

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-26
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	27-178
	1. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	30-84
	2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	84-86
	3. Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	86-91
	4. “Хууль баталсантай холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан/	91-96
	5. “Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан/	96-103
	6. Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр 2020.08.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	103-131
	7. Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	131-154
	8. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	154-157
	9. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	157-164
	10. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	164-178

Хураангуй тэмдэглэл

Нэг.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын ахлах мэргэжилтэн Ш.Цолмон, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Л.Атарцэцэг, Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайхан нар “Их хуралдай” танхимаас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Н.Цогтсайхан, Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Хонгорзул, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар,

мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр “Их хуралдай” танхимаас танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Т.Аубакир, Ж.Ганбаатар, П.Анужин, Т.Аюурсайхан, Д.Ганбат, С.Амарсайхан, Б.Баттөмөр, О.Цогтгэрэл, Б.Энх-Амгалан, С.Ганбаатар, Ц.Анандбазар, Ц.Мөнх-Оргил, Ж.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Л.Атарцэцэг, Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайхан нар “Их хуралдай” танхимаас хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын “гэж” гэсний дараа “эрүү, иргэн, захиргаа зэрэг” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “хэргийн” гэсний дараа “зэрэг” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 13
Бүгд: 62
79.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “дөрвөн” гэснийг “хоёр” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 14
Бүгд: 62
77.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсгийн “сонгосон” гэсний дараах “шүүгч” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 11
Бүгд: 62
82.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 20 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 20.13 дахь хэсэг нэмэх:

“20.13.Энэ хуулийн 20.2.3-т заасан тайланг Нийт шүүгчийн чуулганаар сонсохдоо хэлэлцүүлэг явуулахгүй бөгөөд дүгнэлт, шийдвэр гаргахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	48
Татгалзсан:	14
Бүгд:	62

77.4 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.9.Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар гаргасан албан ёсны тайлбар, Улсын дээд шүүхээс хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад ач холбогдолтой гэж үзсэн шийдвэрийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтэлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	52
Татгалзсан:	10
Бүгд:	62

83.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 24 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 24.5 дахь хэсэг нэмэх:

“24.5.Шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй хэрэг, маргааны талаар сургалтын хөтөлбөр, арга зүйд тусгахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	52
Татгалзсан:	10
Бүгд:	62

83.9 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.8.8 дахь заалт нэмэх:

“25.8.8.улс төрийн намын бүртгэл хөтлөх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	54
Татгалзсан:	8
Бүгд:	62

87.1 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн “тухай саналыг Ерөнхийлөгчид, Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулах тухай албан бичгийг Улсын Их Хуралд холбогдох баримт бичгийн хамт хүргүүлнэ” гэснийг “саналыг, Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулснаар томилуулах саналыг Ерөнхийлөгчид хүргүүлнэ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 11
Бүгд: 63
82.5 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Дээрх 8 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 36.2, 36.3 дахь хэсэг болгох:

“36.2.Улсын Их Хурал Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 104 дүгээр зүйлд заасан журмын дагуу танилцана.

36.3.Ерөнхий зөвлөл энэ хуулийн 36.2-т заасны дагуу Улсын Их Хурал танилцсан нэр дэвшигчийг долоо хоногийн дотор Улсын дээд шүүхийн шүүгчээр томилуулах саналыг Ерөнхийлөгчид хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 9
Бүгд: 63
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төслийн 46 дугаар зүйлийн гарчгийн “Шүүгчийн” гэсний өмнө “Шүүх,” гэж нэмж, 46.5 дахь хэсгийн “хүндэтгэлийн” гэснийг “хүндэтгэл, энэ хуулийн 15.6-д заасны дагуу томилолтоор ажиллах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 12
Бүгд: 64
81.3 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төслийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 46.7 дахь хэсгийн “журам, шалгуур үзүүлэлтийг” гэснийг “шалгуур үзүүлэлт, шүүгчид нэмэгдэл урамшуулал олгох журмыг” гэж өөрчлөх:

“46.2.Шүүгчийн цалин хөлс нь албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн албанд ажилласан хугацааны, докторын зэргийн нэмэгдлээс бүрдэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа үг хэлэв.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 22
Бүгд: 64
65.6 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Дээрх 11 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 47 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 14
Бүгд: 64
78.1 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Төслийн 48 дугаар зүйлийн 48.2.1 дэх заалтын “өв залгамжлагчид” гэснийг “гэр бүлд” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 48.9 дэх хэсэг нэмэх:

“48.9.Шүүгчийг өндөр насны тэтгэвэрт гарахад түүний авч байсан сарын дундаж цалингийн хэмжээгээр 36 сарын хугацаагаар тооцож нэг удаагийн тэтгэмж олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан үг хэлэв.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 22
Бүгд: 64
65.6 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Төслийн 50 дугаар зүйлийн 50.8 дахь хэсгийн “тухайн шүүгчийг оролцуулан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 10
Бүгд: 64
84.4 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Төслийн 58 дугаар зүйлийн 58.1.6 дахь заалтын “51.1.23” гэснийг 58.1.7 дахь заалтад шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 11
Бүгд: 64
82.8 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Төслийн 77 дугаар зүйлийн 77.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“77.10.Ерөнхий зөвлөлийн шүүгч биш гишүүний албан тушаалын зэрэг зиндаа, цалин хөлс, нэмэгдлийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 11
Бүгд: 64
82.8 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Төслийн 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсгийн “дийлэнх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 13
Бүгд: 64
79.7 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Төслийн 96 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 96.21 дэх хэсэг нэмэх:

“96.21.Сахилгын хорооны төсвийг боловсруулж батлахад энэ хуулийн 46.8-д заасан журмыг баримтална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 11
Бүгд: 64
82.8 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Төслийн 98 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 98.4, 98.5 дахь хэсэг нэмэх:

“98.4.Сахилгын хорооны гишүүн энэ хуулийн 44.2-т заасан этгээдтэй уулзсан, харилцсан бөгөөд уг этгээд өөрөө, эсхүл бусдаар дамжуулан аливаа хэлбэрээр нөлөөлсөн, нөлөөлөхөөр оролдсон, үүрэг, чиглэл өгсөн бол энэ талаарх мэдээллийг агуулсан тэмдэглэл үйлдэн Сахилгын хороонд битүүмжлэн ажлын гурван өдрийн дотор хүргүүлэх үүрэгтэй.

98.5.Сахилгын хороо энэ хуулийн 98.4-т заасны дагуу битүүмжлэн ирүүлсэн тэмдэглэлийг хадгалах бөгөөд Сахилгын хорооны гишүүний өөрийнх нь, эсхүл эрх бүхий байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдэд гарган өгнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 10
Бүгд: 64
84.4 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Төслийн 84 дүгээр зүйлийн 84.9 дэх хэсгийн, 99 дүгээр зүйлийн 99.6 дахь хэсгийн “106.1.1-106.1.4-т заасан эрхийг эдэлнэ” гэснийг “103.1.1, 103.1.2-т заасан эрх эдэлж, 103.2-т заасан үүргийг биелүүлнэ” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 9
Бүгд: 64
85.9 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Төслийн 100 дугаар зүйлийн гарчгийн “гишүүнийг” гэсний дараа “чөлөөлөх,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 100.1 дэх хэсэг нэмэх:

“100.1.Сахилгын хорооны дарга, гишүүнийг дараах үндэслэлээр үүрэгт ажлаас нь чөлөөлнө:

100.1.1.бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон;

100.1.2.өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн, эрүүл мэндийн байдал, бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;

100.1.3.өөрөө хүсэлт гаргасан.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 7
Бүгд: 64
89.1 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Төслийн 103 дугаар зүйлийн 103.2.2, 103.2.4 дэх заалтын “Сахилгын хорооны” гэснийг, мөн зүйлийн 103.2.3 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 10
Бүгд: 64
84.4 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Төслийн 105 дугаар зүйлийн 105.2 дахь хэсгийн “энэ хуулийн 105.1-д зааснаас бусад тохиолдолд” гэснийг хасаж, 105.4 дэх хэсгийн “энэ хуулийн 105.2, 106.11-д зааснаас” гэснийг “сахилгын хэрэг үүсгэх тухай болон Сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамжаас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 9
Бүгд: 64
85.9 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Төслийн 106 дугаар зүйлийн 106.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 106.13 дахь хэсэг нэмэх:

“106.6.Илтгэгч гишүүн дараах үндэслэлээр сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг захирамж гарган түдгэлзүүлнэ:

106.6.1.сахилгын хэргийн оролцогч хүнд өвчний учир эмчлүүлж байгаа бөгөөд төлөөлөгч томилох боломжгүй;

106.6.2.сахилгын хэрэг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэсэн;

106.6.3.энэ хуулийн 107.7-д заасан ажиллагаа явуулж байгаа;

106.6.4.холбогдох шүүгчид үүсгэсэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхээс өмнө сахилгын хэргийг хянан шийдвэрлэх боломжгүй;

106.6.5.энэ хуулийн 109.1-д заасан ажиллагаа явуулж байгаа.”

“106.13.Энэ хуулийн 106.6-д заасан түдгэлзүүлсэн үндэслэл арилсан бол илтгэгч гишүүн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 9
Бүгд: 64
85.9 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Төслийн 108 дугаар зүйлийн 108.3 дахь хэсгийн “баталгаажуулна.” гэснийг “баталгаажуулах, эсхүл хуульд заасны дагуу цахим хэлбэрээр өгч болно.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 13
Бүгд: 64
79.7 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Төслийн 116 дугаар зүйлийн 116.4 дэх хэсгийн “эсэргүүцлийг” гэсний дараа “танхим харгалзахгүйгээр” гэж нэмж, 116.7 дахь хэсгийн “татгалзлын үндэслэл, шүүхэд гаргаж өгсөн нотлох баримтыг шинжлэх” гэснийг “татгалзлыг хянан үзэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 10
Бүгд: 64
84.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Найруулгын шинжтэй саналын томьёолол:

Г.Занданшатар: 1.Төслийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийн “оролцох,” гэсний дараа “тухайлсан” гэж, 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсгийн “цалин” гэсний дараа “хөлс” гэж, 107 дугаар зүйлийн 107.16.1 дэх заалтын “үүргээ” гэсний өмнө “албан” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.11 дэх хэсгийн “уламжилж, батлуулна” гэснийг “уламжилна.” гэж, 12 дугаар зүйлийн 12.5, 12.6 дахь хэсгийн “хүн, хуулийн этгээдийн” гэснийг “байгууллага, хувь хүний” гэж, 15 дугаар зүйлийн 15.4, 15.5 дахь хэсгийн “түүнийг” гэснийг “түүний албан үүргийг” гэж, “орлоно” гэснийг “орлон гүйцэтгэнэ” гэж, 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалтын “бүрэлдэхүүнд орох шүүгчийг” гэснийг “шүүгч гишүүнийг” гэж, 20.12 дахь хэсгийн “сонгох бөгөөд даргыг” гэснийг “сонгож, Комиссын даргыг” гэж, 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсгийн “ёсоор” гэснийг “бичгээр” гэж, 36.8 дахь хэсгийн “шүүгчид нэр дэвшээгүй” гэснийг “шүүгчийг сонгоогүй” гэж, 40 дүгээр зүйлийн 40.2.3 дахь заалтын “өөрийн хүсэлтээр энэ хуулийн 39.1-д зааснаас” гэснийг “Ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны гишүүнээр сонгогдсоноос” гэж, 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсгийн “аль нэг намаас” гэснийг “нам, эвслээс” гэж, 64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсгийн “системийн тусламжтайгаар” гэснийг “цахимаар эрэмбэлэн” гэж, 64.3 дахь хэсгийн “системд” гэснийг “цахимаар” гэж, 75 дугаар зүйлийн 75.1.1 дэх заалтын “нэгтгэн Засгийн газартай зөвшилцөн Улсын Их Хуралд уламжлах” гэснийг “энэ хуулийн 46.8-д заасан журмын дагуу хүргүүлэх” гэж, 78 дугаар зүйлийн 78.17 дахь хэсгийн “тогтоол” гэснийг “шийдвэр” гэж, 78.4.1 дэх заалтын “шаардлагыг” гэснийг “баримт бичгийн бүрдүүлбэрийг” гэж, 87 дугаар зүйлийн 87.1.3 дахь заалтын “хөдөлмөр, зохион байгуулалт,” гэснийг “хөдөлмөрийн” гэж, 104 дүгээр зүйлийн 104.1 дэх хэсгийн “Сахилгын зөрчил гарсан” гэснийг “Шүүгчийг сахилгын зөрчил гаргасан” гэж, 107 дугаар зүйлийн 107.10 дахь хэсгийн “баримт нотлох чадвараа алдах” гэснийг “баримтад тооцохгүй” гэж, 115 дугаар зүйлийн 115.4 дэх хэсгийн “шүүгчид” гэснийг “гишүүнд” гэж, төслийн “шүүгч биш гишүүн” гэснийг “шүүгч бус гишүүн” гэж тохиолдол бүрд өөрчлөх.

3.Төслийн 30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсгийн “ажиллах” гэснийг, 32 дугаар зүйлийн 32.2.1 дэх заалтын “өөрийн хүсэлтээр” гэснийг, 34 дүгээр зүйлийн 34.7.3 дахь заалт, 34.12 дахь хэсгийн “хөндлөнгийн” гэснийг, 57 дугаар зүйлийн 57.5 дахь хэсгийн “сургалтад суух” гэснийг, 45 дугаар зүйлийн 45.8 дахь хэсгийн “бүхий л” гэснийг, 73 дугаар зүйлийн 73.1.1 дэх заалтын “хангалтыг зохион байгуулах,” гэснийг, 74 дүгээр зүйлийн 74.1.1 дэх заалтын “тодорхой” гэснийг, 75 дугаар зүйлийн 75.2 дахь хэсгийн “байнгын болон нүүдэллэн ажиллах” гэснийг, 84 дүгээр зүйлийн 84.1.3 дахь заалтын “болон өөр ажил, албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	52
Татгалзсан:	11
Бүгд:	63

82.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй санал:

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.2 дахь хэсэг нэмэх:

“4.2.Шүүх нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн тухай маргаантай асуудлыг болон Засгийн газрын улс төрийн шийдвэрийг хянан хэлэлцэхгүй.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 12
Бүгд: 63
81.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

**Нэг.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл:**

Г.Занданшатар: Төслийн 4 дүгээр зүйлийн “олгохгүй.” гэж,” гэсний дараа “119 дүгээр зүйлийн 119.3 дахь хэсэг, 167 дугаар зүйлийн 167.4 дэх хэсгийн “7” гэснийг “14” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 10
Бүгд: 63
84.1 хувийн саналаар дэмжигдлээ.

**Хоёр.Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төсөл:**

Г.Занданшатар: Төслийн 1 дүгээр зүйлийн ““Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 59.1.5-д заасан үндэслэлээр огцруулсан, 59.6-д заасны дагуу огцорсонд тооцсон,” гэснийг “шүүгч Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан огцруулах сахилгын шийтгэл хүлээсэн, эсхүл огцорсонд тооцогдсон,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 9
Бүгд: 62
85.5 хувийн саналаар дэмжигдлээ.

**Гурав. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай
хуулийн төсөл:**

Г.Занданшатар: Төслийн 1 дүгээр зүйлийн “тайлбар” гэснийг “мэдүүлэг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 7
Бүгд: 62
88.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Монгол Улсын шүүхийн тухай хууль
/Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай
хуулийн төсөл:

Г.Занданшатар: 1.Төслийн 7 дугаар зүйлийн “томилогдсон” гэсний дараа “шүүгчийн бүрэн эрхийг энэ хууль хөндөхгүй бөгөөд” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 6
Бүгд: 62
90.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 46.2-т заасан нэмэгдлийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан үг хэлэв.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 7
Бүгд: 62
88.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 12 дугаар зүйлийн “49.7 дахь” гэснийг “48.9 дэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 8
Бүгд: 62
87.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төсөлд доор дурдсан агуулгатай 15 дугаар зүйл нэмэх:

“15 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болж дагаж мөрдөхөөс өмнө Улсын дээд шүүхэд хяналтын журмаар гомдол, эсэргүүцэл гаргасан хэрэг, маргаанд Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 25.7.5 дахь заалт хамаарахгүй бөгөөд хэрэг, маргааныг Монгол Улсын шүүхийн тухай хууль

/Шинэчилсэн найруулга/, энэхүү хуультай холбогдуулан баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө дагаж мөрдөж байсан хуулиар хянан шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 9
Бүгд: 61
85.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төсөлд доор дурдсан агуулгатай 16 дугаар зүйл нэмэх:

“16 дугаар зүйл.2012 оны 3 дугаар сарын 07-ны өдөр баталсан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 23.2-т заасан бүх шатны шүүхийн шүүгчийн цалингийн нэмэгдэлтэй холбогдох заалтыг 2021 оны төсвийн жил дуусах хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 7
Бүгд: 61
88.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын ахлах мэргэжилтэн Ш.Цолмон, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Л.Атарцэцэг, Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайхан нар “Их хуралдай” танхимаас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Н.Цогтсайхан, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх

Б.Хонгорзул, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар цахимаар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Байнгын хорооноос гаргасан горимын саналаар санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Г.Занданшатар: Байнгын хорооноос гаргасан, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулъя гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	43
Татгалзсан:	18
Бүгд:	61

70.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын ахлах мэргэжилтэн Ш.Цолмон, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Л.Атарцэцэг, Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайхан нар “Их хуралдай” танхимаас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Н.Цогтсайхан, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Хонгорзул, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын

хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг “Их хуралдай” танхимаас танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Ц.Даваасүрэн нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, С.Бямбацогт нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Байнгын хорооноос гаргасан горимын саналаар санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Г.Занданшатар: Байнгын хорооноос гаргасан, Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулъя гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	46
Татгалзсан:	16
Бүгд:	62
74.2 хувийн саналаар дэмжигдлээ.	

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 59 минут үргэлжилж, 74 гишүүнээс 68 гишүүн хүрэлцэн ирж, 91.9 хувийн ирцтэйгээр 13 цаг 01 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 11 минутад эхлэв.

Чөлөөтэй: Х.Булгантуяа, Л.Оюун-Эрдэнэ, Д.Өнөрболор, Ш.Раднаасэд, Ч.Хүрэлбаатар, У.Хүрэлсүх;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Учрал;

Тасалсан: А.Адъяасүрэн, Б.Бейсен, Г.Ганболд, Н.Ганибал, Н.Наранбаатар, Г.Тэмүүлэн;

Хоцорсон: Т.Аюурсайхан-1 цаг 15 минут, Х.Болорчулуун-1 цаг 45, Д.Ганбат-40 минут, Х.Нямбаатар-40 минут, Ц.Цэрэнпунцаг-40 минут, Б.Энх-Амгалан-2 цаг.

Дөрөв. “Хууль баталсантай холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын ахлах мэргэжилтэн Ш.Цолмон, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Л.Атарцэцэг, Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайхан нар “Их хуралдай” танхимаас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Н.Цогтсайхан, Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Хонгорзул, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа “Их хуралдай” танхимаас танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Д.Тогтохсүрэн, Б.Жаргалмаа нарын тавьсан асуултад Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Л.Атарцэцэг нар “Их хуралдай” танхимаас хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Г.Занданшатар: “Хууль баталсантай холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	35
Татгалзсан:	28
Бүгд:	63
55.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.	

Уг асуудлыг 14 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын ахлах мэргэжилтэн

Ш.Цолмон, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Л.Атарцэцэг, Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайхан нар “Их хуралдай” танхимаас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Д.Лүндээжанцан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Н.Цогтсайхан, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Хонгорзул, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, С.Амарсайхан, С.Одонтуяа нарын тавьсан асуултад Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нар “Их хуралдай” танхимаас хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Г.Занданшатар: “Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	40
Татгалзсан:	24
Бүгд:	64
62.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.	

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн батлахтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр санал хэлэв.

Ажлын хэсгээс гаргасан саналтай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д заасны дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж ирэх чиглэл өгөв.

Уг асуудлыг 14 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Дэлгэрэнгүй тэмдэглэл

Нэг.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр танилцуулна.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын эрхэм дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2021 оны 1 дүгээр сарын 7, 8-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийг гүйцээн боловсруулах чиглэлийг хуралдаан даргалагчаас өгсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан 2 санал хураасан бол хуулийн төслийн зарим заалтаар дахин санал хураах шаардлагатай гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд үзсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёрын саналаар санал хураалт явуулж зарчмын зөрүүтэй саналыг шийдвэрлэсэн болно.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд дэмжигдсэнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай, “Хууль баталсантай холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг тус тус боловсруулан хэлэлцүүллээ.

Түүнчлэн нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган, төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, Байнгын хорооны танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Шүүхийн захиргааны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны

ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хууль шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдийн нэрийг танилцуулъя. Лхүндэвийн Атарцэцэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн. Цэндийн Цогт Улсын дээд шүүхийн шүүгч, Барсүрэнгийн Баасандорж Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Пүрэвжавын Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Одонхүүгийн Мөнхсайхан Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн ухааны доктор, Шагдарсүрэнгийн Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу, Сайнхүүгийн Ганбаатар гишүүнээр тасаллаа. Цахимаар асуултын нэрсийг Ц.Батбаатар дарга нэгтгээд танилцуулна.

Эрхэм гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Гишүүддээ шинэ өглөөний мэнд хүргэе.

Шүүхийн тухай хууль дээр ажлын хэсэг, ажлын дэд хэсэг их олон хоног маш сайн ажиллаж байгаа гэдгийг би бас зориуд хэлмээр санагдаж байгаа юм.

Энэ Шүүхийн тухай хууль 2020 оны 4 сард өргөн баригдаад, түүнээс хойш хоёр парламент дамжаад, хоёр чуулган дамжаад ингээд хэлэлцэгдээд явж байгаа ийм хууль.

Сүүлийн үед бас энэ хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүхтэй холбоотой, Шүүхийн хуультай холбоотой асуудлаа нэг буруу ташаа ойлголт яваад байгаа юм.

Ерөнхийлөгчийн эрх мэдлийг булааж авч байна. Улсын Их Хурал. Ялангуяа Улсын Их Хурал дахь олонх гэдэг нэг ийм юм бас яригдаад байгаа юм. Бид өнгөрсөн онд нэмэлт, өөрчлөлт хийсэн. Үндсэн хуулиараа шүүхийн тухай өөрчлөлт нь дотроо энэ шүүхийг хараат бус болгохтой холбоотой

асуудлыг оруулсан юм. Тэгээд Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийн дагуу л хийгдэж байгаа зүйл.

Ер нь өнөөдөр Шүүхийн тухай хуулиар шүүхийг яаж хараат болгох вэ, хараат бус болгох вэ. Шүүхийг яаж хариуцлагатай болгох вэ, шүүгчийг гэдэг ийм л асуудлыг л энэ хуульд тодорхой зааж өгсөн байгаа.

Тийм учраас би энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу хийгдэж байгаа ийм томоохон эрх зүйн шинэчлэл юм гэдгийг би хэлье гэж ингэж бодож байгаа юм.

Асуулт нэг зүйл байна. Ажлын хэсэг бодвол ярилцсан болов уу гэж бодож байна. 2013 онд билүү, 2014 онд шүүгч нарыг чөлөөлөөд буцаагаад томилогдоход 17 шүүгчийн асуудал байдаг юм. Томилогдоогүй. Үлдчихсэн. Тэр томилогдоогүй үлдсэн шүүгчдийн асуудлыг ер нь ажлын хэсэг ярилцсан уу? Цаашдаа энэ хуульд болон хууль дагаж байгаа энэ журмуудад, тогтоолуудад тэр 17 шүүгчтэй холбоотой асуудал ер нь.../минут дуусав/

Г.Занданшатар: Д.Тогтохсүрэн гишүүнд 1 минут нэмж өгье.

Д.Тогтохсүрэн: Бодвол ажлын хэсэг дээр би ярьсан болов уу гэж ингэж бодож байна.

Нөгөө талаас нь Шүүхийн ерөнхий зөвлөл. Энэ чинь эцсийн хэлэлцүүлэг болчихоод байгаа юм.

Ер нь тэгээд мэдээж нөгөө томилдог субъект 2017 онд өөрчлөгдсөн. Сонгуулиар. Ерөнхийлөгч. Тэрний дараа тэр 17 шүүгчийн асуудлыг дахиж Шүүхийн ерөнхий зөвлөл ярьж, Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх ийм оролдлого хийсэн байдаг юм болов уу, үгүй юм болов уу гэдгийг би бас тодруулъя гэж бодож байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар гишүүн хариулна.

Х.Нямбаатар: 2013 онд Шүүхийн багц хууль батлагдсантай холбогдуулж тухайн үед ажил үүргээ гүйцэтгэж байсан бүх шүүгчдийг нэг өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар чөлөөлж, буцааж томилохдоо 13 шүүгчийг эргүүлж томилоогүй ийм зүйл болсон.

Энэ бол тухайн үед хуульчид, шүүгчид юу гэж харж байсан бэ гэвэл бусад шүүгчдэд тийм дохио санамж өгөх зорилгоор ийм үйлдэл хийлээ гэдэг ийм зүйлүүд явагдсан.

Эдгээр шүүгчид эргэж томилогдох хүсэлтээ Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, Захиргааны хэргийн шүүхүүдэд удаа дараа хандсан. Аль ч байгууллагууд нь асуудлыг шийдвэрлээгүй орхисон.

Сая бид бүхэн ажлын хэсэг дээр ярилцаад Шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх хуульдаа нэг зүйл оруулаад энэ 13 шүүгчийг энэ хуулийн дагуу шинээр байгуулагдах Шүүхийн ерөнхий зөвлөл дахин томилуулахаар Монгол Улсын

Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх ёстой гэсэн ийм заалт оруулъя гээд миний бие санал хураалгасан.

Харамсалтай нь ажлын хэсэг дээр болон Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдаан дээр энэ санал дэмжигдээгүй явчихсан байгаа. Тэгээд одоо энэ хүмүүст ерөөсөө дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу байгаа. Үүнийг бас хөндөж ярьж байгаа Д.Тогтохсүрэн даргад баярлалаа.

Тэгээд энэ асуудлыг бид уг нь нэг мөр шийдчихмээр байгаа юм. Энэ хүмүүс Монгол Улсын хууль, шүүхийн бүхий л тогтолцоонд хандаад үзчихсэн. Тийм.

Тэгэхээр ажлын хэсэг дээр юу гэж ярьсан бэ гэвэл цэц дээр энэ асуудлыг Их Хурлын нэр бүхий гишүүд хандъя. Тэгээд цэц шийдвэр гаргаад одоо байгаа Ерөнхийлөгчид энэ цэцийн дүгнэлтээр энэ шүүгч нарыг томилуулахыг даалгая гэсэн ийм процесс явуулъя гэж яриад олонхын санал авч дэмжигдэлгүйгээр орхичхоод байгаа.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн. Байнгын хороо, ажлын хэсэг.

Б.Энхбаяр: Баярлалаа.

2013 онд 13 шүүгч Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар чөлөөлөгдөхдөө Монгол Улсын Үндсэн хуульд заасан, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдөөгүй юм. Өөрөөр хэлбэл тэдгээр 13 шүүгчийг чөлөөлсөн Ерөнхийлөгчийн зарлигт хууль зүйн үндэслэл байгаагүй.

Тэр утгаараа энэ бол Монгол Улсын Үндсэн хууль Ерөнхийлөгч зөрчлөө гэдэг агуулгаар тухайн үед миний бие иргэнийхээ хувьд энэ 13 шүүгчийг чөлөөлсөн Ерөнхийлөгчийн зарлиг Үндсэн хууль зөрчсөн бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хууль зөрчсөн асуудлаар цэцэд бас хандаж байсан тэр иргэн нь бол би байгаад байгаа юм.

Тэгээд Үндсэн хуулийн цэц маргаан үүсгээгүй. Үндсэн хууль зөрчөөгүй гэж Ерөнхийлөгчийг хамгаалж хаацайлсан. Миний хувьд Үндсэн хууль зөрчсөн гэдэг итгэл үнэмшил маань одоо хүртэл байдаг. Тэгэхдээ үүнийг залруулах ажиллагаа мөн Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд явагдах учиртай.

Тэр ч утгаараа Х.Нямбаатар гишүүний саналыг ажлын хэсэг дээр хүлээж аваагүй. Яагаад гэхээр хууль гаргаж Улсын Их Хурал шүүгчдийг томилохгүй. Тэгвэл Улсын Их Хурал өөрөө бас Үндсэн хууль зөрчинө. Шүүгчдийг томилох эрх зөвхөн Ерөнхийлөгчид байгаа.

Тэр утгаараа миний хувьд Байнгын хороон дээр гарц шийдлээ хэлсэн. Өөрөөр хэлбэл асуудлыг Үндсэн хуулийн хүрээнд шийдэж болох шийдэл байна. Тухайлбал, 34 дүгээр зүйлийн 2-т Ерөнхийлөгчийн зарлиг хуульд нийцээгүй бол Улсын Их Хурал хүчингүй болгоно гэж байгаа.

Өөрөөр хэлбэл, энэ асуудал нэгэнт Үндсэн хууль, хууль зөрчсөн гэж Улсын Их Хурал үзэж байгаа тохиолдолд 2013 оны тухайн шүүгчдийг чөлөөлсөн Ерөнхийлөгчийн зарлигийг хүчингүй болгох буюу тэдгээр шүүгчдийн эрхийг сэргээх боломж Улсын Их Хуралд байгаа.

Тийм учраас үүнийг шийдэх хууль зүйн гарц байгаа гэж үзэж байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Цахимаар асуулт асуух гишүүдийн нэрс.

Тилеуханы Аубакир гишүүн.

Т.Аубакир: Баярлалаа. Өглөөний мэнд хүргэе ээ.

Ажлын хэсгээс нэг асуулт байна. Нийгэмд бас асуулт хэвээрээ үлдэх гээд байгаа нэг зүйл байна. Яагаад гэхээр энэ шүүгчдийн эдийн засгийн баталгааны асуудал болсон цалин хөлсний асуудал яасан бэ гээд бас мессеж ч ирэх юм. Хэрвээ үнэхээр өмнөх байдлаасаа хэрвээ цалин хөлсний асуудалд орчихсон бол энэ маань одоо яг эцсийн хэлэлцүүлэг дээр яаж орж ирж байгаа вэ?

Яагаад гэх юм бол бас нэг ойлголт байдаг шүү дээ. Шүүгчдийн цалинг бас цалин гэж үзэхгүй байх. Үүнийг нь нөхөн олговор хэмжээнд үздэг. Яагаад гэвэл жирийн иргэдийг бодох юм бол шүүгчид маань маш олон эрхээ хязгаарлуулсан байдаг учраас үүнийг нь нөхөн олговор хэлбэрээр өгдөг. Эдийн засгийн баталгааг нь сайжруулах үүднээс гэж.

Тийм учраас өмнөх байдлаасаа хэрвээ цалин хөлснийх нь асуудал буурсан бол өмнөх шиг нь хэвээр нь үлдээх бололцоо бий юу гэсэн товчхон асуулт байна.

Дараа нь тодруулга байгаа шүү, дарга аа. Б.Энхбаяр гишүүнээс асууя.

Г.Занданшатар: С.Бямбацогт дарга. Байнгын хороон дарга.

Байнгын хороон дээр энэ асуудал яригдсан.

С.Бямбацогт: Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсөлд шүүгчдийн цалинтай холбоотой асуудал орж ирсэн.

Онцгой нөхцөлийн нэмэгдэл, зэрэг дэвийн нэмэгдэл, төрийн албанд ажилласан удаан хугацаагаар ажилласан жилийн нэмэгдэл гэсэн нэмэгдлүүд орж ирсэн.

Энэ дээр ажлын хэсэг маань ярьж байгаад зэрэг дэвийн нэмэгдлийг шүүгч нар ялгаварлах юм. Тийм болохоор боломжгүй юм байна гэдэг байдлаар хассан юм билээ. Бусад нэмэгдлүүдийг нэмэгдүүлж олгоё. Гэхдээ онцгой нөхцөлийн нэмэгдэл 25 хувиар олгодог байсан бол 40 хувь болгож нэмэгдүүлье. Ингэж бас нэг цалин буурах гээд байгаа нөхцөл байдлыг

сайжруулж цалин бууруулахгүй байх ийм хэмжээний зохицуулах заалтыг өчигдөр Байнгын хороон дээр ярьж дэмжигдсэн.

Ер нь урьд нь анхны хэлэлцүүлгээр орж ирсэн. Чуулганы хуралдаан дээр унасан. Цалингийн нэмэгдлүүд. Яагаад унасан бэ гэхээр нийгэмд шүүгчдийн цалинтай холбоотой буруу зөрүү ойлголтууд нэлээн бий болсон. Үүнтэй холбоотойгоор үүссэн. Хамгийн өндөр цалин авдаг. 8 сая төгрөгийн цалин авдаг. 11 сая төгрөгийн цалин авдаг гэдэг асуудлууд яригдаад. Тийм болохоор нэмэгдлүүд олгох нь зөв үү, буруу юу гэдэг байдлаар энэ нэмэгдлүүд унасан байсан. Байнгын хороон дээр ярьсан.

Үүнтэй холбоотой бас тодруулсан. Одоо бол анхан шатны шүүхийн шүүгчийн цалин бол яг гар дээр нь 2 сая 200 мянган төгрөгийн цалин авдаг. Давахын шүүгч бол 3 сая орчим төгрөгийн цалин авдаг. Дээд шүүхийн шүүгч буюу хяналтын шатны шүүгч 4 сая орчим төгрөгийн цалин авдаг юм билээ.

Ийм цалинтай байж байхад нь одоо бас хэт их цалин авдаг. 8 сая, 11 сая байдлаар буруу ойлголт үүсээд үүнээс болоод Байнгын хороон дээр унасан. Энэ удаа үндсэндээ шүүгч нар цалингуудаа, үндсэн цалингаа авна.

Дээрээс нь саяын ярьдаг онцгой нөхцөлийн нэмэгдэл. Дээрээс нь төрд ажилласан жилийн хугацааны нэмэгдэл. Дээрээс нь докторын нэмэгдэл гэсэн нэмэгдлүүд авахаар болж байгаа. Ингэснээрээ шүүгч нарын цалин буурахгүй хэвийн хэмжээнд хадгалагдах бололцоо үүсэж байгаа.

Ер нь бид шүүгч нартаа цалинг нь боломжийн хэмжээнд өгч байж шударга ёс тогтоо, шударга, хараат бусаар ажилла гэсэн шаардлага тавина.

Г.Занданшатар: Тэгээд өчигдөр Байнгын хороон дээр энэ Цэндийн Цогт шүүгч ярьж байсан л даа.

Нөгөө хуралдаан дээр яригдсантай холбогдуулаад. Хамгийн өндөр цалин авч байгаа, 35 жил ажиллаж байгаа шүүгч 5 сая 200 мянга гэсэн байх аа. 4 сая 200 мянга. Тэгээд бүх нэмэгдэлтэйгээ 5 сая 200 хүрч байна.

Шүүгчийн цалин 2 сая 700 мянгаас эхэлж байна гэж ярьж байсан. Листээрээ 6 сая 738 гэж байна. Яах вэ, хамгийн өндөр нь байх.

Тэгэхдээ Үндсэн хуулийн 48.2-т байхаа. 48.2-т шүүх улсын төсвөөс санхүүжнэ. Шүүхийн эдийн засгийн баталгааг төрөөс хангана гэсэн ийм заалт бий. Энэ утгаараа шүүх бие даан үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангах ёстой. Энэ дотор шүүгчийн бие даасан үйл ажиллагаа бас хамаарна. Тэгээд үүнтэй холбогдолтой санал хураалт явагдана гэж ойлгож байгаа. Тэр үед ярилцъя.

Дараа нь Жамбалын Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Би энэ хуулийн зорилго, зорилтыг хуулиас хараад шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, шүүгчид тавих болзол, шаардлага, эрх зүйн байдал, шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах,

холбогдох байгууллагуудын эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулна гэж. Байнгын хороон даргад тавьсан байгаа. Тийм ээ. Энэ бол хуулийн гол зорилго.

Гэтэл одоо энэ хэлэлцүүлгийн явцад болохлоор. Сая ч гэсэн. Тийм ээ. Ерөөсөө томилгоо болоод цалин хөлстэй холбоотой асуудал хэт давамгайлсан байдлаар зааланд яригдаж байгаа нь хуулийн гол зорилго, зорилтыг нийгэмд буруу ойлгуулж байгаа юм. Б.Энхбаяр гишүүн ч гэсэн үүнийг анхаарах хэрэгтэй.

Цалин мөнгөтэй холбоотой юм уу, томилгоотой холбоотой асуудлыг хэтэрхий их давамгайлсан маягаар ярих нь өөрөө хуулийн чинь гол зорилго, зорилтыг хойш нь татаж байгаа шүү.

Уг нь шүүх гуравдагч засаглал. Хараат бус байхыг энэ хуулиар хамгийн гол нь зааж өгч байгаа. Үүний төлөө Шүүхийн ерөнхий зөвлөл, Сахилгын хороо байгуулагдаж байгаа гэдгээ давамгайлсан. Одоо ядаж эцсийн хэлэлцүүлэгтээ үүнийгээ ярь л даа.

Тэгээд л одоо ажлын хэсгийнхэн тойроод л. Эсвэл бүгдээрээ ингээд л заалнаас дээшээ доошоо бүгдээрээ цалингаа л яриад байх юм. Тэгээд энэ чинь хуулийн чинь гол зорилго нь нийгэмд буруу ойлголт түрүүлж байна шүү.

Хэн нэгэн хүн томилдог байсан бол одоо ахиад нэг өөр хүн томилдог болж байгаа юм байна гэдэг ойлголт нийгэмд яваад байна шүү дээ. Тийм ээ. Одоо энэ чинь ингээд булаацалдаад. Томилгоогоо булаацалдаад байна. Цалин мөнгөн дээрээ асуудал үүсээд байна гээд. Би зорилгын чинь, хуулийн чинь гол зорилгыг уншиж өглөө.

Ядаж эцсийн хэлэлцүүлэг дээрээ энэ хуулийнхаа гол зорилгыг яриач ээ. Энэ хуулиар шүүхийг одоо туйлын шударга, тунгалаг, хараат бус болно гэдгийг нийгэм хүлээж байгаа. Ийм ойлголт хүмүүст төрсөн байгаа. Энэ талаараа эцсийн хэлэлцүүлэг дээрээ яриач ээ. Ядаж энэ дэд ажлын хэсгийнхэн тэрийгээ.../минут дуусав/

Г.Занданшатар: Ж.Ганбаатар гишүүн 1 минут тодруулъя.

Ж.Ганбаатар: Харин тийм. Яг л нэг цалин хөлс юм уу, эсвэл нэг томилгоо баталж байгаа юм шиг ойлголт хүмүүст төрөөд байгаа шүү.

Тэгэхлээр хуулийнхаа гол зорилго, зорилт нь дээр нь. Ядаж эцсийн хэлэлцүүлэг дээр нь үүнийгээ тойрч ярихыг би бас уриалж байна. Ядаж хариулж байгаа хүмүүс үүнийгээ анхаараач ээ. Баярлалаа.

Г.Занданшатар: Сая гишүүдийн асуулттай холбогдуулж цалин хөлсний асуудал яригдсан.

Ерөөсөө иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангах тухай, шүүхийн хариуцлага, хараат бус байдлыг хангах тухай эхний хэлэлцүүлгээс

авахуулаад хэлэлцэх эсэх хүртэл байнга ярьж байгаа шүү дээ. Ж.Ганбаатар гишүүн үүнийг буруу ойлгосон байна.

Хууль зүйн байнгын хороон дээр хариулъя. Сандагийн Бямбацогт дарга хариулъя.

С.Бямбацогт: Ер нь ард түмний дунд, за ер нь хаа сайгүй л нэг шударга бус шүүхтэй, хараат шүүхтэй болчихлоо гэж олон жил яригдаж байгаа.

Ерөөсөө л хэн нэгний дохио зангаар хөдөлдөг болчихлоо. Эсвэл авлига, шан харамж авч асуудлыг шийддэг болчихлоо гэж олон жил яригдсан. Үүнийг ч олон улсын байгууллага ч үнэлдэг болчихсон байсан.

Тийм ч учраас бид Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийхдээ шударга, хараат бус хэн нэгнээс тийм үү, хараат бус, шударга шүүхтэй, шүүгчтэй болох асуудлыг Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Энэ хүрээндээ Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Засгийн газар өргөн бариад хоёр гурван парламент амжиж яригдаж байгаа. Одоо орж ирж байгаа асуудал ч гэсэн ерөөсөө яг энэ хүрээнд хийгдсэн. Ажлын хэсэг маш сайн ажилласан.

Шүүхийг яаж шударга болгох вэ гэдэг чиглэлээр, хараат бус болгох вэ гэдэг чиглэлээр Үндсэн хуульд орсон яг тэр агуулга, үзэл баримтлалын хүрээнд томоохон өөрчлөлтүүд, урьд өмнө байгаагүй маш том өөрчлөлтүүд орж ирж байгаа. Орж ирж байгаа.

Тухайлах юм бол шүүгчийг сонгон шалгаруулах, томилохдоо хэн нэгний дохио зангаагаар, хэн нэгний цүнх барьдаг гэдэг асуудлаар нь биш, мэдлэгтэй, чадвартай, үнэхээр хандлага зөв, шударгаар ажиллах чадвар, ур чадварыг нь шалгаруулж хараат бусаар шалгаруулдаг байх.

Шүүгч ажиллахдаа хараат бусаар, хэн нэгний нөлөөнд автахгүй, хэн нэгний дарамт, шахалтад орохгүй, хариуцлагатай, чин шударгаар ажиллах. Ингэж ажиллаж чадахгүй тэр шүүгчид хүлээлгэх хариуцлагыг маш тодорхой оруулж өгч байгаа.

Ийм байдлаар үндсэндээ бид энэ хууль батлагдах юм бол үнэхээр шударга, хараат бус шүүхтэй, шүүгчтэй болох бололцоо бүрдэнэ. Мэдээж хэчнээн сайн хуультай байсан ч гэсэн нөгөө талд нь шүүгч нь бас чадвартай, ажлаа хийх ажил, амьдралын баталгаа нь хангагдсан байх ёстой. Энэ үүднээсээ тэр цалин хөлсний асуудал яригдаж байгаа юм.

Яагаад гэвэл сайн хууль байсан ч сайн хуулийг тэр шүүгч хэрэгжүүлнэ. Шүүгч маань чадвартай, сэтгэлтэй, ажилдаа, амьдралдаа сэтгэл хангалуун байх ёстой. Хэн нэгнээс эдийн засгийн хувьд хараат бус байх ёстой. Энэ үүднээс л асуудал яригдаж байгаа юм л даа. Тэгээд энэ нь жаахан давамгайлж яригдахаар жаахан мушгигдаж яригдаад байх шиг байна.

Г.Занданшатар: Одоо Пүрэв-Очирын Анужин гишүүн асуулт асууна. Цахимаар. 1 минут асуучихсан Ж.Ганбаатар гишүүн.

П.Анужин: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Одоо хэлэлцэгдэж байгаа хуулиас харахад шүүхийн тогтолцоо, тэгээд шүүгчдийг шүүх тогтолцоо зэрэг сайжрах юм байна гэж, сайжрал, бас ахиц гарах юм байна гэж ойлгож байгаа.

Гэхдээ шүүхийн аливаа асуудал нь системийн асуудал гэхээсээ бас хүний асуудал байдаг. Тэгээд энэ дээр юу хүсээд байна вэ гэхээр бодит амьдрал дээр иргэд маргаанаа шийдүүлж чадахгүй цаг хугацаагаар маш их хохирч байна.

Тэгээд Дээд шүүхийн гурван танхимд энэ статистикаас аваад үзэхэд иргэний хэрэг шийдвэрлэх тал дээр бусад танхимтайгаа харьцуулах юм бол гурав дахин илүү ачаалалтай ажилладаг бөгөөд иргэд өөрсдийнхөө эрхийг сэргээлгэж чадахгүй Иргэний танхим дээр нэг аравны таван жил хүлээдэг тухай гомдлууд маш их байна.

Тэгэхээр энэ асуудал хэрхэн сайжрах вэ, энэ тухай тусгасан уу гэдгийг асуух гэсэн юм.

Г.Занданшатар: С.Бямбацогт дарга.

С.Бямбацогт: Шүүгч шийдвэр гаргадаг. Шүүхийн шийдвэрт мэдээж хоёр талаасаа оролцож байгаа бол хэн нэг нь гомдолтой үлддэг. Давж заалддаг. Тэгээд эцэст нь хяналтын шатанд очдог.

Энэ процесс дээр хэрхэн алдаа гарвал яаж засаж залруулах вэ гэдэг асуудлаар ерөөсөө урьд өмнө байгаагүй. Шүүгч нь хэрэг шийдвэрлэдэг. Нөгөө гомдол гаргасан этгээд нь гомдлоо гаргадаг. Гомдол нь явсаар байгаад Дээд шүүхэд очдог. Дээд шүүхээсээ эцэст нь ёс зүйн хороонд шүүгчийг өгдөг. Энэ үндэслэлээ бичээгүй байна.

Эсвэл илтэд хуулийг буруу хэрэглэлээ гэдэг байдлаар ёс зүйн хороонд нь хандахаар тэнд нь шүүгч нар сууж байдаг. Шүүгч нар шийдэхдээ шүүгч нараа хамгаалчихдаг. Ийм бас урьд өмнө ийм тогтолцоо байсан. Энэ тогтолцоог бас эвдэж байгаа энэ хуулиар.

Өөрөөр хэлэх юм бол тэр “Шүүгчийн сахилгын хороо” ажиллана. Яг шүүгч дээр ажиллахдаа үзэмжээр асуудлыг шийдэхгүй. Тодорхой 40 заалтаар яг ийм ийм асуудал алдаа гаргах юм бол ингэж ингэж шийднэ. Энэ гаргасан алдааг тухайн үед нь ярихгүй байсан ч араас нь хөөн хэлэлцэх хугацаатай байна.

Өөрөөр хэлэх юм бол шүүгчийн гаргасан алдаа нь сахилгын хороогоороо тогтоогдох юм бол түүнийг 5 жил хүртэлх хугацаагаар огцруулахтай тэнцэх тийм хариуцлага ногдох ёстой бол түүнийг 5 жилийн хугацаанд хөөн хэлэлцэж хариуцлага тооцно.

Огцруулахаас бусад хариуцлага тооцох заалт дээр 2 жилийн хугацаанд хөөн хэлэлцэж араас нь хөөж хариуцлага тооцно гэдэг заалт орж ирж байгаа.

Өөрөөр хэлэх юм бол өнөөдөр алдаа гаргачхаад, түүнийгээ аргалаад өнгөрөөчихье. Тэгээд явж байтал болох байлгүй гэж бодох бололцоо байхгүй болсон. Алдааг нь араас нь хөөн хэлэлцэж байгаад шийтгэл оногдуулдаг байх ийм заалтууд орж байгаа.

Ингэж байж шүүгч маань шударга, хэн нэгний нөлөөнд автахгүйгээр үнэхээр хуулийг зөв хэрэглэж, шударга шүүх энэ эрхийн баталгааг ингэж л хангах энэ хуульд орж ирж байгаа. Энэ бол маш том ахиц дэвшил, өөрчлөлт гарч ирж байгаа.

Тэр ачаалалтай холбоотой асуудал бол харьцангуй ачааллыг манай ажлын хэсэг дээр нэлээн сайн ярьсан юм байна лээ. Тэгээд ачаалал бол харьцангуй юу гэдэг юм энэ хууль батлагдаад явбал нэлээн боломжийн хэмжээнд шийдэгдэх бололцоотой гэж үзэж байгаа. Б.Энхбаяр гишүүн нэмээд хариулчих уу.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: П.Анужин гишүүнтэй санал нэг байна.

Бид ер нь судалгаа шинжилгээ, өнгөрсөн алдаа сургамж, практик нөхцөл байдалдаа тулгуурлаад ер нь нэг эргэж бухаад хараад байлгүй урагшаа харсан, хөгжил рүү чирсэн хөтөч хийсэн ийм сайн хууль гаргахыг хичээж чармайж байгаа.

Хууль гарах гэдэг нэг хэрэг. Б.Чимид багш хэлсэн байдаг. Хуулийг хүн хэрэгжүүлдэг юм шүү. Шүүгч гэдэг чинь өөрөө ярьдаг хууль шүү гэж.

Үнэхээр энэ хэчнээн сайн хууль байгаад энэ хуулийн шаардлагад нийцэхгүй буюу энэ хөгжил дэвшлийнхээ мөн чанарыг ойлгохгүй, тэгээд өөрийнхөө явцуу сонирхолд хөтлөгдсөн, одоо болж байгаа байдлаа ер нь болж байна, бүтэж байна гэж боддог. Өөрийгөө хөгжүүлж, дэвшүүлэхийг чармайдаггүй ийм шүүгчтэй байх юм бол энэ хуульд ихээхэн саад болно.

Бид бас үүнийг тооцож харж байгаа. Энэ хуулийн сайн үр дүнгүүд ирэх 5-аас 10 жилийн дараа бодитой мэдрэгдэж эхэлнэ. Яагаад. Энэ хуулийн дагуу байгуулагдах хараат бус Шүүхийн ерөнхий зөвлөл, хараат бус Сахилгын хорооны үйл ажиллагааны дагуу шүүгчдийн сахилга хариуцлага чамбайрах ёстой. Чадваргүй, цус ойртсон ийм хүмүүс ер нь нэг шүүгчээр болчихъё, барьчихъя гэдэг тэр бодлоосоо татгалзаж эхэлнэ.

Улсын дээд шүүхийн шүүгчид гэхэд Улсын Их Хурал дээр орж ирж бүх асуудлаа шүүлгэнэ. Өнгөрсөн амьдралаа шүүлгэнэ. Хар бараан юмтай бол тэр хүн өөрөө больё гээд татгалздаг ийм шүүлтүүрээр орж цаашаа.../минут дуусав/

Г.Занданшатар: Пүрэв-Очирын Анужин гишүүн 1 минут тодруулъя.

П.Анужин: Би илүү ачаалал тал дээр нь бас тодорхой хариулт авахыг хүссэн юм.

Дээд шүүхийн гурван танхим, найм, найман гишүүнтэй. Тийм ээ. Тэгээд статистикаас харахад иргэний хэрэг нь гурав дахин давчхаад байна.

Тэгэхээр бид тогтолцооны хувьд сайжруулах тухай ёс зүйн хувьд яриад байгаа ч гэсэн бодит амьдрал дээр иргэд энэ ачаалал нь ямар болох юм бэ? Үүнийг яг энэ хуулиар тодорхой шийдэж өгч чадсан юм уу? Гэр бүл салах гээд л. Одоо гэр бүлээс салах өргөдөл өгчхөөд нэг аравны таван жил байргүй, юу ч үгүй ингээд гудамжинд хохироод байж байгаа эмэгтэйчүүд өчнөөн байна. Дээд шүүхийн шийдвэрийг хүлээгээд.

Тэгэхээр бид энэ хууль дээрээ ёс зүй, тогтолцоогоо яриад байдаг. Энэ хууль чинь энэ хөрсөн дээрээ хүмүүст яаж хэрэгжих юм бэ? Нэг аравны таван жил, нэг аравны долоон жил ингээд хүлээгээд байх юм уу? Энэ найм, найман гишүүдийн чинь энэ тооны хуваарилалтын тогтолцоо нь өөрөө хөрсөн дээрээ хэр бууж байгаа юм бэ гэдэг дээр тодорхой хариулт өгнө үү. Баярлалаа.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт. Хууль зүйн байнгын хорооны дарга.

С.Бямбацогт: Ачаалалтай холбоотой дагаж гарах тогтоол байгаа. Улсын Их Хурлын.

Ер нь Үндсэн хуульдаа шүүхийн шударгаар, хараат бусаар үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана гэсэн Үндсэн хуулийн заалттай. Үүнтэй холбоотойгоор ер нь шүүгчийн ажлын байрны нөхцөл, шүүгчийн шүүх байруудын хангамж, хүрэлцээ үнэхээр сул байдаг юм байна лээ. Үүнтэй холбоотой үүнийг дагаж Их Хурлаас тогтоол гаргаж байгаа. Засгийн газарт чиглэл өгөөд энэ шүүгчийн ажиллах орчин нөхцөл, энэ байр, хангамжийн асуудлыг шийдээрэй, шийдэх ёстой шүү гэсэн ийм чиглэл өгч байгаа.

Энэ хүрээндээ үндсэндээ шүүхийн ажиллах орчин нөхцөл илүү сайжирна гэж үзэж байгаа. Өнөөдөр үнэхээр ачаалал ихтэй. Нэг байран дээр маш их шахалдаж суудаг байдлууд байж байгаа.

Нөгөө талаасаа шүүгч дээр ногдож байгаа хэрэгтэй холбоотой асуудлаар шүүхийн Ерөнхий шүүгчид нь танхим сэлгэж хоорондоо хуваарилж.../минут дуусав/

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Төмөрбаатарын Аюурсайхан.

Т.Аюурсайхан: Шүүхийн хуулиа эцсийн хэлэлцүүлгийг нь хийж байна.

Үндсэн хуулийн өөрчлөлтөөс хойш боловсруулан баталж байгаа томоохон хуулиудын нэг явж байна. Энэ дээр бас нэлээн ахиц дэвшилттэй зүйл, заалтууд байгаа.

Тийм учраас ажлын хэсэг нэлээн сайн ажилласан гэж үзэж байгаа. Зарим нэг асуудлууд дээр Улсын Их Хурал эрхийнхээ хүрээнд шийдвэрүүдийг гаргасан байгаа. Энэ дээр нь тодорхой хэмжээгээр Их Хурлын шийдвэрийн дагуу засаж залруулаад зохих ёсоор ажлын хэсэг дээр санал хураагаад Байнгын хороон дээр шийдсэн байна.

Шүүгч нарын цалинтай холбоотой их зөрүүтэй мэдээллүүд яваад байгаа. Ажлын хэсэг дээр өгсөн мэдээллүүд бас ташаа мэдээллүүд байсан. Авлигатай тэмцэх газар дээр энэ шүүгч нарын хөрөнгө орлогын мэдүүлэг дээр тодорхой мэдүүлгүүд нь байна. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс би одоо өчигдөр мөн албан ёсоор энэ мэдээллүүдийг авлаа.

Тэгэхээр цалин гэж юу юм бэ гэх юм бол үндсэн цалин болон түүний нэмэгдлээс бүрддэг. Гэтэл энэ ажлын хэсэг дээр ярихдаа нөгөө нийгмийн даатгалын шимтгэл, орлого, хөдөлмөрийн хүн амын орлогыг хасаад ийм дүнгээр яриад ийм зөрүүтэй.

Тэгээд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс өгсөн энэ мэдээллээр доод тал нь 2 сая 700 мянга, дээд тал нь 6 сая 731 мянга 628 төгрөг байна.

Тэгээд энэ мэдээллүүдээ албан ёсоор хэлэхгүй бол Улсын Их Хурлын гишүүнийг ташаа мэдээлэл хэлж байна гэж бас Байнгын хороон дээр ярьж болохгүй гэж би бодож байна. Албан ёсны байгууллагуудаас авч. Цалин гэдэг хуулиар тодорхойлсон үндсэн цалин, түүний нэмэгдлээс бүрдэнэ.

1 минутаа авчихъя. Тэгээд энэ дээр ямар ч л байсан төрийн албаны ажилласан хугацааны нэмэгдэл.../минут дуусав/

Г.Занданшатар: Т.Аюурсайхан гишүүнд 1 минут.

Т.Аюурсайхан: Докторын зэргийн нэмэгдэл, онцгой нөхцөлийн нэмэгдэл гээд. Энэ бол төрийн албан хаагч, тусгай албан хаагчид дээр ерөөсөө нийтлэг байдаг нийтлэг юмаа л хийе гэж байгаа юм.

Тэтгэвэр дээр 80 хувиар тогтоолгоно гэж үүнийг зассан. 36 сарын цалинтай тэнцүү нэг удаагийн олговор гэдэг бол бас л төрийн албан хаагч нар дээр байдаг ийм нийтлэг байдлаараа л явах хэрэгтэй.

Тэгэхгүй одоо Боловсролын ерөнхий хууль орж ирнэ. Одоо Эрүүл мэндийн хууль, Нийгмийн даатгал Нийгмийн бодлогын байнгын хороон дээр хэлэлцэгдээд ингээд явж байна.

Тэгээд энэ хууль болгон дээр энэ өөрөөр зохицуулсан юмнууд орж ирвэл энэ тогтолцоо чинь өөрөө буруу явна. Би нэмж болохгүй гээгүй. Нэмэх юм бол нийтлэг байдлаар Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэвэр, тэтгэмжийг хуулиараа энэ 45 хувиа яаж сайжруулах вэ, яаж тооцоог нь илүү болох вэ гэдгийг нийтлэг байдлаар шийдэх ёстой. Үүнийгээ хаа хаанаа ойлгох ёстой шүү.

Яг бодит байдлаар ийм асуудал орж ирсэн. Их Хурал зассан. Ажлын хэсэг засаад, Байнгын хороо зассан байна. Тэгээд үүнийг хэлье.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт дарга. Хууль зүйн байнгын хороон дарга асуултад хариулна.

С.Бямбацогт: Тэгэхээр шүүгчийн цалинтай холбоотой асуудал ер нь байнга л, хэдэн жилийн өмнөөс л яригдаж эхэлсэн л дээ.

Тэгээд ерөөсөө иргэд маань ч тэр, төр ч тэр ерөөсөө бүгдээрээ л нэг шударга нийгэм тогтооё, шударга ёс тогтооё, шударга шүүгчтэй, шударга шүүхтэй болъё гэж ярьдаг.

Тэгэхийн тулд яг шударгыг хэн дэнсэлдэг вэ. Шүүгч нар дэнсэлдэг. Шударгыг дэнслэхийн тулд шүүгч маань хараат бус байх ёстой. Нөгөө талдаа ажлаа хийх эдийн засгийн баталгаагаар хангагдах ёстой. Үндсэн хуульд заасны дагуу.

Энэ хүрээндээ л цалинг нь бусдаас нэмээд байгаа юм биш. Хуучин жишиг нь харьцангуй яах вэ бусад төрийн албан хаагчтай харьцуулах юм бол харьцангуй өндөр авдаг байсан. Энэ жишгийн хүрээнд л нэмэгдүүлье, энэ жишгийг нь барьж л явъя гэсэн тийм ажлыг маань оруулж ирсэн.

Гэхдээ яах вэ дээ, тэтгэврийг нь 80 хувь. Зарим зэрэг дэвийн нэмэгдэл гэдэг асуудал дээр манай Их Хурлын гишүүд шүүмжлэлтэй хандсан. Зэрэг дэвийн нэмэгдлээр ажлын хэсэг дээр ярихдаа адилхан шүүгч нарыг энэ нь тэргүүн зэргийнх, энэ нь дөтгөөр зэргийнх гэж ангилаад ялгаад байх нь, ялгаварлах нь жаахан буруу юм байна гэдэг байдлаар зэрэг дэвийн нэмэгдэл байхгүй болж байгаа. Нөгөө талдаа онцгой нөхцөлийнх нь нэмэгдлийг нэмж өгч байгаа.

Тэтгэвэртэй холбоотой асуудал бол тэтгэврээр үндсэндээ гээд үндсэн зарчмаар явчихна. Гэхдээ шүүгч нар маань бас онцгой онцлог ажил хийж байгаа. Онцгой улсууд. Энэ хуульд харах юм бол бусад Төрийн албаны тухай хуульд ийм нарийвчилсан зохицуулсан заалт байхгүй.

Ерөөсөө л босох, суух, гишгэх бүх зүйлийг нь энэ хуульд маш нарийн дэглэж өгсөн. Өөрөөр хэлэх юм л хараат бусаар явуулахын тулд хэн нэгний нөлөөнд автахгүй байх, хэн нэгэнтэй уулзахгүй байх, ямар нэгэн ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх энэ бүгдийг нь маш хатуу зохицуулж өгсөн байгаа. Тэгсэн тохиолдолд маш хатуу хариуцлага хүлээхээр, огцруулахаар.

Ийм учраас энэ хүн маань шударгаар асуудлыг шийдэхийн тулд ямар нэгэн нөлөөнд автахгүй ажиллахын тулд бас ажил амьдралаа хэвийн эрхлэх, өргөсөн тангарагтаа үнэнч байх баталгааг нь л бий болгож өгье гэдэг үүднээс харьцангуй өндөр гэдэг юм уу, бусад төрийн албан хаагчдаас цалин авдаг. Олон улсын жишигтэй юм байна лээ. Энэ жишгийн хүрээнд л явж байгаа. Энэ хууль батлагдсанаараа шүүгч нарын цалин нэмэгдэхгүй. Хуучин авч байгаа цалингийн хэмжээндээ л явагдах юм.

Г.Занданшатар: Л.Атарцэцэг. 93 дугаар микрофон. Ажлын хэсэг. Тодруулаад хариулчих.

Л.Атарцэцэг: Баярлалаа. Би энэ шүүгчдийн цалингийн асуудлаар энэ хуулийн төсөлд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ямар байр суурь, санал хэлсэн тухайгаа ер нь нэг жаахан тодруулга маягаар хэлчих нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийг шинэчилсэн найруулгыг шинээр боловсруулж төслийг бэлтгэх явцад Шүүхийн ерөнхий зөвлөлөөс оруулсан санал шүүгчид Төрийн албаны тухай хуулийн дагуу төрийн тусгай албан хаагчийн хувьд энэ шүүгчийн цалин, нэмэгдэл нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлд заасан энэ юунд бүрэлдэхүүнээр явах юм гэдэг саналыг оруулж байсан.

Ингээд шүүх дээр ажлын хэсэг дээр ингээд яригдаад энэ асуудал дэмжигдээгүй.

Ингэхээр үндсэн зарчим шүүгчдийн одоогийн авч байгаа цалин 5 дахь жилээс эхлэн 2 хувь ингээд жил болгон өссөн дүнгээр явна гэдэг энэ багцаараа нийт шүүгчдийн цалинг ямар байдлаар бууруулахгүй байх вэ гэдэг дээр бид маш олон янзын тооцоо судалгааг тухай бүрд нь ажлын хэсэгт холбогдох газруудад нь гаргаж өгч байсан.

Ингээд хамгийн эцсийн юугаар ажлын хэсэг дээр дэмжигдсэн санал онцгой ажлын нэмэгдлийг 40 хувь байх юм бол ямар ч байсан нийт массаараа цалингийн хэмжээнд нь барих юм байна гэдгээр ажлын хэсэг дээр санал дэмжигдээд ингээд явж байгаа.

Т.Аюурсайхан гишүүний Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хамгийн сүүлд авсан мэдээгээр цалин хөлс чинь та нар ингэж буруу ташаа мэдээлэл өгөөд байна аа гэдэгт би бас нэг залруулга хийчихье гэж бодож байна.

Манай шүүхийн ерөнхий зөвлөлөөс өгсөн. Би тодрууллаа л даа. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар шүүгчийн үндсэн цалин, энэ үндсэн цалин дээр Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 23 дугаар зүйлд зааснаар 5 дахь жилээс эхлэн 2 хувиар жил бүр өсөж явна гэсэн ийм заалттай байгаа.

Үүний дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчид 5 дахь жилээс эхлээд өссөн дүнгээрээ ямар байх вэ гэдэг нэг ийм хүсэлт гаргасан байгаа юм. Ингээд ер нь хамгийн эцсийн жилийн 40 жил.../минут дуусав/

Г.Занданшатар: Цаг дууссан. Хугацаандаа л багтаа. Одоо эрхэм гишүүн Жамбын Батсуурь цахимаар асуулт асууна. Ж.Батсуурь гишүүн алга байна. Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Сүүл рүүгээ эцсийн хэлэлцүүлэг энэ тэр рүүгээ ороод явахаар их сонин байдал руу орчихлоо л доо.

Ер нь яг шүүхийн хараат бус байдлыг яг байлгах гээд байгаа юм уу, бий болгох гээд байгаа юм уу, яах гээд байгаа юм. Тийм ээ. Тэр нь тодорхойгүй байна. Барилдахаасаа, таахалзах нь гэгчээр ам ажлын нэгдэл чинь алга байна.

Одоо 2016-2021 он хүртэл Та бүхнийг олонх байхад шүүхийн хараат бус байдал бол хараат бус байгууллагын судалгаагаар 80-аас 120 хүртэл ухарсан. Жил болгон арван байраар.

Тэгээд 2015 онд шүүх, шүүгчдийн ажиллах боломжийг нэг л удаа тэр үед хангаж байсан. Түүнээс хойш шүүгчдийн цалинг нэмсэн зүйл байхгүй. Шүүхийн барилга, байгууламжийг сайжруулсан зүйл байхгүй. Ийм байдалтай л явж байгаа.

Тэгээд энэ ярьж байгаа, хэлж байгаа юмнуудыг чинь хараад байхад цаашдаа байдал бараг аягүй бол дордох нь. Шүүгч гэдэг чинь цалинтай, эдийн засгийн баталгаатай байж байж л тэр ажлаа хийнэ шүү дээ. Тэгэхгүй тэгээд эндээ попорсоор байгаад юу ч биш болоод л дуусах юм байна.

Тэгээд өчигдрийн Байнгын хорооны хурал дээр ажлын хэсэг 35-аар оруулж ирсэн байна лээ. Тэр онцгой байдлын нэмэгдэл гэдгээ. Тэгээд Ардчилсан намын 3 гишүүн 40 болгоё. 40 байтугай 45 байх ёстой юм байна.

Энэ чинь хуулиар та хэлэв үү? Тийм ээ. Үндсэн хуулийн 42-т байж байгаа шүү дээ. Тэр эдийн засгийн нөхцөл байдлыг нь дордуулж болохгүй гээд. Ингээд дордох нь цаашдаа.

Г.Занданшатар: Үндсэн хуулийн 42-т өөр заалт байдаг юм.

Д.Ганбат: Тэгээд шүүх засаглал гэдэг хэмжээнд нь аваачих ёстойгоос биш тэр төрийн албан хаагч байх.../минут дуусав/

Г.Занданшатар: Үндсэн хуулийн 48.2-т зүгээр эдийн засгийн баталгааг хангана гэсэн заалт байгаа гэсэн.

Асуулт асуух юм уу? Д.Ганбат гишүүн 1 минут.

Д.Ганбат: Одоо Авлигатай тэмцэх газар нь хүртэл Онцгой байдлын нэмэгдэл гэдэг нь 40 хувиар байж байгаа шүү дээ. Тэгээд ядаж тэр хэмжээнд нь хүргээч гэж хэлсэн.

Тэгээд тийм байдалд оруулах шиг болно лээ. Ардчилсан намын бүлгийн 3 гишүүн шүүхийг тэр гурав дахь засаглалын хэмжээнд байлгахын тулд шүүгч нараа ядаж тэр онцгой байдлын нэмэгдэл гэдгийг нь 45 хувиар өгье гэдэг санал гаргасан.

Тэгээд энэ дээр Та бүхний ярьж байгаа чуулган, Байнгын хорооны хурал дээр ярьж байгааг харахад зүгээр л нэг таахалзаад байх юм. Яг ажил амьдрал

дээр хууль тогтоохдоо тэр нөхцөл боломжийг нь хангах, Үндсэн хуульд нийцүүлсэн зүйл, заалтаа оруулж чадахгүй байна шүү дээ.

Тэгээд хамгийн сүүлд бас нэг юм хэлчхэд тэр Дээд шүүхийн шүүгчтэй бид энэ хууль батлагдвал импичмент хийх хэрэгтэй. Томилгооны сонсгол хийгээд итгэл үзүүлэх үү, үгүй юу гэдгээ нэг харчих хэрэгтэй. Тэгэхгүй бол одоо хонгил гэдэг нэр бол тэр хүмүүстэй л холбогдоод байгаа шүү дээ.

Г.Занданшатар: Импичмент гэж ярих юм бол Үндсэн хуулийн 49.6, 54.1 дүгээр заалтыг зөрчих болно л доо.

Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Сүүлийн асуултаас эхлээд хариулъя.

Энэ дагасан тогтоолоор Нийтийн сонсголын тухай хуульд бас нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа. Энэ дээр үндсэндээ Улсын Их Хурал Дээд шүүхийн шүүгчтэй танилцана. Танилцахдаа томилгооны сонсгол хийнэ ээ гэж. Танилцах сонсгол хийж орж ирж байгаа.

Тэгэхээр үндсэндээ Дээд шүүхийн шүүгч нар нэг бүрчлэн Их Хурал дээр танилцах сонсгол хийж, таны асуултад хариулж байж томилогдоно. Танилцаж тооцогдоно. Танилцана.

Тэгэхээр цаашдаа үндсэндээ. Түрүүн Б.Энхбаяр гишүүн хэлсэн шүү дээ. Хэн нэгэн одоо юу гэдэг юм, өнгө үзэмжээрээ нуугаад хаагаад, хүчээр түлхээд, дарамтлаад өөрийнхөө хүнийг шүүгчээр томилуулчих. Тэгэнгүүтээ захиа даалгавраа өгөөд чиглүүлээд ажиллуулдаг байсан бол энэ бол бололцоогүй, боломжгүй болно.

Яг үүнтэй адилхан хуульд нэлээн томоохон өөрчлөлт орж байгаа. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт болон урьд нь Үндсэн хуульд байсан заалтууд хэрэгжиж чаддаггүй байсан. Энэ бол зөвхөн 2016 оноос эхэлчихсэн юм биш. Энэ бол ер нь бол зүгээр яг шударга хэлэхэд үе үеийн Ерөнхийлөгч нараас дамжаад л шүүхэд нөлөөлдөг.

Нөлөөлөл нь тэр шүүхэд шударга бус байдлыг бий болгодог. Хараат болдог. Ийм байсан энэ тогтолцоог зөвхөн 2016 оноос биш. Үе үеийн гэж би хэлж байгаа шүү. Энэ тогтолцоог эвдэж байгаа. Энэ тогтолцоог өөрчилж байгаа. Маш том өөрчлөлт орж байгаа.

Мэдээж ийм том өөрчлөлт орж байгаа болохоор алдсан, оносон зүйл байж болно. Үүнийг цаашдаа бид засаад залруулаад явах бололцоо нь байгаа. Хамгийн гол нь маш том өөрчлөлт, маш том дэвшил, алхам хийж байгаа. Энэ дээр яах вэ, алдсан онцлон зүйл байж болно. Үүнийг бас та зөв ойлгоорой. Энд ямар нэгэн байдлаар Байнгын хорооны дарга ч болон ажлын хэсгийн гишүүд нэг таахалзаад байсан юм байхгүй.

Ажлын хэсгийнхэн чадлаараа л өдөр шөнөгүй хэдэн сар, гурав, дөрвөн сар нойр хоолгүй ажиллалаа. Энэ хүмүүсийн хөдөлмөрийг, энд шүүх, Дээд

шүүхийн шүүгч нараас авахуулаад Шүүхийн ерөнхий зөвлөл, Хууль зүй, дотоод хэргийн яам, манай Их Хурлын гишүүд гээд бүгд л ажилласан. Энэ ажилласан хүмүүс маань ямар нэгэн байдлаар энэ сайн хуультай болох юмсан, шударга бус явдлыг таслан зогсоох юмсан гэдэг сэтгэлийн үүднээс л ажилласан. Үүнд таахалзсан зүйл байхгүй байх гэж би бодож байна.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Сайнбуянгийн Амарсайхан.

С.Амарсайхан: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Шүүхийн тухай хуулиар нэлээн тогтолцооны шинж чанартай. Дээрээс нь мэргэжлийн болон бусад чадавхыг дээшлүүлэх, улс төрийн нөлөөллийг багасгах гээд асар олон шинэ зүйл заалтууд орж ирж байгаа.

Миний ярьж байгаа ганц хоёр зүйл, асуудлууд байгаад байгаа. Хууль, шударга ёсны шүүлтүүр болсон Шүүхийн тухай хуулийн зүйл, заалт бүхэн нь маш тодорхой байх ёстой. Ямар нэгэн салаа утга, эсвэл бүдэг бадаг зүйл байхгүй гэж. Гэтэл энэ дээр бас зүйл, заалтын хувьд давхацсан, заримдаа агуулга тодорхойгүй, тэгээд тодорхой бус ийм заалтууд орж байгаа юм.

Нэгдүгээрт нь, Улсын дээд шүүх хууль зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг хэрхэн гаргах вэ гэдэг Үндсэн хуулийн заалтын хэрэгжилтийг Шүүхийн тухай хуулиар тусгайлан зохицуулах хэрэгтэй байна гэдэг асуудал ярьж байгаа юм.

Хууль хэрэглээний нөхцөл байдлыг хангах, өргөн хүрээтэй утга агуулгатай зохицуулалт бүхий хууль тайлбар хийх хэрэгцээ шаардлага үндсэндээ байнга үүсэж байдаг. Түүнийг хийхэд тухайн хуулийн хэм хэмжээнээс хамаараад онол, практикийн судалгаа хийх зайлшгүй шаардлага бас гарч байдгийг Та бүхэн мэднэ.

Үүнтэй холбогдуулаад 28.1.3 дээр би тайлбарыг зөвхөн шүүхийн шийдвэр практикт үндэслэн гаргахаар, энэ талаар саналыг Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанд оруулахаар Улсын дээд шүүхийн танхимд эрх олгосон нь буруу байна гэж үзээд байгаа юм.

Танхимын санал хууль зүйн шинжлэх ухаан болон бусад салбарын шинжлэх ухааны нотолгоо, онол, үндэслэл, дүгнэлт гээд олон зүйл дээр үндэслэгдэж байж хууль тайлбарлагдах ёстой. Жишээ нь, эрдэнэсийн гэдэг юм уу, үнэт зүйлийн, геологийн шинжлэх ухааны нэр томъёолол гээд. Бүр цаашлах юм биологийн, геологийн гээд энэ тусгай салбаруудын нэр томъёололтой холбоотой.

Дээрээс нь түүнтэй холбоотой хуулийн тайлбарыг хийхэд зайлшгүй сонсох судалгаа хийдэг. Тухайн тайлбарын төсөлд хөндлөнгийн экспертээр дүгнэлт гаргуулдаг. Тэр хэрээрээ процедур зөв явж байх ёстой гэдэг ийм.../минут дуусав/

Г.Занданшатар: С.Амарсайхан гишүүн нэмэлт 1 минут.

С.Амарсайхан: Тэгэхээр эдгээр шаардлага хангаагүй, хуультайгаа харшилсан тайлбарыг Улсын дээд шүүх хэрхэн хүчин хүү болгох вэ гэдэгт гэдэг юм уу, журам тодорхой хуульчлагдах ёстой гэж бодож байгаа. Энэ дээр ямар асуудал байна. Нэгд.

Хоёрт, хуулийн төслийн 43.4, 52.1.14 хоёр давхцаж байгаа. Тэр шагнал урамшуулалтай холбоотой. 43.4 дээр хуульд зааснаас бусад цол, одон, тэмдэг, шагнал олгохыг хориглоно гэсэн. 52.1.14 дээр болохоор бас мөн ижил утгатай байж байгаа.

Гуравдугаарт нь, энэ 37.2.6-г хасах саналтай байгаа. Яагаад гэвэл 37.2.5 дээр Улсын Их Хурал танилцах сонсгол хийнэ гэсэн Үндсэн хуулийн шаардлага байгаа. Гэтэл 37.2.6 дээр хэрвээ Улсын Их Хурал 90 хоногийн дотор танилцаагүй бол танилцсанд тооцно гэдэг салаа утгатай асуудал байгаад байгаа.

Дөрөвдүгээрт, шүүгчдийн цалин хөлстэй холбоотой асуудлыг бид дэмжих шаардлагагүй. Тэтгэврийн 80 хувиар нь тогтоодог байх ёстой. Цаашдаа ч гэсэн энэ бусад салбарын үндэсний хэмжээнд цалин хөлсийг бүх салбарт.../минут дуусав/

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн хариулъя.

Б.Энхбаяр: С.Амарсайхан гишүүний асуултад хариулъя.

С.Амарсайхан гишүүн Шүүхийн хуулийн анхны хэлэлцүүлэг дээр Байнгын хороо болон чуулган дээр сая энэ Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй Улсын Их Хуралд танилцах, тодорхой хугацаандаа танилцаагүй бол танилцсанд тооцно гэдэг чинь өөрөө энэ Улсын Их Хурлын бас бүрэн эрхийг зөрчөөд байна.

Энэ чинь тодорхой хугацаа гээд. Ингээд завсарлага завсарлага. Одоо Улсын Их Хурал маань хэдэн ч бүлэгтэй байх юм. Тийм ээ. Тэгээд 3 бүлэгтэй байдаг. 3 бүлгийн завсарлагаа аваад явж байтал нөгөө хугацаа нь дуусчихдаг. Тэгэнгүүт нөгөө танилцсанд тооцно гээд танилцаж чадахгүй өнгөрчих юм биш үү гэдэг асуудлыг тавьсан.

Тэгээд үүнийг ажлын хэсэг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх явцад С.Амарсайхан гишүүний саналыг аваад. С.Амарсайхан гишүүнээ Та саналын томьёоллын 9 дэх саналыг үзээрэй. Энэ яг нөгөө таны хэлж байсан томьёоллын дагуу.

Одоо бол тэр “танилцсанд тооцно” гэдгийг нь авч байгаа юм. “Танилцсанд тооцно” гэдэг таны саналыг аваад тусгаад явж байгаа.

Ер нь Улсын дээд шүүх тайлбараа нийт шүүгчдийн хуралдаанаараа гаргана. Гаргахдаа гол нь хуралдаанд оруулах асуудал нь өөрөө танхим нь байх ёстой. Яагаад гэхээр танхим гэдэг маань өөрөө шүүн таслах үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн, дагнасан байх тэр агуулгаар илүү

ажиллаж байгаа учраас тухайн танхим нь саналаа гаргаад, тэгээд нийт шүүгч дээрээ гаргадаг байх нь өөрөө Үндсэн хуулийн шаардлагад нийцэх юм байна.

Яагаад гэхээр Үндсэн хуульд Улсын дээд шүүх хуулийг хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргана гэж байгаа. Тэгэхээр Улсын дээд шүүх гэдэг маань Ерөнхий шүүгч, нэмэх нь Улсын дээд шүүхийн 24 шүүгч байгаад байгаа юм. Өөрөөр хэлбэл аль нэг танхим гэсэн агуулга Үндсэн хуульд байхгүй байгаад байгаа юм.

Тийм учраас Үндсэн хуулийнхаа үзэл санаанд нийцүүлээд нийт шүүгчдийнхээ хуралдаанаараа тайлбараа гаргаад ингээд хуулийн нэгдмэл байдлыг хангадаг тэр байх ёстой гэдэг.../минут дуусав/

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Баагаагийн Баттөмөр.

Б.Баттөмөр: Монгол Улсын Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийн нэг чухал хэсэг нь шүүхийн шинэчлэлтэй холбоотой асуудал байгаа юм.

Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд энэ органик хуулиудад өөрчлөлт орж байна. Шүүхийн тухай хууль үнэхээр Монгол Улсын цаашдын хөгжил дэвшил, Монгол Улсад шударга ёсыг тогтооход үнэхээр их чухал ач холбогдолтой ийм хуулийг бид баталж байна л даа.

Хэд хэдэн асуулт байна.

Нэгдүгээрт нь, Шүүхийн хуулийн өөрчлөлтийг мэргэжлийн байгууллагуудаас санал аваагүй. Мэдээллийн хэрэгслээр тэр болгон мэдээлээгүй. Нийтийн сонсгол явуулах ёстой гэсэн ийм байр суурьтай гишүүд ч байгаа. Иргэд ч байна. Энд ямар хариулт өгөх вэ гэдэг асуулт нэг дэх нь асуулт байна.

Хоёр дахь нь, шүүхийн статистикаар эрүүгийн болон иргэний, захиргааны болон анхан шатны давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн 50 хувь нь Дээд шүүх дээр өөрчлөгдөж байгаа. Энэ яагаад ингэж байна. Хуульчидтайгаа холбоотой байна уу? Шүүгчтэй холбоотой байна уу? Хуульдаа байна уу. Хууль хэрэглэхэд тийм бэрхшээл гарч байна уу?

Захиргааны хэргийн шүүхийн 25 хувь нь Дээд шүүх дээр өөрчлөгдсөн байгаа. Энд хариулт авъя. Яагаад ингэж байна.

Дараагийн асуудал. Дээд шүүх 25 гишүүнтэй. Иргэний хэргийн 7 шүүгч дээр маш их олон хэрэг цугларсан байдаг. Дээд шүүхийн шүүх дээр хэрэг болгоныг ингээд унших ёстой юм уу, эсвэл хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах ёстой юм уу? Энэ чиглэлд ямар хариулт өгөх вэ?

Дээд шүүхийн хэрэг хүлээж авах шалгууруудыг өөрчилсөн үү гэсэн ийм асуулт байна. Тодорхой хэрэг маргаан дээр нэг хуулийн заалтыг хоёр өөрөөр хэрэглэсэн маргааныг дээд шүүх авч үзэх ёстой. Энэ дээр ямар өөрчлөлтүүдийг оруулж байна гэсэн ийм. 1 минутаа авчихъя.

Г.Занданшатар: Б.Баттөмөр гишүүн 1 минут. Эхлээд хариулчих.

Б.Баттөмөр: Би 1 минутаа авъя.

Г.Занданшатар: Хариулсны дараа авчих даа. За Б.Баттөмөр гишүүн. 1 минут.

Б.Баттөмөр: Шүүхийн ерөнхий зөвлөл нь Үндсэн хуулиар тогтоосон шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүгчид хариуцлага тооцох эрх бүхий байгууллага, Шүүхийн ерөнхий зөвлөл нь 10 гишүүнтэй, одоо бас орон тооны бус гишүүдтэй байхаар ингэж орж ирж байна л даа.

Тэгэхээр бусад улсуудын туршлага, бусад орнуудын туршлага ямар байна? Энэ дээр юу юуг нь авч хэрэглэв ээ? Яг энэ шийдэл маань хэр зэрэг оновчтой болж байгаа юм бол?

Хамгийн сүүлчийн асуудал. Энэ шүүхийн шийдвэр биелдэг, хэрэгждэг байх ёстой. Гэтэл Захиргааны хэргийн шүүхийн 10 хувь нь, Иргэний хэргийн шүүхийн 40 хувийн хэрэгжилттэй л байна л даа.

Тэгэхээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажил бол тусдаа хуультай ч гэсэн шүүхийн шийдвэр биелэх эсэх нь шүүх хурал, тэрний хууль хэрэглэж байгаа олон зүйлээс шалтгаална. Тэгээд шинэ хуульд энэ асуудлыг нь ер нь яаж авч үзэв гэсэн ийм асуултуудад хариулт авъя.

Г.Занданшатар: С.Бямбацогт дарга асуултад хариулна. Сандагийн Бямбацогт.

С.Бямбацогт: Эхний асуултад би хариулчихъя.

Шүүхийн тухай хуулийг олон нийтэд мэдээлэл хэр өгсөн бэ. Хэлэлцүүлэг хийсэн бэ гэдэг асуудал ярьж байгаа юм.

Тэгэхээр 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийгдсэн. Энэ үед бас шүүхтэй холбоотой энэ хараат бус байх, шударга ёсыг тогтоох, энэ чиглэлээр маш сайн хэлэлцүүлгүүд хийгдсэн.

Үүний дагуу 2020 оны 4 сард Монгол Улсын Засгийн газар Шүүхийн тухай хуулийг Их Хуралд өргөн мэдүүлсэн. Үүнийг хэлэлцэх эсэх нь бол 4 сар шийдэгдсэн. Хэлэлцэх эсэхийг шийдэх үед чуулган, Байнгын хороогоор маш сайн хэлэлцүүлэг хийгдсэн.

Дараа нь ажлын хэсэг байгуулагдаад үндсэндээ гурав, дөрвөн сар ажиллаж байгаа. Энэ хугацаанд ажлын хэсэг маань 2 удаа хэлэлцүүлэг хийсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгч бас шүүхийн багц хуулиуд санаачилж Их Хуралд өргөн мэдүүлсэн. Үүнтэй холбоотойгоор Их Хурлын чуулганы хуралдаанд тодорхой асуудал яригдаж байсныг та мэдэх байх.

Үүний дараа бас Ардчилсан намын бүлэг дээр мэдээллүүд хийгдэж, мөн Монгол Улсын Ерөнхийлөгч дээр бас тодорхой танилцуулга, мэдээллүүд хийгдэж, ерөнхийдөө Шүүхийн тухай хууль маань түрүүн ярьсан шүү дээ. Хоёр парламент дамжаад, гурван чуулган дамжаад хэлэлцэгдээд, одоо батлагдах гээд эцсийн хэлэлцүүлэг хийгдэж байгаа.

Энэ хүрээндээ олон нийтийн өмнө нээлттэй, ил тод, байнга л хэлэлцэгдэж байгаа.

Улсын Их Хурлын нэг онцлог бол Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаа асуудал болгон олон нийт дээр шууд ил тод явдаг. Хэлэлцэх эсэх нь, анхны хэлэлцүүлэг нь, эцсийн хэлэлцүүлгийг нь, эцэслэн батлах нь бүгд ил тод явдаг.

Мөн ажлын хэсгийн хуралдаан, Байнгын хорооны хуралдаан, чуулганы хуралдаан бүгдээрээ л ил тод явдаг. Бүгд л бүх шатандаа олон нийтийн санаа бодлыг сонсох, санал хэлэлцүүлэг хийгдэх бололцоо боломжоор хангагдаж явдаг.

Тийм болохоор энэ үүднээсээ Шүүхийн тухай хууль харьцангуй одоо юу гэдэг юм сайн хэлэлцэгдсэн, хэлэлцүүлэг хийгдсэн гэж үзэж байгаа. Гэхдээ мэдээж асуудал байх юм бид алдахгүй биш алдаж болно. Энэ алдааг цаашид засаж залруулах нь нээлттэй байгаа.

Хоёр дахь асуудал. Дээд шүүхтэй холбоотой асуудлаар Ц.Цогт шүүгч хариулчихъя. 86.

Г.Занданшатар: 86. Ажлын хэсэг. Цэндийн Цогт шүүгч.

Ц.Цогт: Б.Баттөмөр гишүүний Улсын дээд шүүхийн шүүхээр хэлэлцэж байгаа хэрэг хүчингүй болж өөрчлөгдөж байгаа хувьтай холбоотой асуултад хариулъя.

Тэгэхээр сүүлийн 5 жилийн статистикаар Эрүүгийн хэргийн танхим дээр доод тал нь 42.4-өөс дээд тал нь 50.1 хувь энэ анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр хэвээр үлдэж байгаа.

Иргэний хэргийн танхим дээр доод тал нь 53.7-гоос дээд тал нь 63.0 хувь хэвээрээ үлдэж байгаа. Хэвээр үлдэж байгаа хувь нь.

Захиргааны хэргийн танхим дээр дээд тал нь 66.2 хувь хүртэл хэвээр үлддэг. Ийм тоо гардаг. Энэ бол статистик.

Тэгэхээр шат шатны шүүхийн байдаг учир холбогдол ялангуяа дээд шатны шүүхэд анхан шатны, давж заалдах шатны шүүхийн шийдвэрт гарсан алдаа оноог хэргийн оролцогчдын гомдлын үндсэн дээр засаж залруулах ийм үүрэгтэй оршин байдаг. Тэр чиг үүргээ хэрэгжүүлж анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэрт гарсан алдаа оноог засаж залруулдаг.

Тийм учраас шүүхийн шийдвэрийн өөрчлөлт ийм тодорхой хуваарь ингэж өөрчлөгддөг. Энэ нь байх ёстой зүй ёсны ийм өөрчлөлт юм.

Энэ өөрчлөлт дотор бүх төрлийн өөрчлөлт багтаж байгаа. Тухайлбал, анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон доод шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь хүчингүй болгоод нэхэмжлэлийг нь хангаж байгаа тэр өөрчлөлт ч орж байгаа. Нэг хуулийн зүйл, заалтыг буруу барьсан. Тийм ээ. Арван долдугаар зүйл гэж барихыг Арван наймдугаар зүйл гэж барих ёстой байсныг Арван долдугаар зүйл гэж барьсныг дээд шатны шүүх залруулж байгаа тэр өөрчлөлт хүртэл энэ тоонд ордог.

Тийм учраас бүх тэр өөрчлөлт өөрөө доод шатныхаа шүүхийн шийдвэрийг.../минут дуусав/

Г.Занданшатар: Цэндийн Мөнх-Оргил гишүүн. Шүүхийн шийдвэр. Асуултад хариулна. Цэндийн Мөнх-Оргил гишүүн. Ажлын хэсгийн гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Б.Баттөмөр гишүүн ээ, шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой асуултад би товчхон хариулъя.

Шийдвэр гүйцэтгэлийн хувь заяа үндсэндээ хоёр юмнаас шалтгаалж байгаа юм. Нэг нь гарч байгаа шийдвэрийн чанар. Хоёр дахь нь гарсан шийдвэрийг хэрэгжүүлж байгаа ажиллагаа.

Хувилаад үзэх юм бол. Миний бодлоор шүү. Б.Баттөмөр гишүүн ээ. Миний бодлоор хувилаад үзэх юм бол гарч байгаа шүүхийн шийдвэрийн чанараас ер нь 10 хувь л шалтгаална. 90 хувь нь гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх дараа дараагийн шатлалын ажиллагаа.

Тэгээд энэ 10 хувийг сайжруулахын тулд бид энэ хуульд шүүгчийн шийдвэр ийм ийм үндэслэлтэй байх ёстой. Үндэслэлээ бичээгүй байх юм бол сахилгын шийтгэл ногдуулна. Сахилгын хороон дээр очно гээд ингээд үндэслэлүүдийг нь тавьчихсан. Нөгөө талаас шүүхийн шийдвэр гарахад яг юу юу тусгах ёстой юм бэ гээд бүр нарийвчилсан дэг журмыг нь дээд шүүх нь өөрөө сургалтууддаа хийнэ гээд ингээд энэ асуудал туссан.

Энэ Шүүхийн хууль батлагдсаны дараа Улсын Их Хуралд нэг анхаарлаа хандуулах ёстой юм бол энэ шийдвэр гүйцэтгэлээ яаж сайжруулах вэ гэдэг асуудал байгаа юм.

Тэгээд энэ дээр ерөөсөө гол алдаа миний хараад байхад л байна шүү дээ. Ерөөсөө процессуудаа бид янзлахгүй байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн процесс гэхэд л байна шүү дээ ерөөсөө нэг шатны шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гаргалаа. Тийм ээ. Лацад нь ч гэдэг юм уу. Тэрийг нь шууд давчихдаг. Дээд шатны дарга дээр нь. Дээд шатны дарга нь тэрийг нь зөвшөөрлөө. Тэрийг нь дараагийн шатан дээр нь.

Ингэж явсаар байгаад шийдвэр гүйцэтгэлийн дарга Д.Загджав дээр очиж байтал гурав, дөрвөн шат явчхаад байгаа байхгүй юу.

Үүнийхээ дараа ахиад нөгөөдөхөө шүүхдэнэ. Нөгөө шат шатаараа явсаар байгаад. Ингээд энэ нөгөө нэг шийдвэр гүйцэтгэлийн процесс маань өөрөө хүнд байна.

Хоёрдугаарт, эрүүгийн, захиргааны, иргэний процессууд маань, ялангуяа иргэн, захиргааны процессууд маань өөрөө их хүнд байна. Бүх юмыг бид заавал ингээд нөгөө шат шатаар нь явуулаад байна. Жишээ нь, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар тэр урьдчилан шийдвэрлэх ажиллагаа гэж байгаа байхгүй юу. Тийм үү. Урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явагдлаа. Дээд шатны захиргааны удирдах ажилтан нь шийдвэрээ гаргалаа. Тэр гаргасан шийдвэрт нь шүүхэд гомдол гаргаагүй л бол үндсэндээ тэр ажиллагаа дуусаж байгаа байхгүй юу.

Тэгэхэд тэр шийдвэр.../минут дуусав/

Г.Занданшатар: Б.Баттөмөр гишүүн 1 минут тодруулчих. Болсон уу? Процессжуулах бас их чухал байгаа шүү.

Одоо эрхэм гишүүн Одонгийн Цогтгэрэл.

О.Цогтгэрэл: Баярлалаа. Энэ хуульд орж байгаа бас нэг зарчмын шинжтэй томоохон өөрчлөлтүүдийн нэг нь Дээд шүүх дээр хэрэг маргаан очих асуудал гэж ойлгож байгаа. Дээд шүүх дээр үндсэндээ хэрэг маргаан очих босго өндөрсөж байгаа.

Тэгэхээр үүнтэй холбоотой асуултууд байгаад байна л даа. Яг одоогийн байдлаар Дээд шүүх дээр хэрэг маргаанаа шийдүүлнэ гээд өгчихсөн хэчнээн иргэний асуудал байгаа юм. Нийт том тоо бол их л том л тоо дуулдаж байсан. Энэ хүмүүс ямар ч байсан одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн эрх зүйн дагуу би бас хэргээ, гомдлоо шийдүүлнэ гээд дээд шүүх дээр өгчхөөд хүлээж байгаа байхгүй юу.

Энэ хүмүүс дээр Та нар яг энэ хуулийн төсөлд ямар байдлаар энэ хүмүүсийн асуудлыг шийдэгдэх юм. Шууд хуулийн зохицуулалтаараа явчих юм уу?

Тэгээд хоёр дахь асуулт нь, ер нь энэ Дээд шүүх дээр хэрэг маргаан очих босго өндөрсөж байгаа юм чинь тэр дээд шүүхэд тэр дунд шатны шүүхээс давах хугацаан дээр ч юм уу, тийм боломж, иргэдэд боломж олгосон заалт байгаа юу? Одоо энэ чинь хуучин 14 хоног байсан гэж би сонссон. Үүнийг нэг сар болгодог ч юм уу?

Ингэхгүй болохоор тэр шинээр үүсэж байгаа хуулийн өндөр босготой холбоотойгоор Дээд шүүхэд гаргах маргаанаа үндэслэлтэй гаргах гэдэг иргэдэд бас их том асуудлууд гарч магадгүй. Энд очиж үндсэндээ иргэдийн эрх, эрх зүйн байдал дордох нөхцөл байдал үүсэх нөхцөл байдал үүсэх үү? Энэ дээр ямар зүйл, заалт. Нөгөө талд нь босго өндөрсөж байгаатай холбоотой иргэдэд боломж олгож байгаа вэ гэсэн асуулт байна.

Г.Занданшатар: 86. Ажлын хэсэг. Ц.Цогт шүүгч.

Ц.Цогт: Улсын дээд шүүхийн иргэний хэргийн танхим өнгөрсөн хугацаанд, өнгөрсөн жил, бүтэн жил орон тоо маш дутагдалтай ажилласнаас болоод Улсын дээд шүүхэд хандсан иргэний хэрэг шийдвэрлэгдэх боломжгүй. Өөрөөр хэлбэл бүрэлдэхүүнгүй болсноос болоод хяналтын шатны иргэний хэрэг хуралдаанаараа хэлэлцэж чадахгүй байсаар байгаад тэгээд ийм бөөгнөрөл, хүлээлт үүссэн нь үнэн.

Энэ байдал засагдаад Ерөнхийлөгчийн зарлигаар Улсын дээд шүүхийн Иргэний танхим ажиллах боломжтой болсноос хойш иргэний хэргийн танхим долоо хоногт маш олон өдөр хуралдаж, ингээд энэ иргэдийн шүүхэд гаргасан гомдлыг, хураагдсан байсан гомдлыг шийдвэрлэх зорилготойгоор ажиллаж байгаа.

Тэгэхээр яг одоогоороо сүүлийн байдлаар энэ иргэний хэргийн танхим дээр 2 мянгаад хэрэг хэлэлцэгдэхээр хүлээгдэж байгаа. Ийм байдалтай байгаа.

Захиргааны хэргийн танхим, иргэний хэргийн танхим бол долоо хоногт нэг ойролцоогоор. Би зүгээр дунджаар хэлж байгаа шүү. Яг тоо биш. 20-иос 30 хэрэг, 40 хэрэг давж заалдах шатны шүүхүүдээс ирдэг.

Тэгээд энэ нь 30 хоногийн дотор шүүх хуралдаанаар зарлагдаад ингээд ирсэн дарааллаараа хэлэлцэгдээд, шийдвэрлэгдээд явж байгаа. Захиргаа, иргэн хоёр дээр хүлээлт үүссэн зүйл байхгүй байгаа.

Ер нь Шүүхийн тухай хуулийн өөрчлөлтөөр хяналтын шатны шүүхийн эрх хэмжээг бүх хэргийг авч шийдэхдээ биш хууль хэрэглээний зарчмын ач холбогдолтой, хүний эрхийг ноцтой зөрчсөн, эсвэл шүүхийн шийдвэрт тэр нь нөлөөлсөн гэсэн ийм үндэслэлүүдээр давж заалдах шатны шүүхийн шийдвэрүүдийг авч шийдвэрлэх. Улмаар тэр шийдвэрүүд нь өөрөө ижил төстэй хэрэг маргаанууд дээр жишиг болж шиг болж шийдвэрлэгддэг байх зарчим суугдаж байгаа. Энэ нь нэг талаас.../минут дуусав/

Г.Занданшатар: Хишигээгийн Нямбаатар гишүүн.

Х.Нямбаатар: Баярлалаа. Сая О.Цогтгэрэл гишүүний асуултад Ц.Цогт дарга дутуу хариулчихлаа.

Одоо Дээд шүүх дээр байгаа хэргүүдийг яах юм бэ гэдэг нэг зүйлийг асуусан юм.

Хоёрдугаарт, цаашид иргэдэд эрхээ хамгаалуулах гэж байгаа хүмүүст Дээд шүүхэд хандахад ямар үндэслэлүүдээр хандах талаар илүү олон түмэнд ойлгуулж, сурталчлан таниулах хэрэгтэй шүү гэдэг ийм хоёр зүйлийг хэлсэн юм.

Тэгэхээр бид дагаж мөрдөх журмын хуулиар өнөөдөр Дээд шүүхийн гурван танхим дээр байгаа энэ хэргүүдийг үндсэндээ Дээд шүүх шийдэх ёстой гэдэг агуулгаар зохицуулалт хийе гэж тохирсон.

Хоёрдугаарт, энэ хуулийн 25.7.5 дээр дээд шүүх, Улсын дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор давж заалдах шатны шүүхийн магадлалыг дараах тохиолдолд хяналтын журмаар шийдвэрлэнэ гээд гурван үндэслэл оруулж ирж байгаа юм.

Нэгдүгээрт, анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах зорилгоор Улсын дээд шүүх хэрэг маргааныг хяналтын шатны журмаар шийдвэрлэнэ.

Хоёрдугаарт, хуулийг Улсын дээд шүүх албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн тохиолдолд хэрэг маргааныг хяналтын шатны журмаар шийдвэрлэнэ.

Гуравдугаарт, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн гэж үзвэл хэрэг маргааныг хяналтын шатны журмаар шийдвэрлэнэ гэсэн ийм гурван үндэслэлийг оруулж ирсэн.

Одоо Улсын дээд шүүх нийт шүүхээр шийдэгдэж байгаа хэргийн 3 хувийг Улсын дээд шүүх хяналтын шатны журмаар шийдвэрлэж байгаа бол энэ хууль хэрэгжиж эхэлснээр ойролцоогоор бидний урьдчилан тооцоолж байгаагаар 1 орчим хувийг хяналтын шатны журмаар шийдвэрлэнэ гэсэн ийм статистик гарч байгаа.

Энэ утгаараа цаашид давж заалдах шатны шүүхийг чадавхжуулах, тэндээс гарч байгаа шийдвэр нь хууль зүйн үндэслэлтэй байх тал дээр илүү их анхаарах шаардлагууд гарч байгаа гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Тийм. Ер нь хууль тогтоогчид, Хууль зүй, дотоод хэргийн яам ч гэсэн Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийг ягштал баримталж байвал хууль тогтооход нэн тустай байгаа.

Шүүх холбогдох байгууллагууд мэдээж өөрсдийн байгууллагын ашиг сонирхол, асуудлыг ярих нь зүй ёсны хэрэг. Тэгээд тэнцвэр хангах асуудал нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд байгаа хүний эрхийн бүх заалтууд маш сайн хийгдсэн заалтууд. Тухайлбал, Үндсэн хуулийн 16.14-т Монгол Улсын иргэний үндсэн эрхэд өөрийн эрх зөрчигдсөн, Монгол Улсын хууль, олон улсын конвенцоор олгогдсон эрх зөрчигдсөн гэж үзвэл уг эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, үр хүүхэд, эцэг эх, төрөл төрөгсдийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хууль зүйн туслалцаа авах, өөрийгөө өмгөөлөх үндсэн эрхийг хуульчилсан байдаг.

Тэгээд энэ бүхэн нь цаанаа нарийн агуулгатай задарч байдаг. Өөрөөр хэлбэл иргэний эрхийг шүүх талаас тэнцвэржүүлж хамгаалж байх ёстой иргэний үндсэн эрхийн асуудал.

Тийм учраас шударга шүүхээр шүүлгэх эрхийг л хангахын тулд Шүүхийн хуулийн шинэчлэл үндсэндээ хийгдэж байгаа шүү. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заагдсан иргэн шударга шүүхээр шүүлгэж үндсэн эрхээ

хамгаалуулах эрхийг л энэ шүүх тогтолцоо хангах учиртай гэдэг талаасаа бид шүүгчийн хараат бус байдал, эдийн засгийн баталгаа энэ бүх юмыг хөндөж ярьж байвал их зүйтэй байгаа юм.

Одоо эрхэм гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан.

Б.Энх-Амгалан: Өчигдөр шинэ Үндсэн хуулийн өдөр боллоо.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2016-2020 оны Улсын Их Хурал нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэн батлах түүхэн үйл явцыг авч хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд 40 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт орж байгаа. Үүний нэг нь Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл байгаа юм.

Яагаад шүүхийн тухай ярьж байна вэ гэхээр зэрэг шүүхийн нэр хүнд ард түмний дунд унасан. Шүүхэд итгэх итгэл алдарсан. Энэ юунаас болсон бэ гэхээр шүүхийн байгууллага буруутай биш ээ. Энэ бол шүүхийн буруу тогтолцоог бий болгож, түүгээрээ дамжуулж эрх мэдэлдээ хэрэгжүүлэх гэсэн тэр эрх мэдэлтэн буруутай юм. Энэ шударга шүүгчид энд буруутай биш байгаа юм. Энэ зориудаар бий болгосон хонгилын шүүгчид хууль завхруулах гэсэн тэр шүүгчид буруутай юм.

Шүүхийн байгууллагад ажиллаж байгаа эгэл жирийн шүүхийн албан хаагчид энд буруутай биш байгаа юм. Энэ бол улс төрийн хуйвалдаанд орсон захиалгатай, ардаа эзэнтэй, томилгоогоор тавигдсан энэ шүүгчид буруутай юм.

Тийм учраас үүнийг өөрчлөх гэж зүтгэж байгаа юм. Хоёр удаагийн парламент, гурван удаагийн чуулга нь дамжиж, олон гишүүд энэ дээр санал онолоо уралдуулж ингэж явж байгаа юм.

Энэ талаар манай Ц.Нямдорж сайд хамгийн их дуугардаг байсан. Шударга шүүхийн талаар. Эрүүдэн шүүхийн эсрэг, хүнийг хэлмэгдүүлэхийн эсрэг хамгийн их дуугардаг байсан.

Тийм ч учраас энэ хуулийг өөрөө өргөн барьсан. Цааш нь өлгийдөж авч явсан хүн нь Хууль зүйн сайд Х.Нямбаатар байна. Мөн энэ хуулийг бас нэг үзэл баримтлалыг нь өөрчилчихгүй, хамаагүй хадууруулчихгүй, зөв голдиролд нь авч явсан хүн бол энэ хуулийг ахалж байгаа ажлын хэсгийн дарга Б.Энхбаяр байна гэж бид бодож байгаа юм.

Энэ хуулийн байгууллагын ажлыг хийх гол зүйл нь шударга хуулийг л тогтоох гэж бид энэ бүгдийг.../минут дуусав/

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асууна. 1 минут.

Б.Энх-Амгалан: Тэгээд би энэ дээр юу асуух гээд байна вэ гэхээр зэрэг яах вэ энэ удаагийн хууль тийм арчсан толь шиг, арилгасан сонгино шиг сайхан болчихсон гэж бид үзэхгүй байгаа. Энэ цаашдаа улам сайн болох байх.

Тэгэхдээ шүүгчид ямар ч байсан албандаа итгэх итгэлийг бий болгосон. Шүүгчдийн цалин хангамж, нийгмийн баталгааг хангаж чадсан. Шүүхийн үйл ажиллагаа ил тод нээлттэй болох энэ ажиллагааг хийсэн л гэж ингэж бодож байгаа.

Тэгээд энэ дээр би нэг ил тод Их Хурал хэлэлцээд байна. Энэ бол нийгэмд ил тод байгаа гэж түрүүн С.Бямбацогт дарга хэлж байна лээ. Энэ яг бодит байдал дээр яг тийм байж чадаж байна уу? Энэ ил тодын асуудлаа та нэг яриач дээ. Бусад шатандаа ямар байдаг юм бэ?

Энэ шүүхийн мэргэшсэн байдал, дагнасан байдлын талаар нэг хэлж өгөөч. Одоо цаашдаа ингээд иргэний хэрэг, эрүүгийн хэрэг, эдийн засгийн гэмт хэргүүдтэй холбоотой дагнасан шүүгчид байгуулах, мэргэжлийн шүүгчид бий болгох энэ асуудал дээр энэ хуульд ямар зүйлүүд орсон бэ гэж ийм хоёр асуулт асууя.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт. Хууль зүйн байнгын хороон дарга.

С.Бямбацогт: Сая Их Хурлын дарга бас хэлсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд Монгол Улсын иргэний 18 эрх байж байгаа. Үндсэн эрхүүд нь. Түүний нэг нь тэр шударга шүүхээр шүүлгэх эрхээ хамгаалуулах.

Энэ эрхийг л хангахын тулд ерөөсөө шүүхийн хуулийн гол зорилго агуулагдаж байгаа. Өнөөдөр Монгол Улсын иргэн болгон, аж ахуйн нэгж, байгууллага болгон бүгдээрээ л шударга шүүхээр шүүлгэдэг байх юмсан. Энэ шүүгч нь хэн нэгний хараа, нөлөөнд автдаггүй байх юмсан. Ийм шүүхтэй болчих юмсан гэж бодож байгаа.

Шүүгч нар ч гэсэн хэн нэгний дарамт шахалтгүйгээр, чин шударгаар Монгол төрийнхөө төлөө хууль ёсыг дээдлээд Үндсэн хуульд заасан хүний эрхийн хангахын төлөө ажиллах юмсан гэж бүгд бодож байгаа.

Ийм учраас хүн болгон Шүүхийн тухай хуулийг харж байгаа. Анзаарч байгаа байх. Ингээд ярихаар бас хардаад байгаа юм л даа. Парламент дээр л юм гарчихдаг гээд. 76 гишүүн далан зургуулаа ярьдаг. Ажлын хэсэг дээр, Байнгын хороон дээр, чуулган дээр, эхний хэлэлцүүлэг, хэлэлцэх эсэх, эцсийн хэлэлцүүлэг гээд бүгд нээлттэй ярьдаг. Энэ нууж хаасан юм юу ч байхгүй. Одоо энд сууж байгаа Д.Ганбат гишүүн айхтар харж байна. Тийм.

Нээлттэй л ярьж байгаа. Д.Ганбат гишүүнээс нуух зүйл юу ч байдаггүй. Жишээ нь.

Тэгвэл Ерөнхийлөгч зарлиг гаргадаг. Ерөнхийлөгч зарлиг гаргахыг бид мэддэггүй. Нэг өдөр л гарчихсан байдаг. Нэг өдөр шагначихсан байдаг. Нэг өдөр шийтгэгдсэн байдаг.

Засгийн газар хуралдаанаар зөндөө олон томилгоо хийдэг. Засгийн газрын хуралдаанаар маш олон шийдвэр гаргадаг. Нэг өдөр гаргачихсан байдаг. Засгийн газар чинь бас нэг 15, 16 сайд ажиллаж байгаа шүү дээ. Ерөнхийлөгч ганцаараа Тамгын газартайгаа сууж байгаа зарлигаа гаргадаг байх.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөгөө гээд бас нэг шийдвэр, зөвлөмж гаргадаг. Тэнд бас нэг өдөр л гарчихсан байдаг.

Тэгвэл парламентаар гарч байгаа шийдвэр урьдчилаад нээлттэй, ил тод, бүхий л түвшиндээ урьдчилж хэлэлцүүлгүүдээс саналууд авч, судалгаа, шинжилгээ хийж, ингэж явж байж хуулийн төслүүд өргөн баригддаг. Энэ өргөн баригдсан төслүүдийг нь Улсын Их Хурал дээр нээлттэй хэлэлцэж байж шийдвэр гаргадаг.

Үүгээрээ үндсэндээ хангалттай хэлэлцэгдсэн, хангалттай мэдээлэл, энэ хэлэлцүүлгүүдээр дамжаад олон нийт аль нь зөв байна, аль нь буруу байна, хэн нь зөв ярьж байна, хэн нь буруу ярьж байна, үнэхээр зөв хууль гаргах гэж байна уу, буруу хууль гарах гэж байна уу гэдгийг шүүж байгаа байх, тунгааж байгаа байх.

Тийм болохоор би энэ Шүүхийн тухай хууль харьцангуй нээлттэй хийгдсэн гэж бодож байгаа.

Тэр шүүхийн харьяалалтай холбоотой асуудлаар О.Мөнхсайхан багш хариулчих уу. Дагнасан шүүх.

Г.Занданшатар: 80. О.Мөнхсайхан доктор.

О.Мөнхсайхан: Дагнасан шүүх, тойргийн шүүхийн асуудал энэ хууль батлагдсаны дараа дагаж өргөн баригдана гэж ойлгож байгаа.

Түрүүн нээлттэй, ил тод байдал хангагдсан уу, оролцоо хангасан уу гэдэг дээр нэмж хэдэн зүйл хэлэх гэсэн юм. Үндсэн хуулийн өөрчлөлтөд орсон шүүхийн тухай заалт гурав, дөрвөн жил хэлэлцэгдэж орсон. Энэ хүрээнд бүхий л санал, оролцоог хангаж явсан байгаа.

Одоо хэлэлцэж байгаа төсөл анх 2020 оны 01 сарын 31-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны сайт дээр тавигдсан. Үүнээс хойш бүтэн жил тасралтгүй санал шүүмжийг өргөн барихын өмнө болон дараа нь ямагт авч явсан. Засгийн газрын боловсруулсан ажлын хэсэг дотор шүүгч нар маш олноороо орж, хуульчид орж саналаа өгсөн байгаа.

Тэгээд өргөн баригдсаны дараа түрүүн Их Хурал дээр шат шатанд маш олон хэлэлцүүлгүүд хийсэн ажлын хэсэг ажилласан.

Энэ дээр Ерөнхийлөгчийн ирүүлсэн гол суурь зарчмын саналуудын 90 орчим хувь нь энэ төсөл рүү туссан байгаа. Ардчилсан намын бүлэг дээр ажлын хэсгийн ахлагч танилцуулга хийсэн. Дээрээс нь Ардчилсан намын бүлэг

11 сарын 05-ны өдөр хэлэлцүүлэг хийхэд дэд хэсгийн гишүүний хувьд миний хувьд бас төлөөлж очиж санал шүүмжийг сонсож байсан.

Н.Алтанхуяг гишүүн зэрэг цөөнхийн гишүүд ажлын хэсэгт маш идэвхтэй оролцож саналаа тусгаад явсан. Ийм оролцоо хангаж явж байгаа.

Нөгөө талаар хуульчдын хувьд 5 сард Нээлттэй нийгэм форум зохион байгуулаад бүтэн 5 өдөр LIVE хэлэлцүүлэг энэ төслөөр хийгдсэн. 8 сард Стратегийн академи том эрдэм шинжилгээний хурал хийж, зөвлөмжүүд гаргасан. Худалдаа аж үйлдвэрийн танхим, Улаанбаатар хотын танхим дээр бас энэ төсөл хэлэлцүүлж санал, зөвлөмжийг авсан.

Тэгээд шүүхийг дагнаж судалдаг 10 орчим хуульчид нэгдэж санал, зөвлөмж өгсний бараг 99.0 хувь нь энэ төсөл рүү туссан.

Тэгээд өнгөрсөн хугацаанд ажлын хэсгийн даалгавраар бүх судалгаануудыг шүүж тэрний Монголын нөхцөлд орж болох тэр бүх санал зөвлөмжүүд ийшээ боломжоороо тус.../минут дуусав/

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Сайнхүүгийн Ганбаатар.

С.Ганбаатар: Эрхэм гишүүд ээ, Би энэ хүний нэр ярихгүй, асуудал гарц гаргалгаатай, болохгүй байгаа зүйлийг үндэслэлтэй ярих гэж хичээдэг.

Харин та нар хариулахдаа хүний нэр хүнд рүү халдаж хариулдаг. Хэрвээ тэгвэл би асуудалдаа ялчихсан юм байна гэж ойлгоно шүү.

Нэгдүгээр асуулт. Та нарын Монгол Ардын Намын олонхын санаатайгаар Үндсэн хуульд оруулсан заалтын буянаар, өнөөдрийн хуулийн буянаар энэ хараат бус шүүх засаглал, хууль тогтоох засаглалынхаа хормой доор орлоо гэж үзэж болох уу?

Улсын Их Хурлаас Шүүхийн ерөнхий зөвлөл Сахилгын хороог томилно гэдэг бол хараат бус шүүх засаглал Монголд устлаа гэж би ойлгож байна. Ингэж үзэж болох уу? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт. Та нар Улсын Их Хурлаар энэ Шүүхийн ерөнхий зөвлөл, энэ Сахилгын хороог хачин гоё сонсгол хийж шалгаруулж сонгоно, шударга сонгоно, хараат бусаар та нарын хараатаар сонгоно гэж яриад байна. Тэгвэл Олон нийтийн радио телевизийг яг тэгж сонгодог.

Олон нийтийн радио, телевизийн хараат бус гишүүд гэж нэртэй шүү дээ. Энэ хүмүүсийг мафийн зарчмаар сонгодог. Бүлэглэлүүд хоорондоо ярьж байгаа сонгодог. Энэ олон нийтийн радио телевизийг сонгодог, энэ хараат бус гишүүдийг сонгодог байдлаасаа энэ шүүхийн Сахилгын хороог сонгодог нь ямар ялгаатай вэ? Ямар онцлог, ялгаа гарах вэ?

Миний гуравдугаар асуулт. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр шүүгч нарт хариуцлага, сахилга тооцсон шийдвэрийг цуцлах тухай ярьж эхэллээ. Тэгвэл Үндэсний аюулгүй байдлын ач буянаар ГОК-ийн 49 хувь, тэр Салхитын

мөнгөний орд, тэгээд л энэ Оюу Толгойн буруу шийдвэр гаргасан энэ асуудлуудыг засахаар одоо хууль, шүүх дээр танай дарга нар явж байгаа. Эд нар одоо бас шоронгоос гарч ирнэ гэсэн үг үү?

Энэ нааштай, нэг жаахан нар гарч байсан шийдвэрүүдээсээ Та нар ухарч буцаж байна гэж ойлгож болох уу?

Г.Занданшатар: Энэ хэлэлцэх эсэх дээр л холбоотой асуулт байна даа.

Ер нь Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1-т Монголын ард түмэн Засгийн бүх эрх мэдэл ард түмний гарт байна. Мэдэлд байна. Энэхүү эрх мэдлээ сонгосон төлөөлөгчдийн байгууллагаараа дамжуулан эдэлнэ гэж заасан байна. Энэ бол Улсын Их Хурал, төр төрийн эрх барих, сонгогдсон төрийн эрх барих дээд байгууллагаар уламжлан эдэлнэ гэсэн үг.

Тэгээд Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-т хүн халдашгүй чөлөөтэй байх эрхтэй, хуульд заасан үндэслэлээс гадуур хэнийг ч мөрдөж мөшгөх, хорих, нэгжих болон хүний нэр төрийг доромжилж болохгүй гэсэн ийм заалттай.

Тэгээд үүнийг л энэ Үндсэн хуульд хүний эрх талаасаа л хандаж суулгах нь хамгийн гол. Энэ зорилгоор л. Тэгээд шударга шүүхээр шүүлгэх хэрэгтэй.

Тэгээд хамгийн гол юм бол одоо хүртэл сайн хэрэгжихгүй байгаа юм бол байна шүү дээ, С.Ганбаатар гишүүн ээ. Үндсэн хуулийн 16.14-т түрүүн уншаагүй үлдсэн хэсэг бол тэр гэмт хэрэг үйлдсэн нь хуулийн дагуу шүүхээр тогтоолгосноос бусад тохиолдолд хэнийг ч гэм буруутайд тооцож үл болно. Гэмт хэрэг үйлдсэн гэж тооцохгүй гэж. Тэгээд одоо манайх чинь шүүхээр тогтоогдоогүй байхад хүнийг урьдчилж яллаад. Үүнийг шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг гэж үзэж болно.

Нийгмийн давлагаа үүсгэж дээр үед антихрист, сатана энэ тэр гээд ингээд шийтгэгдэж байсан тэр хэв маягаар ингэж ялладаг уур амьсгалыг дагаж хөөсөрдөг ийм асуудлыг ч гэсэн энэ Үндсэн хуульд урьдчилан харж хориглосон байдаг.

Үндсэн хуулиа яг хуульдаа тусгаж хэрэгжүүлэх нь л энэ шүүхийн хуулийн хамгийн гол зорилго байгаа шүү дээ.

Сандагийн Бямбацогт дарга асуултад хариулна.

С.Бямбацогт: Тийм. Улсын Их Хурал. Сая Их Хурлын дарга хэлсэн. Тийм ээ.

Төрийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байна. Сонгож байгуулсан төлөөлөгчөөр дамжуулж төрийн эрхийг эдэлнэ гэж. Төр барина гэж байна.

Улсын Их Хурал төрийн эрх барих бөгөөд хууль тогтоох дээд байгууллага. Төрийн гадаад дотоод бодлогын аль ч үндсийг тогтоодог. Гагцхүү хуулийг Улсын Их Хурал баталдаг.

Тийм болохоор бид ард түмний төлөөлөл. Үндсэндээ бага ард түмэн. Бага ард түмэн учраас түрүүн би хэлсэн. Энд олонх цөөнх, хөгшин, залуу гэдэг юм уу, одоо юу гэдэг юм. Мэдээлэл сайтай, мэдээлэл муутай гэсэн ойлголт байхгүй. Бүгдээрээ л хэлэлцэж байгаа шийдвэр гаргадаг.

Үүгээрээ үндсэндээ ард түмнийг төлөөлж байгаа учраас гарч байгаа шийдвэр нь бүгдээрээ хэлэлцдэг, бүлээн усаар угааж байж гардаг. Энэ үүднээсээ харьцангуй юу гэдэг юм, хэн нэгнээс хараат бус, зөвхөн Монгол Улсын эрх ашиг, ард түмний хүсэл сонирхолд нийцсэн шийдвэрийг гаргахын төлөө л бид тангараг өгч ажиллаж байгаа. Ингэж шийдвэр гаргахын төлөө ажиллаж байгаа.

Энэ үүднээсээ Шүүхийн тухай хуульд шинэчилсэн найруулга хийж байна. Үүндээ шүүхийг шударга байлгах, шүүгчийг хараат бус байлгах асуудлыг оруулж ирж байгаа.

Ингэхдээ Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгчийг сонгон шалгаруулах, томилох, энэ асуудлыг шийдэх ажлыг Шүүхийн ерөнхий зөвлөл хариуцаж байгаа. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 5 гишүүн нь шүүгч гишүүн байна. 5 нь шүүгч бус гишүүн байна. Шүүгч гишүүнийг шүүгч нар өөрсдөө дотроосоо. Шүүгч бус гишүүдийг Улсын Их Хурал нээлттэй томилгооны сонсгол хийж шалгаруулна.

Ингэхдээ Сахилгын хороог мөн адил бас. Сахилгын хороог мөн адил бас ийм зарчмаар. Ингэхдээ Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийг сонгож байгаатай адилхан биш. Хүний эрхийн Үндэсний Комиссыг сая сонгон шалгаруулалт хийсэн. Үүнтэй адилхан сонгон шалгаруулах комисстоо бид бүх талын төлөөллүүдийг байлгахаар оруулж ирж байгаа.

Энд төлөөллүүдийн бүрэлдэхүүнд нь Ерөнхий зөвлөлийн.../минут дуусав/

Г.Занданшатар: С.Ганбаатар гишүүн 1 минут тодруулъя.

С.Ганбаатар: Миний асуултад хариулсангүй.

Улс төрийн нөлөөлөлгүй, шүүх засаглалыг улс төрийн нөлөөлөлгүй болгоно л гэж байн байн ярьж байгаа. Үгүй ээ, энэ чинь Улсын Их Хурал чинь улс төрийн байгууллага.

Улсын Их Хурал үеийн үедээ энэ 30 жил бид банкны, Оюу Толгойн, Тавантолгой томоохон лобби бүлэглэлүүдийн дарамтад, нөлөөлөлд бид шаналж байгаа. Улсын Их Хуралд шүүх тогтоох шүүгч нарыг томилдог Шүүхийн ерөнхий зөвлөл, Сахилгын хороог Улсын Их Хурлаас тавина гэдэг бол бүр улс төр, эдийн засгийн бүлэглэлүүдийн хараат байдалд шүүхийг оруулж байна гэж би хараад байгаа. Үүнээс гарц гаргалгаатай. Энэ яг хэлэлцэх хэсэг дээр би бас гарц гаргалгаатай саналуудаа ярьсан. Тэгээд өнөөдөр

хуульд заасан эрхийнхээ дагуу үзэл бодлоо, бас энэ эцсийн хэлэлцүүлэг дээр байр сууриа илэрхийлж байгаа юм.

Г.Занданшатар: С.Бямбацогт дарга. Сандагийн Бямцогт гишүүн.

С.Бямбацогт: Тэгэхээр урьд нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөл. С.Ганбаатар гишүүний яриад байгаа юм Үндэсний аюулгүйн зөвлөлөөс томилж байж болдоггүй юм уу. Огцруулж, чөлөөлж болдог байсан. Үүгээрээ явчхаж болохгүй юм уу гэсэн асуудал яриад байгаа.

Энэ маань тодорхой хугацаанд таны хэлж байгаатай санал нэг байгаа. Бас үүргээ гүйцэтгэсэн үү. Гүйцэтгэсэн. Цаашдаа ийм байдлаар явж болохгүй.

Гуравхан хүнээс хараат ийм байдалтай шүүх шударга ёсыг тогтоож чадах уу, үгүй юу. Үндсэн хууль зөрчинө. Үндсэн хуульд ч ерөөсөө тодорхой заачихсан байгаа.

Шүүхийг яаж байгуулах вэ, шүүгчийг яаж томилох вэ гээд. Үүнтэй зөрчилдөж байгаа. Ийм учраас Шүүхийн тухай хуульд шүүгчийг томилох асуудлыг сая зааж өгсөн.

Тэр шүүхийг томилох, шүүгчид хариуцлага тооцох, Шүүхийн ерөнхий зөвлөл, Сахилгын хороог ажлын хэсэг байгуулахдаа Улсын Их Хурал дахь олонхоос оруулна. Цөөнхөөс оруулна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн төлөөллийг оруулна. Засгийн газрын төлөөллийг оруулна. Хүний эрхийн Үндэсний Комиссын төлөөллийг оруулна. Монголын хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбооны төлөөллийг оруулна. Хууль зүйн сургалт, судалгааны байгууллага, хууль зүйн их, дээд сургуулийн санал болгосон төлөөллөөс бүрдсэн нийт 11 хараат бус, хөндлөнгийн хүмүүс энэ сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах юм.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Цогт-Очирын Анандбазар.

Ц.Анандбазар: Баярлалаа. Өнөөдөр Улсын Их Хурал Монгол Улсын ард иргэдэд маш чухал шударга шүүх тогтолцоог бий болгох хуулийг хэлэлцэж байна.

Энэ бол цаг үеэ олсон. Магадгүй ганцхан удаа олдох ийм боломж гэж цаг үе, хугацааны хувьд харж байгаа юм.

Тэгэхээр шүүх дээр юу болж байна вэ гэдгийг бизнесийн байгууллагынхан, аж ахуйн нэгжийг удирдаж байгаа хүмүүс маш их мэддэг. Өнөөдөр анхан шатны шүүх дээр явж байгаа нийт хэргийн 70-аас 80 хувь нь аж ахуйн нэгжүүдийн хоорондын маргаан байдаг.

Аж ахуйн нэгжүүд юу хүсдэг вэ гэхээр шүүхээс нэгдүгээрт шударга шийдвэр гаргаж өгөөч ээ гэж хүсэж байгаа юм.

Хоёрдугаарт, цаг хугацааны хувьд асар богино хугацаанд үнэн шударгыг нь тогтоож өгөөч гэж хүсэж байгаа.

Гуравдугаарт, шүүхийн шийдвэр амьдрал дээр биелдэг байгаач ээ гэж хүсэж байгаа юм.

Ер нь цалин хөлс Монгол Улсын төрийн байгууллага ялангуяа асар хоцорсон шүү дээ. 100 жилээр хоцорсон. Тэгээд ямар нэгэн байгууллагын хууль хэлэлцэх болгонд тухайн салбарын цалин хөлсийг сугалж авчирч нэмээд байх ерөөсөө бодлогын хувьд алдаа гэж үзэж байгаа.

Тийм учраас хэрвээ цалин хөлсний нэмэгдэл явах юм бол шүүгчдийг хийснээр нь хувийн хэвшлийн цалин, хөлсний тогтолцоо яаж явдаг вэ. Тийм тогтолцоонд шилжүүлэх хэрэгтэй байгаа юм.

Тийм учраас ажлын хэсгийн даргаас асуулт байна. Тухайлах юм бол шийдсэн хэргээр нь, шударга шүүснээр нь, шүүхийн шийдвэр нь амьдралд хэрэгжсэнээр нь энэ нэмэгдлийг олгодог болгох ямар арга байна вэ? Шударга шийдвэрийн нэмэгдэл ч гэдэг юм уу, шүүхэд шударга ажилласны нэмэгдэл ч гэдэг юм уу.

Энэ ер нь цалингийн нэмэгдэл гэдэг бол нэмээд орхисны дараа бүх хүн мартана. Нэрийг зүүх юм бол тэр хүн насан туршдаа үүнийг санаж явна шүү дээ.

Тийм болохоор энэ бодитой нэмэгдэл болгож энэ нэмэгдэлд тусгай нэр өгч шийдэх хэрэгтэй. Хэрвээ цалин хөлсийг нэмбэл. Ер нь төрийн тогтолцооны бүх л Монгол Улсад цалингийн систем бол хуучирчхаад байгаа шүү дээ.

Тийм учраас нийт төрд ажиллаж байгаа хүмүүсийн цалингийн тогтолцоог өөрчлөх цаг болсон гэж хувийн хэвшилд ажиллаж байсан хүний хувьд боддог юм. Өнөөдөр амьдралд.../минут дуусав/

Г.Занданшатар: Ажлын хэсэг. Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Шүүхийн цалин, урамшууллын системийг үр дүнтэй нь, шударга ажиллаж байгаа тэр шийдвэр, зөрчил гаргаж байгаагүй, сахилгын шийтгэл ногдуулж авч байгаагүй, хүлээж байгаагүй тэр нөхцөл байдалтай уялдуулж тогтоох гэдэг ийм зарчмын байр суурьтай санал нэг байна.

Яг энэ агуулгаар Засгийн газраас энэ зэрэг дэвийн нэмэгдэл гэдгийн агуулгын цаана нь тэр байсан юм. Тэгэхдээ түрүүн хэлсэн. Шүүгчийг дотор нь ингэж эрэмбэлж чи илүү том дарга шүүгч, чи илүү цэрэг шүүгч гэж эрэмбэлж болохгүй учраас энэ нэмэгдэл хасагдаж байгаа.

Ер нь шүүгчийг төрийн албаны сүлжээнд багтааж цалинжуулдаг байх нь зөв юм уу, буруу юм уу. Ер нь шүүгч төрийн албан хаагч мөн үү, биш үү. Та бүхэн мэдэж байгаа. 1992 оноос, 1993 оноос хойш ингээд явсан нэг жишиг бол Ерөнхийлөгчөөсөө эхлээд Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд шүүгчдээ бүгдийг нь төрийн албан хаагч гэж нэрлээд байгаа юм. Багш эмч, бүгд төрийн албан хаагч.

Тэгээд үүнийг уг нь бусад улс орны жишиг, энэ явж ирсэн түүх, туршлага бол яг төрийн албан хаагч гэдэг бол энэ Засгийн газар, Засгийн газрын харьяа буюу гүйцэтгэх эрх мэдэлд ажиллаж байгаа албан хаагчдыг л төр гэж үзээд байгаа юм.

Улсын Их Хурал, ард түмнээс сонгогдсон мандат авсан энэ институт бол ард түмний төлөөлөгчид байхгүй юу. Ард түмний төлөөлөгчид, ард түмний дуу хоолой, ард түмний индэр.

Шүүх бол энэ ард түмний төлөөлөгчийг ч, Засгийн газар буюу төрийн албыг ч гэсэн хянаж хариуцлага тооцож байдаг тусдаа бие даасан институт.

Тийм учраас яах вэ, Төрийн албаны энэ ангилал сүлжээнээс нь цаашдаа.../минут дуусав/

Г.Занданшатар: Түрүүн яриад байсан. Одоо Ерөнхийлөгчийн засаглалтай Америкийн Нэгдсэн Улсад хүртэл сая шүүгч нарыг, Дээд шүүхийн шүүгч нарыг сенат, конгрессоороо томилж, төлөөлөгчдийн байгууллагаараа томилж байгаа биз. Ингээд нээлттэй сонсголоор.

Одоо эрхэм гишүүн Цэндийн Мөнх-Оргил.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Шүүх хуулийн найруулга...

Г.Занданшатар: Уучлаарай. Ц.Ананбазар гишүүн 1 минут тодруулъя гэсэн.

Ц.Анандбазар: Баярлалаа. Шүүхийн шүүгч нарын ачааллыг бууруулах тал дээр тодорхой шийдэл гаргамаар байна.

Одоо 2005 онд Английн Манчестер. Та бүхэн сайн мэдэж байгаа. Ажлын хэсгийн дарга Б.Энхбаяр боловсролтой залуу. Мэдэж байгаа гэж би ойлгож байгаа.

Эвлэрүүлэн зуучлах төв байгуулж жижиг үнийн дүнтэй шүүхийн асуудлыг шийдвэрлэдэг болсон. Ийм туршлага Данид ч бас гарсан байдаг. Дэлхийн олон оронд байдаг.

Тэгэхээр энэ эвлэрүүлэн зуучлах төвөөр дамжуулж жижиг үнийн дүнтэй маргааныг түргэн шийддэг болгохгүй бол шүүхийн ачаалал маш их байна. Улс төрчдийн шүүхийн асуудал маш хурдан шийдэгддэг. Аж ахуйн нэгжийнх 4-өөс 5 жилээр сунжирдаг. Энэ байдлаас болж аж ахуйн нэгжүүд дампуурах асуудалтай болчихоод байгаа юм.

Цаашлаад шинэчлэлийн бодлогын асуудал бол цахим шүүхийг шинэчлэн байгуулах асуудал онцгой чухал байна. Богино хугацаанд шүүхийн шийд гаргана гэдэг нь өөрөө шүүхийн шийдвэрийн амин чухал хэсэг шүү дээ. Хугацаа өнгөрөх тусам асар их үнэтэй болдог. Өртөг зардалтай болдог.

Тэгэхээр бид бүтцийн хувьд өөрчлөлт хийж байгаа юм чинь ийм шинэчлэлийн горимын алхмуудыг хиймээр байна. Ийм зардлыг шүүхийн салбарт тусгаж өгч.../минут дуусав/

Г.Занданшатар: Х.Нямбаатар гишүүн. Хишгээгийн Нямбаатар гишүүн. Ажлын хэсэг.

Х.Нямбаатар: Баярлалаа. Би Ц.Анандбазар гишүүний асуултад хариулъя.

Яах вэ, зүгээр тогтолцооны хувьд Англо-саксоны эрх зүйн системтэй орнуудад хэрэг маргааныг хянан шийдвэрлэдэг тогтолцоо манайхаас харьцангуй өөр.

Тухайлбал, тэнд жилд ойролцоогоор сая 500 мянга орчим жижиг хэргүүдийг магистрантууд шийддэг энэ тэр ийм тогтолцооны хувьд ялгаатай зүйл бий.

Бид ямар асуудлаар шүүхийн ачааллыг бууруулахаар төлөвлөж ажиллаж байгаа вэ гэхээр нэгдүгээрт бид эвлэрүүлэн зуучлах замаар хэрэг маргааныг шийдвэрлэдэг энэ тогтолцоо бий болгосон хууль эрх зүйн орчноо шинэчилж байгаа.

Өөрөөр хэлбэл заавал шүүхэд хандахгүйгээр өөр хоорондоо эвлэрээд нэгнийхээ өр төлбөрийг барагдуулдаг энэ тогтолцоог бий болгоё гэдэг энэ хуулийн төсөл энэ хаврын чуулганаар орохоор явж байгаа.

Хоёрдугаарт, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль 1995 онд батлагдсан.

Тэгэхээр Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дэргэдэх арбитра хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгож, тэнд бас асуудлыг шийддэг тогтолцоог оруулж ирэхээр төлөвлөөд ажиллаж байна.

Гуравдугаарт, бид хэрэглэгчийн гэрээний хууль гэдэг ийм шинэ хуулийн төслийг энэ хаврын чуулганаар өргөн барихаар төлөвлөж байгаа. Энэ юу гэвэл бизнес төв, иргэн гэдэг харилцаан дээр үүссэн маргааныг хэрэглэгчийн гэрээний хуульд заасны дагуу маргаан хянан шийдвэрлэдэг ажиллагааг бий болгохоор төлөвлөж байгаа.

Одоо бараг бүх маргаан шүүхэд очиж шийдвэрлэгддэг ийм бас тийм зөв биш тогтолцоо явж байгаа.

Хурал даргалагчаа 1 минут нэмээд өгчих. Би нэмээд хариулчихъя. Би нэг сонин жишээ хэлье л дээ. Жишээлэхэд, Баян-Өлгий аймгийн хоёр иргэн маргаад 3 ширхэг хоосон варений шилний талаар маргаан үүсгэж байгаа юм. Тэгээд энэ 3 ширхэг ширхэг хоосон варений шилний маргаан 3 шатны шүүхийг дамжиж шийдвэрлэгдсэн байгаа.

Тэгэхээр энэ бол шүүхийн ачааллыг ийм жижиг маргаанууд ихээр бий болгож байгаагийн нэг жишээ.

Нэг үүрэн телефоны оператор компани хэрэглэгчдэдээ 20 мянган төгрөгийн маргаан үүсгээд 3 шатны шүүхээр яваад шүүхийн зардал нь 4 сая төгрөгт хүрсэн ийм бас тохиолдлууд байдаг.

Тэгэхээр бид энэ болгоныг тооцоолж аль болох тодорхой төрлийн маргааныг шүүхээр шийдвэрлүүлэлгүйгээр маргаан таслах комиссуудаар шийдвэрлэдэг, эвлэрүүлэн зуучлуулдаг. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дэргэдэх арбитрт маргааныг шийддэг энэ жишиг рүү явахаар энэ Шүүхийн тухай хууль, түүний араас дагаж гарах хуулиуд, энэ шүүгчдийн ачааллыг бууруулахад чиглэгдэж байгаа юм.

Эцэст нь нэг зүйлийг нэмээд хэлэхэд бидний хамгийн том хуулийн төсөл бол 3 дугаар сарын 15-нд эхлэх чуулганаар орж ирнэ. Энэ бол Шүүх байгуулах хууль.

Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд тойргийн зарчмаар шүүх байгуулахаар төлөвлөн ажиллаж байгаа. Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэж Засгийн газар Их Хуралд оруулж ирэхээр төлөвлөж байгаа гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Цэндийн Мөнх-Оргил.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Шүүхийн хуулийн шинэчилсэн найруулгын хэлэлцүүлэг ер нь өндөрлөх шат руугаа орж байна.

Тэгээд би зүгээр нэг ийм санаа хэлэх гэсэн юм. Энэ зааланд сууж байгаа хүмүүс нэг хоёр юмыг л бид мэдээд, мэдрээд байгаа юм.

Нэгдүгээрт, шүүх гэдэг бол хэцүү ажилтай хүн. Амаргүй. Юмны үнэн зөвийг дэнсэлнэ, шийдвэр гаргана, хүнд ял онооно. Энэ бол маш хэцүү ажил. Стресстэй, ачаалалтай. Мань мэт бол хийж чадах ч үгүй, нойр хүрэх ч үгүй.

Тэгэхдээ бид үүнийг нь ойлгож байгаа учраас нийгмийн хамгааллын асуудал, энэ шүүгч нарыгаа хамгаалах, хараат бус байх бололцоог нь бүгдийг нь бүрдүүлэхийн төлөө их зүйл хийсэн.

Цаашид ч гэсэн нийгмийн асуудал, цалин хөлсний асуудлыг Засгийн газарт даалгавар болгоод л оруулаад ир гээд л. Сая Х.Нямбаатар сайдын хэлж байгаа ачааллыг бууруулах, тэр жижиг хэргийн маргааны шүүх байгуулах гээд. Энэ ажлыг бид хийнэ. Энэ ажлыг хийнэ. Үүнийг та нар итгэлтэй байж болно.

Хоёр дахь, бидний мэдээд байгаа юм бол байна шүү дээ. Ер нь манай шүүгч нар үндсэндээ нийгмээс бүр тас вакуумжиж, бүр тас вакуум.

Бид нар ингээд вакуумжсан л гээд байдаг. Бид нар чинь бас нэг иргэд сонгогчидтой, дөрвөн жилдээ сонгуультай учраас бас иргэдтэйгээ холбоотой байдаг юм байна.

Шүүгч нар бол ерөөсөө ажил, мэргэжлийн онцлогоосоо шалтгаалаад тэгээд хүнтэй уулзаж болохгүй, хүнтэй хамаагүй юм ярьж болохгүй гэсэн хуулийн шаардлагаа дагаад ерөөсөө бүрэн вакуумжиж.

Сая хуулийн төсөл хэлэлцэж байхад л, хуулийн төсөл ажлын хэсэг дээр ажиллаж байхад л шүүгч нартай уулзахад л ерөөсөө бүр нүд нь эргэлдээд л тэгээд байгаа шүү дээ. Бид ерөөсөө нөлөөнд автагддаггүй гээд л. Автагддаггүй шүү дээ. Ерөөсөө автагддаггүй. Улс төрийн нөлөөнд ч автагддаггүй, мөнгөний нөлөөнд ч автагддаггүй. Хэн нь автагдаад байдаг юм бэ гээд л ингээд л.

Тэгээд энэ чинь нөгөө шүүгчид өөрсдийгөө яаж үнэлээд байгаа, нийгэм шүүгчдийг яаж үнэлээд байгаа хоёрын хооронд асар их зөрүү гарчхаад байна.

Тэгэхлээр шүүгч нар маань та нар энэ хуулийн хэлэлцүүлэг, энэ юмнаас гарч одоо.../минут дуусав/

Г.Занданшатар: Ц.Мөнх-Оргил гишүүнд 1 минут.

Ц.Мөнх-Оргил: Дүгнэлт хиймээр байна.

Тэгээд би зүгээр нэг л зүйлийг хэлье гэж бодож байна.

Улсын Их Хурал Монголын шүүх, шүүгч нарт боломж олголоо шүү. Боломж олголоо. Одоо та нар энэ нэг, хоёр, гурван жилийн дотор өөрсдийгөө дотроосоо цэвэрлээрэй. Цэвэрлээрэй.

Цэвэрлэж чадахгүй бол энэ зааланд ярьж байгаа хүмүүсийн бухимдал, уур хилэн, та нарт хаяад байгаа хатуу ширүүн үг чинь бид нарын үг биш шүү. Бид нарын үг биш. Бид нар зүгээр дамжуулагч нар. Энэ нийгэм чинь өөрөө та нарт бухимдаад, уурлаад, гомдоод байна.

Үүний үр дагаврыг та нар тооцоорой. Хэрвээ хоёр, гурван жилийн дотор ажлаа цэгцэлж чадахгүй бол Улсын Их Хурал дараагийн ажил алхам хийхээс өөр аргагүй болно шүү. Бүтнээр нь цэвэрлэх тал руугаа явна шүү. Бүтэн цэвэрлэгээ хийх тал руугаа явна шүү. Аттестатчилал бол аттестатчилал. Эсвэл тэр Гүржийн М.Саакашвили шиг 500 шүүгчээ 500-г нь сольдог арга руу явахаас өөр аргагүй болж байна шүү. Боломж гэж ойлгоорой.

Г.Занданшатар: Ц.Цогт шүүгч юу гэж үзэж байна. Ц.Цогт шүүгч асуултад хариулъя. 86 байна уу?

Ц.Цогт: Ц.Мөнх-Оргил гишүүний хэлсэн саналтай холбоотой товчхон тайлбар хэлье л дээ.

Мэдээж энэ шүүгч нар өөрсдөө тангараг өргөсөн, өөрийн ажилтай, амьдралтай, нэртэй төртэй улсууд байгаа учраас өргөсөн тангараг, нэр хүндээ бодож ажил хөдөлмөртөө ханддаг.

Тэр тодорхой хэрэг дээр гарсан нөлөөллийн асуудал ярьж байна уу, эсвэл үүнийг одоо нөгөө төсөөллийн нөлөөлөл гэдэг асуудал ярьж байна уу, үгүй юу гэдэг бол өөрөө их хол зөрүүтэй.

Тэгэхээр энэ талаар хийсэн судалгаа байдаг. Яг шүүхээр үйлчлүүлсэн иргэдэд иргэд шүүхийг нөлөөнд автдаг эсэх талаар хэлж байгаа, шүүхэд итгэж байгаа хувь бол өөр тоо гардаг. Шүүхээр үйлчлүүлээгүй, сургаар, дамаар ярьж байгаа дүн бол бас их тийм доогуур дүн гардаг шүү. Тэгэхээр энэ ялгааг мэдээж харна биз дээ.

Хоёрдугаарт, шүүх, шүүгч нар өөрсдөө олон нийтийн итгэлийг олж авах, олон нийтийн итгэлийг төрүүлэхүйцээр ажиллах чиглэлд бас ажил хийж байгаа.

Энэ чиглэлээрээ цаашид ч гэсэн энэ хуулийн шинэчлэлийн дагуу бид ажиллах боломжтой гэж бодож байна.

Г.Занданшатар: Ер нь энэ сануулгыг ард иргэдийн зүгээс гарч байгаа санал, шүүмжлэлтэй холбогдуулаад нийт шүүгчдийн чуулгантай болно. Хуучин шүүгчдийн зөвлөл гэж явсан. Үүгээрээ онцгой анхаарч өөрөө өөрийгөө засагладаг тэр шүүхийн өөрөө удирдах ёсыг бие даасан засаглалынх нь хувьд хангасан энэ зарчмыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу шүүхийн хуульд тусгаж байна шүү дээ. Тийм ээ.

Тийм учраас Америкийн **Жон Локк** /John Locke/ гээд хүн хэлсэн байдаг. **“Шүүх засаглал авлигад идэгдээд асуудалд орох юм бол өөрөө өөрийгөө хамгаалдаг систем бүрдтэл нь хууль тогтоох дээд байгууллага, гүйцэтгэх засаглалаас хяналт тавих үүрэгтэй.”** гэж.

Тэгээд **“Хууль тогтоогчид шүүгчдийг авлигачид гэж үздэг. Шүүгч нар хууль тогтоогчдыг мэдлэг боловсролгүй амьтад гэж үздэг.”** гэж Америкийн тэр эрдэмтэн бичсэн байдаг нь хаана ч байдаг мөнхийн сэдэв юм шиг байгаа юм. Энэ бол ард иргэд бүгдийг нь шүүмжилдэг гэж.

Одоо ингээд эрхэм гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тэгэхээр юуны өмнө Хууль зүйн байнгын хороо, ажлын хэсэгт талархал илэрхийлэхийг хүсэж байна.

Гишүүддээ ч бас талархал илэрхийлье.

Шүүх засаглал гэдэг маш том засаглал. Үүнийг зөв зүйтэй явуулах, хараат бус байлгах, хууль зүйн талаар бүх зарчим, процессын асуудлыг нь хуульд зааж, ингээд сайн сайхан явуулах тал дээр засан залруулж байгаа ийм хууль орж ирж байгаа.

Дээрээс нь ажлын хэсэг болоод Хууль зүйн байнгын хороо маш сайн ажилласан гэдгийг бүр цохон тэмдэглэхийг хүсэж байна. Гишүүд маань янз янзын асуудлууд асууж байна.

Түрүүн бас хэллээ. Энэ асуугаад байгаа асуудлууд үнэхээр. Ц.Мөнх-Оргил гишүүн хэлсэн байх аа. Ард иргэдийн асууж байгаа асуулт юм шүү. Түүнээс биш хэн нэгэн гишүүн өөрийнхөө хэмжээнээс асуугаад байгаа юм биш үү. Энэ бол ерөөсөө ард иргэдийн төлөөлөл гэдэг утгаараа ард иргэдийн гаргаж байгаа. Тэнд шүүхэд хандаж байгаа хандлагын илэрхийлэл гэдгийг шүүгчид маань болоод бас хууль хэрэгжүүлж байгаа хуулийн байгууллагууд маань, шүүхийн байгууллагууд маань бас сайн анхаарч хандаарай гэж хэлж байна. Хэлэхийг хүсэж байна.

Хууль хэлэлцүүлэх явцад бид маш олон зүйлүүдийг ярьсан. Одоо ингээд хууль маань үндсэндээ батлагдаад явах тийшээгээ хандлаа. Нэлээдгүй сайн хууль гарсан гэж үзэж байгаа шүү. Энэ бол ард иргэдэд зөв ойлголтыг өгөх ёстой. Маш сайн хууль гарч байгаа. Ер нь том шинэчлэлийг бид энэ хуульд хийж чадсан.

Цааш нь нэг зүйлийг анхааруулж хэлмээр байна. Энэ Хууль зүйн байнгын хороо болоод энэ ажлын хэсгийнхэн ер нь цаашаа хууль амьдрал дээр шигтгэгдэж очих тал дээр маш сайн анхаарлыг хандуулах хэрэгтэй байна. Хууль хэрэгжүүлдэг байх, хуулиа дагаж мөрддөг байх, нэг мөр ойлголтыг авдаг байх тал дээр тэр тусмаа Хууль зүйн байнгын хороо цаашаагаа тэр хуулийн байгууллагууд болон Шүүхийн ерөнхий зөвлөл, тэгээд Сахилгын хороо болоод ингээд бидний сая шинэчлэл хийж оруулж ирсэн маш том шинэчлэлүүдийг амьдралд суулгахад том анхаарлыг хандуулж ажиллах нь зүйтэй шүү гэдгийг сануулж хэлье.

Хоёрдугаарт, Хуульчдын холбоо гэдэг нэг байгууллага байгаа.

Ер нь хуульч хүн гэдэг бол.../минут дуусав/

Г.Занданшатар: Ж.Бат-Эрдэнэ гишүүн. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн 1 минут.

Ж.Бат-Эрдэнэ: Хуульч, шүүгч гэдэг хүн бол шүүн таслах үйл ажиллагааг. Зөвхөн шүүн таслах үйл ажиллагаа. Түүнээс гадна судалгаа болон шинжлэх ухааны үйл ажиллагаанд оролцох ийм л эрхтэй хүмүүс шүү дээ.

Ц.Мөнх-Оргил гишүүн түрүүн хэллээ. Өөрсдийгөө вакуумжуулдаг. Энэ чинь хуулийн өөрсдийн, шүүгчдийнх нь, өөрсдийнх нь нөхцөл байдлынх нь үүднээс өөрөө өөрсдийгөө вакуумжуулаад явж байгаа ийм нөхцөл байдалтай.

Гэтэл Хуульчдын холбоон дотор шүүгчдийг оруулаад байдаг явдлыг зогсоож байгаа байх. Зогсоож байгаа. Энэ дээр бас том анхаарлыг хандуулж цааш цаашдаа амьдралд энэ Шүүхийн тухай хууль хэрэгжүүлэх тал дээр маш том анхаарлыг хандуулах нь зүйтэй шүү. Энэ дээр Байнгын хороо болоод л одоо бусад байгууллагууд хамтарч ажиллах нь зүйтэй юм гэдгийг цохон тэмдэглэе.

Тэгээд нэг том зүйлийг дахин хэлэхэд Сахилгын хороо гэдэг Үндсэн хуульд заасан том байгууллагыг бид бий болгосон шүү гэдгийг ард түмний өмнө энэ Улсын Их Хурлынхаа ажлын хэсэг болон бусдыг төлөөлж хэлэхийг хүсэж байна. Сахилгын хороо Үндсэн хуульд зааж түүнийхээ дагуу түүний процессыг ямар нэгэн журмаар зохицуулагддаг биш, хууль дотор процессыг.../минут дуусав/

Г.Занданшатар: Баярлалаа. Үндсэн хуульд Сахилгын хорооны бүтэц бүрэлдэхүүн, ажиллах журмыг хуулиар тогтооно гэж заасан байгаа. Тийм учраас хуулиар тогтоож байгаа.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. 28 санал байгаа. Гишүүд бэлтгэлээ хангаарай.

Бэлтгэл хангаж байх хооронд мэндчилгээ дэвшүүлнэ. Энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүддээ мэндчилгээ дэвшүүлье.

Өнөөдөр буюу 01 дүгээр 14-ний өдөр манай Улсын Их Хурлын эрхэм гишүүн Дамдины Цогтбаатар мэндэлсэн байна. 01 дүгээр сарын 15-ны өдөр эрхэм гишүүн Даваажанцангийн Сарангэрэл энэ ертөнцөд мэндэлж төржээ.

Ингээд Даваажанцангийн Сарангэрэл, Дамдины Цогтбаатар нарын гишүүддээ төрсөн өдрийн мэнд хүргэж, эрүүл энх, аз жаргал, ажлын амжилт, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. /алга ташив/

Одоо зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Хоёр гишүүнийг дэлгэн дээр гаргаарай.

Төрсөн өдрийн мэнд хүргэе.

Одоо Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх саналын томьёоллоор санал хураалт явуулна.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын “гэж” гэсний дараа “эрүү, иргэн, захиргаа зэрэг” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “хэргийн” гэсний дараа “зэрэг” гэж тус тус нэмэх.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Улсын Их Хурлын даргаас гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу энэ дагнасан шүүхүүдийг шүүхийн мэргэшсэн байдлыг хангах, дараагийн дараагийн заалтуудтай уялдуулж оруулахаар чиглэл өгсөн.

Энэ 3.1.2 дээр байсан заалтыг 3.1 дээрээ оруулаад цэгцэлсэн юм байна.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Энэ туршилтын санал хураалт. Бүртгэлийн санал хураалт явуулъя.

My Parliament-аар л даа.

Санал хураалтад 62 гишүүн оролцож, 40 гишүүн дэмжсэн. 22 гишүүн нь бүртгэлээс гадуур гарч. Энэ гишүүдийг ярьж нөхцөлийг нь хангуулна.

Ингээд саяны уншсан 1 дүгээр заалтаар санал хураалт явуулъя.

Санал хураалтад 62 гишүүн оролцож, 49 гишүүн дэмжиж, 49.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “дөрвөн” гэснийг “хоёр” гэж өөрчлөх.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Төсөөлөл дээр “Шүүгчдийн зөвлөл” гэж байсныг “Шүүгчдийн нийт чуулган” болгоод, 4 жил болгосон. Төсөл дээрээ 2 жил байсан юм. Тэгэхээр 2 жилээр болгож байгаа.

Санал хураалтад 62 гишүүн оролцож, 48 гишүүн дэмжиж, 77.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсгийн “сонгосон” гэсний дараах “шүүгч” гэснийг хасах.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 62 гишүүн оролцож, 51 гишүүн дэмжиж, 82.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Төслийн 20 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 20.13 дахь хэсэг нэмэх:

“20.13.Энэ хуулийн 20.2.3-т заасан тайланг нийт шүүгчийн чуулганаар сонсохдоо хэлэлцүүлэг явуулахгүй бөгөөд дүгнэлт, шийдвэр гаргахгүй.”

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 62 гишүүн оролцож, 48 гишүүн дэмжиж, 77.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Төслийн 22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.9.Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар гаргасан албан ёсны тайлбар, Улсын дээд шүүхээс хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад ач холбогдолтой гэж үзсэн шийдвэрийг “Төрийн мэдээлэл” эмхтгэлд нийтэлнэ.”

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 62 гишүүн оролцож, 52 гишүүн дэмжиж, 83.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 24 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 24.5 дахь хэсэг нэмэх:

“24.5.Шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй хэрэг, маргааны талаар сургалтын хөтөлбөр, арга зүйд тусгахыг хориглоно.”

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 62 гишүүн оролцож, 52 гишүүн дэмжиж, 83.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.8.8 дахь заалт нэмэх:

“25.8.8.улс төрийн намын бүртгэл хөтлөх;”

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 62 гишүүн оролцож, 84 гишүүн дэмжиж, 87.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Х.Нямбаатар сайд аа. Цаашдаа улсын төрийн намын бүртгэлийг Сонгуулийн ерөнхий хороон дээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр нөгөө сонгогчдын тоотой уялдаж байгаа учраас сонгогчдын тоо Сонгуулийн хороо, Улсын бүртгэлийн газар л байдаг учраас уг нь тийшээ л. Бусад дийлэнх улс тийм л юм билээ.

Дээд шүүх бүртгэдэггүй. Сонгуулийн хороон дээрээ л бүртгэдэг юм билээ.

8.Төслийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн “тухай саналыг Ерөнхийлөгчид, Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулах тухай албан бичгийг Улсын Их Хуралд холбогдох баримт бичгийн хамт хүргүүлнэ” гэснийг “саналыг, Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулснаар томилуулах саналыг Ерөнхийлөгчид хүргүүлнэ” гэж өөрчлөх.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 63 гишүүн оролцож, 52 гишүүн дэмжиж, 82.5 хувийн саналаар санал дэмжигдсэн.

9.Дээрх 8 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 36.2, 36.3 дахь хэсэг болгох:

“36.2.Улсын Их Хурал Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 104 дүгээр зүйлд заасан журмын дагуу танилцана.

36.3.Ерөнхий зөвлөл энэ хуулийн 36.2-т заасны дагуу Улсын Их Хурал танилцсан нэр дэвшигчийг долоо хоногийн дотор Улсын дээд шүүхийн шүүгчээр томилуулах саналыг Ерөнхийлөгчид хүргүүлнэ.”

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 63 гишүүн оролцож, 54 гишүүн дэмжиж, 85.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 46 дугаар зүйлийн гарчгийн “Шүүгчийн” гэсний өмнө “Шүүх,” гэж нэмж, 46.5 дахь хэсгийн “хүндэтгэлийн” гэснийг “хүндэтгэл, энэ хуулийн 15.6-д заасны дагуу томилолтоор ажиллах” гэж өөрчлөх.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 64 гишүүн оролцож, 52 гишүүн дэмжиж, 81.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11 дээр Д.Адьяа гишүүн үг хэлье гэж санал ирүүлсэн байна. Д.Адьяа гишүүн.

11.Төслийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 46.7 дахь хэсгийн “журам, шалгуур үзүүлэлтийг” гэснийг “шалгуур үзүүлэлт, шүүгчид нэмэгдэл урамшуулал олгох журмыг” гэж өөрчлөх:

“46.2.Шүүгчийн цалин хөлс нь албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн албанд ажилласан хугацааны, докторын зэргийн нэмэгдлээс бүрдэнэ.”

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Д.Адьяа гишүүн. Ширнэнбаньдын Адьяа гишүүн.

Ш.Адьяа: Та бүгдийн өнөөдрийн амгаланг айлтгая.

Энэ шүүгчийн цалин хөлстэй холбоотой энэ асуудал бол шүүхийн хараат бус байдлыг хангах нэг шалгуур үзүүлэлт байгаа.

Энэ шүүгчдийн цалин хөлс, түүний хангамжтай холбоотой асуудлаар энэ шүүхийн хэлэлцүүлгийн үед улс төрчид маш их улстөржиж олон талаас нь их шүүмжлэлтэй хандсан.

Өнөөдөр шүүхээр ажиллаж байгаа Монгол Улсын иргэд тодорхой эрхийн хязгаарлалттай ийм нөхцөлд ажиллаж байгаа. Ийм онцгой субъект гэж ойлгож болно.

Гэтэл Засгийн газраас өргөн мэдүүлсэн тэр шүүгчдийн цалинг хөлсний итгэлцүүр буурсан нь үнэн. Энэ дээр бас Улсын Их Хурал, Засгийн газар дүгнэлт хийж дараа нь Шүүхийн хууль хэлэлцэхтэй холбогдсон энэ улс төрийнхөө хөөрлийг дарж дахиж энэ Засгийн газар энэ шүүгчдийн цалин хөлстэй холбоотой асуудлыг оруулж ирэх байх гэж найдаж байгаа.

Одоо нэгэнт энэ асуудал дахиж яригдахаас өнгөрсөн учраас би зориуд протоколд тэмдэглүүлж ингэж оруулж байгаа юм.

Шүүгчийн шүүн таслах ажиллагааны нэмэгдлийг шүүгчийн авч байгаа албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар олгоно гэсэн Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт өнөөдөр батлагдах гэж байгаа. Энэ санал дээр Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат бид нар 45 болгоё гэдэг ийм зарчмын зөрүүтэй саналыг оруулсан юм. Энэ дээр улс төржсөн тийм асуудал ерөөсөө яриагүй.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төсөл дээр 75 гэж байгаа. Гэтэл үүнийг нь Хууль зүйн байнгын хороо 40 болгосон. Үүнийг нь 45 болгоё л гэдэг ийм саналыг оруулсан юм.

Ер нь энэ Засгийн газрын хуулиар өргөн мэдүүлсэн энэ шүүгчдийн цалин хангамжийн асуудал бол зүгээр нэг шүүгч энэ хүмүүст Улсын Их Хурал, Засгийн газраас шууд бусад иргэд, төрийн албан хаагчдаас илүү хэмжээний мөнгө төгрөг олж ямар нэгэн ийм харж үзэж байгаа асуудал биш шүү. Энэ бол үнэхээр шударга шүүхээр шүүлгэх, шүүхийн хараат бус байдлыг хангах талаар Монголын төрөөс авч хэрэгжүүлэх ийм арга хэмжээний нэг л хэсэг байгаа.

Гэтэл өнөөдөр маш их хэмжээний цалин хөлс авч байгаа мэтээр төр энд Улсын Их Хурал, Засгийн газар энд шүүгчид илүү их хангамж эдлүүлж байгаа мэтээр өнөөдөр.../минут дуусав/

Г.Занданшатар: 1 минут байхгүй.

Энэ нөгөө дагалдах хууль дээр энэ хувь яригдана шүү дээ. Шүүгчийн урамшуулал олгох тогтоолтой холбоотойгоор Төрийн албаны зөвлөл ингээд онцгой нөхцөлийн юманд. Тэр үед ярих сэдэв байна.

Тэгэхдээ 47 дугаар зүйл чинь. Энэ чинь дараагийнх нь. Ингээд санал хураалт явуулъя.

Сая Ш.Адьяа гишүүний хэлсэн саналтай холбогдуулаад тодруулж тайлбарлахад шүүгчдийн цалинг бууруулах асуудал огт яригдаагүй. Харин

онцгой нөхцөлийн болон докторын зэрэг, нэмэгдэл, ажилласан жилийн, төрийн албанд ажилласан хугацааны нэмэгдлээс бүрдэнэ гэж тодруулж байгаа.

Энэ нэмэгдлүүд нь одоо дагалдан гарах хууль тогтоолуудад тусгалаа олж эцэслэн хэрэгжинэ. Үүнтэй холбогдуулаад 47 дугаар зүйл хасагдаж байгаа нь шүүгчийн эдийн засгийн баталгаа гэж Үндсэн хуульд заасан тэр шүүхийн эдийн засгийн баталгааг төрөөс хангана гэсэн заалттай уялдуулж ярьж байна шүү дээ.

12.Дээрх 11 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 47 дугаар зүйлийг хасах.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

13.Төслийн 48 дугаар зүйлийн 48.2.1 дэх заалтын “өв залгамжлагчид” гэснийг “гэр бүлд” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 48.9 дэх хэсэг нэмэх:

“48.9.Шүүгчийг өндөр насны тэтгэвэрт гарахад түүний авч байсан сарын дундаж цалингийн хэмжээгээр 36 сарын хугацаагаар тооцож нэг удаагийн тэтгэмж олгоно.”

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо.

Түрүүчийн санал хураалтад 64 гишүүн оролцож, 50 гишүүн дэмжиж, 78.1 хувийн саналаар санал дэмжигдсэн.

Өмнөх санал ч гэсэн 64 гишүүн оролцож, 50 гишүүн дэмжиж, 78.1 хувийн саналаар санал дэмжигдсэн.

Төмөрбаатарын Аюурсайхан гишүүн үг хэлнэ. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлнэ.

Т.Аюурсайхан: 48.9. Энэ эцсийн найруулга дээрх саналыг дэмжиж байгаа.

Өмнө нь энэ 36 сарын нэг удаагийн тэтгэмжээс гадна одоо үндсэн цалингийн 80 хувиар тэтгэврийг тогтооно гэдгийг Улсын Их Хурал дэмжээгүй.

Тэгээд энэ авч байгаа цалингаас бас тооцогдоно. Энэ тэтгэвэр бол. Тэгэхээр энэ авч байгаа цалинг Улсын Их Хурал бууруулаагүй. Төрийн албан хаагч нартай харьцуулахад өөр жишгээр тогтоодог. Доод тал нь 2 сая 700, дээд тал нь 3 сая 300 мянган төгрөгийн үндсэн цалинтай.

Тэгээд цалин хөлсийг юу гэж ойлгох вэ гэхээр эрх зүйн ойлголтоороо, эдийн засгийн ойлголтоороо цалин хөлс бол “үндсэн цалин, түүний нэмэгдлээс тогтоно” гэж байгаа юм. Гэтэл мэдээллийн юун дээр болж явж байна вэ гэхээр би одоо нөгөө татвараа хасагдаад гар дээрээ төдийг авч байгаа гэж яриад Улсын Их Хурлын гишүүдээс буруу ярьж байна гээд байгаа юм.

Тэгээд сая Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тодруулах гээд байна лээ л дээ. Жишээлбэл, 35 жил ажилласан шүүгч нэмэгдэл нь 84.7 хувь болоод 6 сая 97 мянган төгрөгийн цалинтай. Үнэн биз. Жагсаалтаараа. Үнэн гэж байна.

Тэгэхээр юун дээр сая алдах гэж байсан бэ, ямар юм оруулж ирээд бас хэм хэмжээг алдагдуулсан бэ гэх юм бол энэ ажилласан жил болгон өссөн дүнгээр өмнөх оныхоосоо 2 хувиар нэмэгдээд тэгээд түүний дээр төрийн албанд ажилласан нэмэгдэл буюу 5-аас 25 хувь. Одоо энэ онцгой нөхцөлийнх гэж байгаа. Үүнийг хуульчлаад журамлаад тогтооно гэж байгаа. 40 гэж бодох юм бол.

Тэгээд докторын зэрэг 15-аас 20. Тэр болгон, хүн болгонд биш байх л даа. Ингээд бодох юм бол одоо энэ нэмэгдсэн 35 жил ажилласан 84.7 хувь дээрээ нэмээд төрийн албанд ажилласан 26-аас дээш ажилласаны 25 хувь нь нэмэгдээд. Дээр нь энэ онцгой нөхцөлийн одоо 40 хувиар тогтооно гэдгийг хэлэлцэх юм шиг байна. Ингээд нэмэгдэхээр энэ чинь хэм хэмжээ нь хэтэрч байгаа биз дээ.

Тийм учраас энэ асуудал нь дэмжигдээгүй юм. Энэ бүх цалин хөлснөөс 80 хувиар тооцогдож тэтгэвэр тогтоогдоно гэдгийг нь Улсын Их Хурал дэмжээгүй юм. Ингэж нэг мөр ойлголтын зөрүүгээ ярихгүй бол шүүгч нарын үндсэн цалинг бид хасаагүй.

Ер нь явдгаараа явж байгаа. Нэмэгдэл нь ахисан жилээр 2 хувь явж байсан бол дахиад нэмээд түүнтэй дүйцэхүйц 25 хувь одоо ингээд 40 дээр 25, 65 хувь. Ингээд хэрвээ доктор болбол 85 гээд. Тэгээд дахиад бас нэг 2 хувийн 85 хувь. Ингээд зуун хэдэн хувь болгох гээд байгаа биз дээ.

Тэгээд аль нэгээр нь яв гэдэг зарчмын асуудал л бид тавьсан шүү дээ. Ингэж хэм хэмжээг алдагдуулж болохгүй. Тэгээд харин эцсийн найруулга дээр нь үүнийг засаж залруулсан учраас би дэмжиж байна гэж яриад байгаа шүү дээ.

Г.Занданшатар: Тэгээд энэ хоёр бол өв залгамжлагчид гэдгийг гэр бүлд гэж 41 дэх санал хураалт дээр хамт ороод 80 хувь гэдгийг нь ингээд багцлаад санал хураасан учраас тэтгэвэр тогтооход цалингийн 80 хувиар гэдгээс болоод бүхэлдээ унасан юм.

Тэгээд 80 хувь гэдгийг хасаад дахиж хураагдаж байгаа ийм санал хураалт байна. Ингээд санал хураалт.

Санал хураалтад 64 гишүүн оролцож, 42 гишүүн дэмжиж, 65.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ дээр С.Бямбацогт дарга, Б.Энхбаяр гишүүн. Нэг ийм юм яваад байна шүү.

Төсвийн зардал нэмэгдүүлэхээр бол Засгийн газрын саналыг заавал сонсоно гэж дэгийн тухай хуулийн 34.5-д байх. 35.4-т байгаа.

14.Төслийн 50 дугаар зүйлийн 50.8 дахь хэсгийн “тухайн шүүгчийг оролцуулан” гэснийг хасах.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 64 гишүүн оролцож, 54 гишүүн дэмжиж, 84.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Төслийн 58 дугаар зүйлийн 58.1.6 дахь заалтын “51.1.23” гэснийг 58.1.7 дахь заалтад шилжүүлэх.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 64 гишүүн оролцож, 53 гишүүн дэмжиж, 82.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Төслийн 77 дугаар зүйлийн 77.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“77.10.Ерөнхий зөвлөлийн шүүгч биш гишүүний албан тушаалын зэрэг зиндаа, цалин хөлс, нэмэгдлийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно.”

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 64 гишүүн оролцож, 53 гишүүн дэмжиж, 82.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Төслийн 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсгийн “дийлэнх” гэснийг хасах.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 64 гишүүн оролцож, 51 гишүүн дэмжиж, 79.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Төслийн 96 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 96.21 дэх хэсэг нэмэх:

“96.21.Сахилгын хорооны төсвийг боловсруулж батлахад энэ хуулийн 46.8-д заасан журмыг баримтална.”

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 64 гишүүн оролцож, 53 гишүүн дэмжиж, 82.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Төслийн 98 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 98.4, 98.5 дахь хэсэг нэмэх:

“98.4.Сахилгын хорооны гишүүн энэ хуулийн 44.2-т заасан этгээдтэй уулзсан, харилцсан бөгөөд уг этгээд өөрөө, эсхүл бусдаар дамжуулан аливаа хэлбэрээр нөлөөлсөн, нөлөөлөхөөр оролдсон, үүрэг, чиглэл өгсөн бол энэ талаарх мэдээллийг агуулсан тэмдэглэл үйлдэн Сахилгын хороонд битүүмжлэн ажлын гурван өдрийн дотор хүргүүлэх үүрэгтэй.

98.5.Сахилгын хороо энэ хуулийн 98.4-т заасны дагуу битүүмжлэн ирүүлсэн тэмдэглэлийг хадгалах бөгөөд Сахилгын хорооны гишүүний өөрийнх нь, эсхүл эрх бүхий байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдэд гарган өгнө.”

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 64 гишүүн оролцож, 54 гишүүн дэмжиж, 84.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Төслийн 84 дүгээр зүйлийн 84.9 дэх хэсгийн, 99 дүгээр зүйлийн 99.6 дахь хэсгийн “106.1.1-106.1.4-т заасан эрхийг эдэлнэ” гэснийг “103.1.1, 103.1.2-т заасан эрх эдэлж, 103.2-т заасан үүргийг биелүүлнэ” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 64 гишүүн оролцож, 55 гишүүн дэмжиж, 85.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Төслийн 100 дугаар зүйлийн гарчгийн “гишүүнийг” гэсний дараа “чөлөөлөх,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 100.1 дэх хэсэг нэмэх:

“100.1.Сахилгын хорооны дарга, гишүүнийг дараах үндэслэлээр үүрэгт ажлаас нь чөлөөлнө:

100.1.1.бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон;

100.1.2.өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн, эрүүл мэндийн байдал, бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;

100.1 .3.өөрөө хүсэлт гаргасан.”

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 64 гишүүн оролцсон. 57 гишүүн дэмжиж, 89.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22.Төслийн 103 дугаар зүйлийн 103.2.2, 103.2.4 дэх заалтын “Сахилгын хорооны” гэснийг, мөн зүйлийн 103.2.3 дахь заалтыг тус тус хасах.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 64 гишүүн оролцож, 54 гишүүн дэмжиж, 84.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23.Төслийн 105 дугаар зүйлийн 105.2 дахь хэсгийн “энэ хуулийн 105.1-д зааснаас бусад тохиолдолд” гэснийг хасаж, 105.4 дэх хэсгийн “энэ хуулийн 105.2, 106.11-д зааснаас” гэснийг “сахилгын хэрэг үүсгэх тухай болон Сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамжаас” гэж өөрчлөх.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 64 гишүүн оролцож, 55 гишүүн дэмжиж, 85.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

24.Төслийн 106 дугаар зүйлийн 106.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 106.13 дахь хэсэг нэмэх:

“106.6.Илтгэгч гишүүн дараах үндэслэлээр сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг захирамж гарган түдгэлзүүлнэ:

106.6.1.сахилгын хэргийн оролцогч хүнд өвчний учир эмчлүүлж байгаа бөгөөд төлөөлөгч томилох боломжгүй;

106.6.2.сахилгын хэрэг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэсэн;

106.6.3.энэ хуулийн 107.7-д заасан ажиллагаа явуулж байгаа;

106.6.4.холбогдох шүүгчид үүсгэсэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхээс өмнө сахилгын хэргийг хянан шийдвэрлэх боломжгүй;

106.6.5.энэ хуулийн 109.1-д заасан ажиллагаа явуулж байгаа.”

“106.13.Энэ хуулийн 106.6-д заасан түдгэлзүүлсэн үндэслэл арилсан бол илтгэгч гишүүн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээнэ.”

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 64 гишүүн оролцож, 55 гишүүн дэмжиж, 85.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

25.Төслийн 108 дугаар зүйлийн 108.3 дахь хэсгийн “баталгаажуулна” гэснийг “баталгаажуулах, эсхүл хуульд заасны дагуу цахим хэлбэрээр өгч болно” гэж өөрчлөх.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 64 гишүүн оролцож, 51 гишүүн дэмжиж, 79.7 хувийн саналаар санал дэмжигдэж байна.

26.Төслийн 116 дугаар зүйлийн 116.4 дэх хэсгийн “эсэргүүцлийг” гэсний дараа “танхим харгалзахгүйгээр” гэж нэмж, 116.7 дахь хэсгийн “татгалзлын

үндэслэл, шүүхэд гаргаж өгсөн нотлох баримтыг шинжлэх” гэснийг “татгалзлыг хянан үзэх” гэж өөрчлөх.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 64 гишүүн оролцож, 54 гишүүн дэмжиж, 84.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал.

1.Төслийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийн “оролцох,” гэсний дараа “тухайлсан” гэж, 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсгийн “цалин” гэсний дараа “хөлс” гэж, 107 дугаар зүйлийн 107.16.1 дэх заалтын “үүргээ” гэсний өмнө “албан” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.11 дэх хэсгийн “уламжилж, батлуулна” гэснийг “уламжилна” гэж, 12 дугаар зүйлийн 12.5, 12.6 дахь хэсгийн “хүн, хуулийн этгээдийн” гэснийг “байгууллага, хувь хүний” гэж, 15 дугаар зүйлийн 15.4, 15.5 дахь хэсгийн “түүнийг” гэснийг “түүний албан уургийг” гэж, “орлоно” гэснийг “орлон гүйцэтгэнэ” гэж, 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалтын “бүрэлдэхүүнд орох шүүгчийг” гэснийг “шүүгч гишүүнийг” гэж, 20.12 дахь хэсгийн “сонгох бөгөөд даргыг” гэснийг “сонгож, Комиссын даргыг” гэж, 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсгийн “ёсоор” гэснийг “бичгээр” гэж, 36.8 дахь хэсгийн “шүүгчид нэр дэвшээгүй” гэснийг “шүүгчийг сонгоогүй” гэж, 40 дүгээр зүйлийн 40.2.3 дахь заалтын “өөрийн хүсэлтээр энэ хуулийн 39.1-д зааснаас” гэснийг “Ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны гишүүнээр сонгогдсоноос” гэж, 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсгийн “аль нэг намаас” гэснийг “нам, эвслээс” гэж, 64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсгийн “системийн тусламжтайгаар” гэснийг “цахимаар эрэмбэлэн” гэж, 64.3 дахь хэсгийн “системд” гэснийг “цахимаар” гэж, 75 дугаар зүйлийн 75.1.1 дэх заалтын “нэгтгэн Засгийн газартай зөвшилцөн Улсын Их Хуралд уламжлах” гэснийг “энэ хуулийн 46.8-д заасан журмын дагуу хүргүүлэх” гэж, 78 дугаар зүйлийн 78.17 дахь хэсгийн “тогтоол” гэснийг “шийдвэр” гэж, 78.4.1 дэх заалтын “шаардлагыг” гэснийг “баримт бичгийн бүрдүүлбэрийг” гэж, 87 дугаар зүйлийн 87.1.3 дахь заалтын “хөдөлмөр, зохион байгуулалт,” гэснийг “хөдөлмөрийн” гэж, 104 дүгээр зүйлийн 104.1 дэх хэсгийн “Сахилгын зөрчил гарсан” гэснийг “Шүүгчийг сахилгын зөрчил гаргасан” гэж, 107 дугаар зүйлийн 107.10 дахь хэсгийн “баримт нотлох чадвараа алдах” гэснийг “баримтад тооцохгүй” гэж, 115 дугаар зүйлийн 115.4 дэх хэсгийн “шүүгчид” гэснийг “гишүүнд” гэж, төслийн “шүүгч биш гишүүн” гэснийг “шүүгч бус гишүүн” гэж тохиолдол бүрд өөрчлөх.

3.Төслийн 30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсгийн “ажиллах” гэснийг, 32 дугаар зүйлийн 32.2.1 дэх заалтын “өөрийн хүсэлтээр” гэснийг, 34 дүгээр зүйлийн 34.7.3 дахь заалт, 34.12 дахь хэсгийн “хөндлөнгийн” гэснийг, 57 дугаар зүйлийн 57.5 дахь хэсгийн “сургалтад суух” гэснийг, 45 дугаар зүйлийн 45.8 дахь хэсгийн “бүхий л” гэснийг, 73 дугаар зүйлийн 73.1.1 дэх заалтын “хангалтыг зохион байгуулах,” гэснийг, 74 дүгээр зүйлийн 74.1.1 дэх заалтын “тодорхой” гэснийг, 75 дугаар зүйлийн 75.2 дахь хэсгийн “байнгын болон нүүдэллэн ажиллах” гэснийг, 84 дүгээр зүйлийн 84.1.3 дахь заалтын “болон өөр ажил, албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 63 гишүүн оролцож, 52 гишүүн дэмжиж, 82.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй нэг санал байна. Дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томъёоллоор буюу Хууль зүйн байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

1.Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.2 дахь хэсэг нэмэх:

“4.2.Шүүх нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн тухай маргаантай асуудлыг болон Засгийн газрын улс төрийн шийдвэрийг хянан хэлэлцэхгүй.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж. Санал хураалт.

Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг угаасаа Үндсэн хуулийн цэц л шийдвэрлэнэ л дээ. Үндсэн хуулиараа.

Санал хураалтад 63 гишүүн оролцож, 51 гишүүн дэмжиж, 81.0 хувийн саналаар санал дэмжигдлээ. Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулиудын төслөөр санал хураалт явуулна.

Нэг.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн “олгохгүй.” гэж,” гэсний дараа “119 дүгээр зүйлийн 119.3 дахь хэсэг, 167 дугаар зүйлийн 167.4 дэх хэсгийн “7” гэснийг “14” гэж,” гэж нэмэх.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Б.Энхбаяр гишүүн ээ. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль дээр би гуравдагч этгээдээр оролцох нэхэмжлэлийн шаардлага үүсэх талаар нэг юм хэлж байсан юмсан. Тэрийг авч үзээгүй юм байна.

Санал хураалтад 63 гишүүн оролцож, 53 гишүүн дэмжиж, 84.1 хувийн саналаар энэ санал дэмжигдсэн байна.

Хоёр.Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх найруулгын санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн ““Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 59.1.5-т заасан үндэслэлээр огцруулсан, 59.6-д заасны дагуу огцорсонд тооцсон,” гэснийг “шүүгч Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан

огцруулах сахилгын шийтгэл хүлээсэн, эсхүл огцорсонд тооцогдсон,” гэж өөрчлөх.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 62 гишүүн оролцож, 53 гишүүн дэмжиж, 85.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гурав. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “тайлбар” гэснийг “мэдүүлэг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 62 гишүүн оролцож, 55 гишүүн дэмжиж, 88.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дөрөв.Монгол Улсын шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх саналын томъёолол.

1.Төслийн 7 дугаар зүйлийн “томилогдсон” гэсний дараа “шүүгчийн бүрэн эрхийг энэ хууль хөндөхгүй бөгөөд” гэж нэмэх.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 62 гишүүн оролцож, 56 гишүүн дэмжиж, 90.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 46.2-т заасан нэмэгдлийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгоно.”

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо.

Сайнбуянгийн Амарсайхан гишүүн үг хэлнэ.

С.Амарсайхан: Би энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн өөрчлөлт оруулах хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотой асуудлууд байгаа юм.

Энэ давж заалдах шатны шүүхийн шийдвэрт дараах үндэслэлээр оролцогч гомдол гаргаж болно гээд хоёр, гурван үндэслэл заачихсан байгаа юм. Тэгээд манай ажлын хэсгийнхний ярьж байгаагаар Дээд шүүхийн ачаалал буурна. Хяналтын шатанд очих хэрэг багасна гэж байгаа юм.

Гэтэл хүн бүхэн давах шатны шүүхээсээ эхлээд хяналтын шатанд хандана гээд бүгд л энэ хоёр гурван заалтыг дурдаад л гомдлоо гаргаж өгнө.

Тэгээд дээд шүүхийн ачааллыг бууруулах биш харин нэмэгдүүлэх ийм нөхцөл байдал үүсэж байгаа юм биш үү гэдэг асуудал бас өмнө нь ярьж байсныг Та бүхэн маань санаж байгаа байх.

Одоо өмнө нь хэрэг хүлээж аваад, одоо нэг шүүгч хүлээж аваад танхимын 5 гишүүнтэй хэлэлцээд шууд шийддэг байсан бол одоо эхлээд танхимаараа хэлэлцээд, хэрэг үүсэх, одоо хянах уу, үгүй юу гэдгээ шийднэ. Дахиад шийдсэний дараа танхимын 5 гишүүнээр хэлэлцэж шийдвэрлэнэ гээд энэ бүхэн дээр чинь гомдол гардаг. Дахиад Сахилгын хороо чинь Дээд шүүхийн шүүгчдийн гомдлоор дүүрсэн. Тэгээд хэрэг үүсэх, хянах уу, үгүй юу гэдэг дээр 4 шүүгчийн саналаар шийднэ гэж байгаа юм. Танхимын. Энэ нь эргээд нөгөө шүүгчдийг авлига, хээл хахуульд хардах, сэрдүүлэх нэгдүгээр асуудал.

Хоёрт, дахиад Дээд шүүхийн ачааллыг бүр хоёр, гурав дахин процесс нэмээд ингээд өмнөхөөсөө илүү ачаалалтай болж байгаа юм биш үү гэдэг ийм асуудал байгаад байгаа юм. Тэгээд энэ дээр Та бүхэн бас анхаараарай. Энэ чинь дахиад аягүй бол удахгүй дахиад энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсвэл үүнийг өөрчлөх гэдэг. Нөгөө Дээд шүүхийн ачааллыг бууруулах, хяналтын шатны хэрэг маргааны тоог багасгах гэдэг асуудал чинь бүр хүндэрч орж ирэх ийм эрсдэл бий шүү.

Тэгээд энэ дээрээ бас сайн анхаарч хандаж байгаа юм байгаа биз дээ гэдгийг хэлье гэсэн юм.

Г.Занданшатар: Дээд шүүхэд давж заалдах юуг нь хязгаарласан л даа.

Тэгэхдээ Үндсэн хуулийн 50.2-т Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байна. Тэгээд бусад шүүх, бусад этгээд дагаж заавал биелүүлнэ гэсэн нэг утгатай заалт байдаг нь бас л хүндрэл учруулж магадгүй.

Санал хураалт.

Санал хураалтад 62 гишүүн оролцож, 55 гишүүн дэмжиж, 88.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ чинь нэмэгдэл олгох тухай л заалт байсан.

3.Төслийн 12 дугаар зүйлийн "49.7 дахь" гэснийг "48.9 дэх" гэж өөрчлөх.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 62 гишүүн оролцож, 54 гишүүн дэмжиж, 87.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дугаар л өөрчлөгдөж байгаа санал юм.

4.Төсөлд доор дурдсан агуулгатай 15 дугаар зүйл нэмэх:

“15 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болж дагаж мөрдөхөөс өмнө Улсын дээд шүүхэд хяналтын журмаар гомдол, эсэргүүцэл гаргасан хэрэг, маргаанд Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 25.7.5 дахь заалт хамаарахгүй бөгөөд хэрэг, маргааныг Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/, энэхүү хуультай холбогдуулан баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө дагаж мөрдөж байсан хуулиар хянан шийдвэрлэнэ.”

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Үүний эцсийн редакцийг их сайн анхаараарай.

Санал хураалтад 61 гишүүн оролцож, 52 гишүүн дэмжиж, 85.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Төсөлд доор дурдсан агуулгатай 16 дугаар зүйл нэмэх:

“16 дугаар зүйл.2012 оны 3 дугаар сарын 07-ны өдөр баталсан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 23.2-т заасан бүх шатны шүүхийн шүүгчийн цалингийн нэмэгдэлтэй холбогдох заалтыг 2021 оны төсвийн жил дуусах хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 61 гишүүн оролцож, 54 гишүүн дэмжиж, 88.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

Дараагийн асуудалд орно.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Энэ хуулийг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жамъянхорлоогийн Сүхбаатар танилцуулна.

Ж.Сүхбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хурал өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2021 оны 01 дүгээр сарын 07, 08-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Шүүхийн ерөнхий зөвлөл болон Сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг Улсын Их Хурлаас нээлттэйгээр нэр дэвшүүлж, томилгооны сонсгол зохион байгуулж томилох, түүнчлэн Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн талаар Улсын Их Хуралд танилцах сонсгол зохион байгуулдаг байх санал дэмжигдсэнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан хэлэлцүүлсэн болно.

Байнгын хороо 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед гишүүдээс санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Б.Энхбаяр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасныг үндэслэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ж.Сүхбаатар гишүүнд баярлалаа.

Одоо Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна. Цахимаар алга байна. Тийм ээ.

Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 61 гишүүн оролцож, 43 гишүүн дэмжиж, 70.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах, бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

Дараагийн асуудалд орно.

Гурав.Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулан, анхны хэлэлцүүлэг/

Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Энэ бол Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан. Хэлэлцүүлгийн явцад дэмжсэн. Тэгээд үүнийг сонсголын хуульдаа оруулж шийдвэрлэх нь зүйтэй гэж Улсын Их Хурлын даргаас чиглэл өгсний дагуу боловсруулсан.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг танилцуулна.

Н.Алтанхуяг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 4 сарын 10-ны өдөр Улсын Их хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2021 оны 01 сарын 07, 08-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Шүүхийн ерөнхий зөвлөл болон Сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг Улсын Их Хурлаас нээлттэйгээр нэр дэвшүүлж, томилгооны сонсгол зохион байгуулж томилох, түүнчлэн Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн талаар Улсын Их Хуралд танилцах сонсгол зохион байгуулдаг байх санал дэмжигдсэнтэй холбогдуулан Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан хэлэлцүүлсэн болно.

Байнгын хороо 2021 оны 01 сарын 13-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед гишүүдээс санал гаргаагүй тул Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Б.Энхбаяр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасныг үндэслэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Г.Дамдинням гишүүнээр тасаллаа.

Ингээд эрхэм гишүүн Гонгорын Дамдинням асуулт асууна.

Г.Дамдинням: Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дээр хоёр асуулт байгаа юм.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа нийтийн сонсголын хууль болон одоо хэлэлцэж байгаа Шүүхийн ерөнхий зөвлөл болон Сахилгын хорооны шүүгч бус гишүүн Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн талаар томилгооны болон танилцах сонсгол хийх тухай нэмэлт оруулах төслийн аль алинд нь нэг нэг зохицуулалт орсон байгаад байгаа. Орхигдсон байгаа юм.

Ерөнхийлөгч Улсын дээд шүүхийн шүүгчийг томилохдоо, эсвэл Ерөнхийлөгчийн институцээс томилохдоо энэ ажлаас чөлөөлөгдөх өргөдлийг нь авч байгаад томилдог гэсэн асуудал яригдаад байгаа. Аягүй их асуулт орж ирж байгаа.

Тэгэхээр энэ дээр Дээд шүүхийн шүүгчийг бас энэ шүүхийн томилгоо, прокурорын томилгоо хийхдээ, шүүгчийг томилохдоо энэ мэт хууль бус тулгалт хийсэн эсэх болон өөр бусад хууль бус, шударга бус үйлдэл гаргасан эсэх талаар нийтийн сонсгол хийх боломж одоо энэ хуульд орж байгаа юу? Ажлын хэсэг энэ дээр судалж үзсэн үү? Өөрөөр хэлбэл төрийн өндөр албан тушаалтан, институцийн зүгээс ямар нэг орж ирсэн бол шалгаж болох уу? Энэ зохицуулалтын тухай асуудал байна.

Хоёрдугаарт, Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2-т Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно гээд ингээд заачихсан байдаг.

Үндсэн хуулийн энэхүү заалтыг илүү нарийвчилсан зохицуулалт болгон Нийтийн сонсголын тухай хуулийн 6.2.7 дахь заалт болгон оруулж ирсэн нь оновчтой болсон байгаа юм.

Гэхдээ өнгөрсөн намар банкны шүүгч орж ирээд баахан юм болсон шүү дээ. Тэгсэн чинь энд ямар асуудал гарсан бэ гэхээр Улсын Их Хурал танилцахгүй гээд ингээд гүрийгээд арай гэж нэг юм авч үлдсэн. Шалгуур хангаагүй хүн. Энд сууж байгаа Ц.Цогт шүүгчтэй цуг орж ирсэн шүү дээ.

Тэгэхээр энэ дээр танилцахаас татгалзах гэсэн ойлголт байгаа юу? Үүнийг нийтийн сонсгол дээр яаж оруулж ирсэн юм бэ? Тэгэхээр энэний хууль эрх зүйн асуудал.../минут дуусав/

Г.Занданшатар: Г.Дамдинням гишүүн нэмэлт 1 минут.

Г.Дамдинням: Тэгэхээр одоо энэ Нийтийн сонсголын тухай хуульд 6.2.7-д нь танилцах сонсгол гэж нэмсэн нь эх зүйн ямар үр дагавар үүсэх талаар ажлын хэсэг ер нь нэг тайлбар өгөөч.

Танилцахаас татгалзах нь яачхаад байгаа юм. Танилцах нь ямар өөрчлөлт орчихоод байгаа юм. Энэ дээр бас нэг жаахан ойлгомжгүй байгаад байгаа байхгүй юу. Үүнийг нэг тодорхой болгож өгөөч.

Г.Занданшатар: Б.Энхбаяр гишүүн хариулах уу? Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Нийтийн сонсголын тухай хууль үйлчилж байгаа. Нийтийн сонсголын хууль бол тухайн томилж байгаа албан тушаалтны хүрээнд хийгддэг.

Энэ танилцах сонсгол Улсын Их Хурал өөрөө томилоогүй, томилохгүй. Танилцаж байгаа сонсголын асуудал яригдаж байгаа юм. Энэ бол Монгол Улс Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг Улсын Их Хурал танилцдаг. Энэ процесс дэлгэрэнгүй хуульчлагдаагүйтэй холбоотойгоор Улсын дээд шүүхийн нэр дэвшигчид ямар хугацаанд танилцах юм. Танилцсанд тооцох юм уу, тооцохгүй юм уу.

Сая ойрмогхон болсон процесс Байнгын хороон дээр бүр танилцахгүй гэсэн шүү дээ. Тэгээд ер нь ийм танилцахгүй хүртэл байх эрхтэй юм уу, эрхгүй юм уу гээд ийм асуудал үүссэн.

Тийм учраас энэ асуудлыг бас тодорхой болгоод Үндсэн хуулийн хүрээнд танилцах сонсгол хийдэг байя. Тэр нь тухайн улсын дээд шүүхийн нэр дэвшигчдийг таних гээд байгаа, хэн бэ гэдгийг асуух гээд байгаа юм биш. Энэ

ард түмэндээ танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүд танилцах гээд байгаа биш. Улсын Их Хурлаар дамжуулж танилцуулъя.

Тэгэхгүй бол энэ Улсын дээд шүүхийн шүүгчдийг манай ард иргэд ер нь мэдэх үү? Мэдэхгүй шүү дээ. Өглөө ширээн дээр нь тавиад ингээд танилцсанд тооцлоо гээд л тэгээд Ерөнхийлөгч томилдог байсан. Ямар ч хүмүүс ажилладаг юм. Ямар ч түүх намтартай хүмүүс юм. Мэддэггүй шүү дээ.

Тэгээд энэ дэлхийн бусад орныг та бүхэн харж байгаа байх. Америкийн дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг одоо хэдэн сар хэлэлцэж байна. Парламентаар. Яагаад ингэж танилцах сонсголыг ийм дэлгэрэнгүй хийгээд байгаа гэхээр ард түмэндээ энэ ер нь ямар түүх намтартай, ямар үзэл бодолтой хүн бэ гэдгийг танилцуулах тийм л ажиллагаа хийгээд байгаа юм.

Тэгэхээр яг ийм шүүлтүүрээр оруулж ард иргэддээ энэ шүүх засаглалын оройд байгаа шүүгчдийг танилцуулдаг болъё гэж байгаа юм.

Г.Занданшатар: Болсон. Эрхэм гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн асуулт асуулна.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Тэгэхээр энэ хуулийн асуудал бол бас ялангуяа одоогийн энэ яригдаад байгаа Шүүхийн хуультай чинь нэлээн уялдана. Ялангуяа энэ үр дүнтэй байх уу гэдэг чинь их нөлөөлнө.

Бид бол их л гоё л тайлбар хийлээ шүү дээ. Тийм ээ. Гэтэл яг одоо тэр нөгөө Шүүхийн ерөнхий зөвлөл, Сахилгын хороо чинь Их Хуралд ирсний дараа түүгээр нь шилдэг улс орохгүй юм уу, сайн улсууд орохгүй ийм юм болоод эхэлбэл их хэцүү л юм. Ялангуяа нийгмийн сүлжээгээр яваад байна шүү дээ. Одоо улс төрийн хараат болох юм биш биз. Та нарын нураагаад байгаа хонгил чинь одоо тэр С.Баяр, С.Баярцогт, Д.Ганболд энэ тэрээр явсан хонгилыг нураагаад байгаа юм биш үү гээд ингээд хардалт яваад байна шүү дээ.

Манайхан чинь нэг шинэ хонгил нураана гээд байгаа юм. Тэр хонгилоор нь нөгөө нөхдүүд явсан юм шиг байгаа юм. Тэрийг нураана гээд байна гэж ингэж нийгэм ойлгож байгаа үед бид буруу томилгоо хийгээд энэ Үндсэн хуулийн цэцийг радио, телевиз шиг ийм байгууллагуудыг шүүх дээр Шүүхийн ерөнхий зөвлөл, тэгээд тэр Сахилгын хороон дээр хийх юм бол маш хэцүү юм болно шүү. Би тэр шүүхийн багц хууль орж ирж байхад хэлсэн шүү.

Ер нь яах вэ ингээд нэг шударга ёс гэдэг үгийг их ашигладаг болсон. Тэгчхээд бид шударга бус юм хийвэл маш муухай юм болно шүү. Тэгэхдээ үүнийг цаг хугацаа, амьдрал харуулна. Би олон юм яриагүй. Олон юм яриагүй. Тэгэхдээ энэ шүүлтүүрээр орно. Тийм учраас энэ чинь үнэн зөв байх уу гэдэг чинь шүүгчийн шударга болох уу, үгүй юу гэдэг чинь энэ олон нийтийн сонсголоо та нар яаж хийж, ямар шүүгч, ямар хууль ч томилсноос шалтгаална. Тэгэхээр амьдрал бол шүүгээд өгнө.

Тэгэхээр би зүгээр ингээд зарим нэг гишүүдэд хэлэхэд ер нь амьдралаар шүүгддэг юм шүү. Амьдрал шүүдэг юм шүү.

Г.Занданшатар: Сандангийн Бямбацогт гишүүн. Хууль зүйн байнгын хорооны дарга.

С.Бямбацогт: Тэгэхээр одоо яг ярьж байгаа энэ дээд шүүхийн шүүгчтэй танилцах сонсгол хийх асуудал маань бол арай өөр процесс явж байгаа.

Их Хурал дээр танилцах процесс явагдаад Ерөнхийлөгч батламжилна. Томилно. Дээд шүүхийн шүүгчийг.

Тэр Сахилгын хороо Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнийг Байнгын хороон дээр ажлын хэсэг байгуулаад, Их Хурлын даргаар захирамж гаргуулж. Тэнд Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын Их Хурал дахь олонх, цөөнх, Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо, Хууль зүйн их дээд сургууль гэх мэт байгууллагуудын төлөөлөл ороод ажлын хэсэг байгуулагдана.

Тэр ажлын хэсэг маань хэнээс ч хараат бус тал талаасаа цугласан ажлын хэсэг ажиллаад Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнийг болон Сахилгын хорооны гишүүнийг Хууль зүйн байнгын хороо, Их Хурал оруулж ирнэ. Томилох эсэх нь Их Хурлын гишүүд саналаа хурааж шийдэх юм. Ийм хоёр ялгаатай байгаа.

Тийм болохоор Нийтийн сонсголын тухай хуульд нөгөө “хууль тогтоох”, “ерөнхий хяналтын”, “төсвийн хяналтын”, “томилгооны”, “захиргааны хэм хэмжээний болон төлөвлөлтийн”, “орон нутгийн” гэсэн 6 төлөөлөл, сонсголын араас танилцах сонсгол хийнэ.

Танилцах сонсгол хийхтэй холбогдуулаад хуульд заасан бол бас сонсгол хийж болно. Энэ дээр тухайлах юм бол Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргын асуудал бас яригдана. Үндсэндээ энэ хуулиар зохицуулагдаад сонсгол хийх асуудал нь энэ хуульд туссан байгаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хороо Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Гишүүд бэлэн байна уу? Санал хураалт.

Санал хураалтад 62 гишүүн оролцож, 46 гишүүн дэмжиж, 74.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны саналыг, горимын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн нийт олонх дэмжсэн тул Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах, бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

Ер нь Парламентын хяналт шалгалтын тухай хуулиар мөрдөн шалгах **investigate public hearing** буюу мөрдөн шалгах, хяналт шалгалтын сонсгол нэмэгдэхээр төсөл боловсруулагдаж байгаа. Хууль зүйн байнгын хороон дээр.

“Танилцах сонсгол” гэж байхгүй байсан. Томилгооны, ерөнхий хяналтын, хууль тогтоомж боловсруулах, хууль тогтоомжийн зэрэг ийм 6 төрлийн нийтийн сонсголд “танилцах сонсгол” гэж байхгүй байсан юм. Тэгээд энэ бол өнөөдрийн хуулиар нэмэгдэж байгаа юм.

Ингээд Байнгын хороонд шилжүүлсэн. Ингээд 13.00 цаг болсон учраас өнөөдрийн чуулганы үдээс өмнөх хуралдаан завсарлаж байна.

14.00 цагаас “Хууль баталсантай холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Энэ бол бас Шүүхийн тухай хуультай холбогдуулан боловсруулсан төсөл байгаа. Яг 14.00 цагт үргэлжилнэ.

ЗАВСАРЛАГА

***Дөрөв. “Хууль баталсантай холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан/***

Г.Занданшатар: Үдээс хойшхи чуулганы үйл ажиллагаа эхэлснийг мэдэгдье.

Одоо бүртгэлийн санал хураалт явуулна. Үүний өмнө “Хууль баталсантай холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаа танилцуулна. Ш.Адьшаа гишүүнийг индэрт урьж байна.

Ш.Адьшаа: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 4 сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2021 оны 01 дүгээр сарын 07, 08-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын шүүхийн тухай хууль шинэчилсэн найруулгыг нэг мөр хэрэгжүүлэхээр Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д заасныг үндэслэн “Хууль баталсантай холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан.

Байнгын хороо 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаараа тогтоолын төслийг хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд “Хууль батлагдсантай холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний тухай”

Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан “Хууль баталсантай холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Содномын Чинзориг гишүүнээр тасаллаа. Эрхэм гишүүн Содномын Чинзориг.

С.Чинзориг: Байнгын хорооноос “Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолын төслийг дэмжиж байгаа юм.

Хууль батлахдаа бас шүүгчдийн цалин, нийгмийн хамгааллыг нь сайжруулах талаар анхны хэлэлцүүлгийн үеэр гишүүдийн гаргасан саналыг тусгаж, ялангуяа шүүгчдийн цалингийн хөлсний системийг Төрийн албаны хууль, Хөдөлмөрийн хуулиудтайгаа уялдуулж нэг голдрилд оруулж цэгцэлсэн ажлын хэсэгт талархаж байгаа юм.

Энэ хууль хэрэгжсэнээр шүүгчдийн цалин хөлс буурахгүй. Дунджаар 55 орчим хувийн удаан жилийн нэмэгдэл, онцгой нөхцөлийн нэмэгдэл нийлээд авахаар болж байгаа юм. Энэ нэмэгдлүүд авахтай холбогдуулаад 5-аас дээш жил ажилласан шүүгчид жил тутам 2 хувийн цалингийн нэмэгдэл олгогддог байсан. Тэгэхээр энэ 2 үеийн нэмэгдэл нь ирэх оноос байхгүй болоод удаан жил, онцгой нөхцөлийн нэмэгдэл аваад эхэлнэ.

Тэгэхлээр 25-аас дээш юм уу, 30-аас дээш жил ажилласан шүүгч дээр шүүгчдийн өөрсдийнх нь гаргаж байгаа судалгаагаар 8 орчим хүн дээр л цалингийн жаахан бага хэмжээний бууралт үүсэж магадгүй гэсэн ийм асуудал байгаа юм.

Тэгэхээр энэ асуудлыг Хууль зүйн байнгын хороо судалж үзсэн үү? Хэрвээ шаардлагатай бол тэр цөөн хүний цалинг энэ тогтоолын төсөлдөө оруулаад цалинг нь хүрсэн түвшингөөс нь бууруулахгүй байх арга хэмжээ авахыг чиглэл болгосон, даалгасан тийм заалтууд оруулаад явчих юм бол бас илүү оновчтой болох болов уу гэсэн ийм нэг саналтай байгаа юм.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Сандагийн Бямбацогт. Хууль зүйн байнгын хороон дарга асуултад хариулна.

С.Бямбацогт: С.Чинзориг гишүүн асуултад хариулъя.

Ер нь ажлын хэсэг ажиллаад Байнгын хороон дээр хэлэлцүүлэг хийгээд чуулганд хэлэлцэж байх явцад шүүгч нарын цалинг ажлын хэсэг дээр ихээхэн хэмжээгээр нэмэгдэж байгаа юм шиг, нэмж байгаа юм шиг ойлголт төрөөд. Түүнтэй холбоотойгоор ажлын хэсэгт орсон зарим саналууд унасан. Үүнтэй холбогдуулж эцсийн хэлэлцүүлэг хийх явцад шүүгч нарын цалингийн асуудлыг өчигдөр бид хэлэлцсэн.

Тэгээд онцгой нөхцөлийн нэмэгдэл, ажилласан жилийн нэмэгдэл, дээрээс нь докторын зэргийг нэмэгдсэн гурван нэмэгдэл авахаар болж байгаа.

Яг ингээд үзэхээр анхан шатны шүүхэд ажиллаж байгаа шүүгч нар, цөөхөн шүүгч нарын цалин нэмэгдэж байгаа. Бусдаар шүүгчийн цалин нэмэгдэхгүй байгаа.

Харин олон жил ажилласан, анхан болон давах, мөн хяналтын шатанд ажиллаж байгаа цөөн, одоо 12, 13 шүүгчийн цалин буурахаар болчихоод байгаа юм. Тийм болохоор үндсэндээ ажилтан, албан хаагчдын эрх зүйн байдлыг дордуулсан ийм асуудал хөндөгдөөд байгаа учраас үүнийг бид яг энэ хууль баталсантай холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоолоор улсын төсөвт тодорхой асуудлыг шийдэхээр орж ирж байгаа.

Төсвөө шинэ хуулиар Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Хууль зүйн байнгын хороонд хянуулаад Хууль зүйн байнгын хороо Засгийн газарт явуулаад Засгийн газар нэгтгээд Их Хуралд өргөн барихаар ийм зохицуулалттай болж байгаа.

Урьд нь шууд Сангийн яаман дээр очоод хасагддаг байсан бол одоо энэ бол өөрчлөгдөж байгаа.

Үүнтэй холбоотойгоор бид 2022 оны 01 сарын 01-нээс энэ шүүгч нарын цалингийн асуудал, нэмэгдлийн асуудал, мөн төсвийн асуудал ярьж эхэлнэ. Энэ үедээ шүүгч нарын цөөн, одоо сая ярьж байгаа 12 шүүгчийн цалин хасагдаж байгаа. 12, 13 шүүгчийн. Үүнийг шийдэх боломжтой гэж үзэж байгаа. Ийм байдлаар зохицуулах бололцоо, боломжийг бүрдүүлж Хууль зүйн байнгын хороо, Улсын Их Хурал ажиллах бололцоотой гэж үзэж байгаа.

Тийм болохоор яг санаа зовж байгаа энэ шүүгч нарын асуудлыг анхаарах ёстой асуудал. Энэ дээр манай Шүүхийн ерөнхий зөвлөл Л.Атарцэцэг гуай нэмээд хариулчихгүй юу. Та.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн асуулт асууна. Түүний дараа Л.Атарцэцэг. Шүүхийн ерөнхий зөвлөлийн Лхүндэвийн Атарцэцэг.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Би Шүүхийн ерөнхий зөвлөлөөс асууна.

Миний асуух асуулт өглөө бас асуусан юм. Тэгээд цаг багтаагүй юм. Хариулт өгөөгүй юм. Нөгөө 13 шүүгчийн асуудал байгаа юм.

Тэгээд Шүүхийн ерөнхий зөвлөл энэ хүмүүсийг яагаад ер нь оруулж ирдэггүй юм бэ? Дахиад. Томилдог субъект нь өөрчлөгдсөний дараа ч гэсэн энэ асуудлыг судалж үзээд Шүүхийн ерөнхий зөвлөл оруулах боломж байсан шүү дээ. Тэгээд яагаад энэ нь оруулж ирдэггүй юм. Эсвэл ямар нэгэн шалтгаан байна уу?

Б.Энхбаяр гишүүн нарын тайлбарлаж байгаагаар шалтгаан байхгүй. Хуульд буцаах үндэслэлгүй байхад нь л томилогдоогүй л гээд байгаа шүү дээ. Чөлөөлөгдөөд.

Тэгээд энэ нь шүүгчдийн талаар ер нь Шүүхийн ерөнхий зөвлөл ямар байр суурьтай байдаг юм. Цаашдаа манайх судалж үзээд шүүгч нарынхаа хүрээнд авч үзээд оруулж ирнэ гэвэл заавал тогтоол хуульд тусгахгүйгээр шийдээд уг нь явчихмаар байгаа юм л даа.

Г.Занданшатар: Лхүндэвийн Атарцэцэг. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн. 93 дугаар микрофон.

Л.Атарцэцэг: Баярлалаа. С.Бямбацогт гишүүний хэлсэн дээр нэг жаахан зүйл тодруулаад хэлчихье.

Үнэхээр одоогийн авч байгаа нэмэгдэлтэйгээ нийлээд цалинг нь бууруулахгүй гэдэг асуудал дээр нийлбэрээрээ. Одоо авч байгаа цалинг нь бууруулахгүй гэдэг тоон дээр бид тооцоо хийгээд 40 хувь гэдэг дээр гарахаар тодорхой хэмжээний шүүгчдийн цалин буурна гэдэг дээр бид Байнгын хороон дээр саналаа хэлсэн. Ингээд үүнийг хүлээж авч бас нааштайгаар шийдэх боломжийг гаргаж байгаад би бас өөрөө баяртай байна.

Дараагийн асуудал бол Т.Аюурсайхан гишүүний өглөөний тэр 6.5 сая төгрөг авдаг шүүгч Монголд байхгүй. Юуг үндэслэж яриад байна гэхээр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2 хувийн нэмэгдэл жил болгон авна гэдэг дээр нөгөө өөрсдөө ингээд барьж цалинг нь олгодог ийм нэг хүснэгт байдаг юм. Энэ 6.5 сая төгрөгийн цалинг ямар шүүгч авах вэ гэхээр ирээдүйд шүүгчээр 40 жил ажилласан шүүгч 5 жил тутам 2 хувийн нэмэгдэл авах юм бол 6.5 байна гээд 1-ээс 40 жил хүртэлх шүүгчийнхээ цалинг ингээд жагсаасан энэ жагсаалтыг үндэслэж гаргасан тоо юм шүү.

Өнөөдөр Монгол Улсад хамгийн олон жил ажиллаж байгаа шүүгч ганц хоёрхон шүүгч 35 жил байна. Энэ 35 жил ажилладаг шүүгч нар энэ 6.5 сая төгрөгийн цалин авдаггүй юм. Ямар хэмжээний цалин авдаг вэ гэдэг одоо урьд нь зөндөө яригдсан асуудал.

Дараагийн асуудал энэ 13 шүүгчийн асуудал бас энд сөхөгдөж яригдаж байгаад их зүйтэй асуудлаа. Ямар асуудал болоод өрнөсөн гэхээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоолоор тухайн үед 13 шүүгчийн нэрсийг орхигдуулалгүйгээр өргөн барьсан юм. Уг нь.

Ингээд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс энэ 13 шүүгчийн тухайд зарлигуудыг бүх шатны шүүхийн шүүгчийг чөлөөлөөд дахиж томилохдоо энэ 13 шүүгчийг үлдээсэн.

Ер нь Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд байдгаар Шүүхийн ерөнхий зөвлөлд томилогдоогүй томилоогүй шалтгааныг бидэнд тайлбарладаггүй учраас энэ чигээрээ энэ асуудал ингэж өнгөрөөд, шүүгчид маань шүүхэд Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоолтой холбогдуулж гомдол гаргасан.

Энэ гомдлыг Шүүхийн ерөнхий зөвлөл өөрсдийнхөө бүрэн эрхийн хүрээнд өргөн барьсан байна гэдэг асуудлаар энэ тогтоол бол өргөн барьсан тогтоол нь хүчинтэй байгаа. 2019 оны 11 сараас Шүүхийн ерөнхий зөвлөл.../минут дуусав/

Г.Занданшатар: Ер нь сая Д.Тогтохсүрэн даргын асуусан нөгөө нэг 13 шүүгчийн асуудлыг хариулахгүй өөр юм ярьсаар байгаад таарлаа л даа. Нөгөө цалин нэмэгдэлтэй холбоотой.

13 шүүгчтэй холбоотой асуудлаа хариул. 93. 1 минутад.

Л.Атарцэцэг: Ингээд үргэлжлүүлээд 13 шүүгчийн асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөл 2019 оны 11 сарын 01-нээс шинэ бүрэлдэхүүнтэй ажилласан. Дахиж энэ 13 шүүгчийн асуудлаар шүүгчдээс маань хандаагүй Шүүхийн ерөнхий зөвлөлөөс дахиж өргөн бариагүй.

Ер нь зүгээр барьж байгаа чиг нь болохоор нэгэнт өргөн барьсан тогтоол маань хүчинтэй байгаа учраас бид нарт одоо нэг тийм нөгөө юу нь байхгүй. Дахиж өргөн барих одоо тийм үндэслэл байхгүй байна гэдгээр одоогийн энэ асуудлууд ингээд шийдвэрлэгдээгүй яваад байгаа юм.

Г.Занданшатар: Ер нь энэ нэмэгдэл, урамшуулал, 36 сарын нэмэгдэл энэ тэртэй уялдуулаад хэлэхэд Германы Төрийн албаны сахилгын тухай хууль гэж бий. Тэр хуульд сахилгын шийтгэл оногдуулсан бол 36 сарын тэтгэвэрт тогтоох, 36 сарын цалин өгдөггүй. Тэрийг нь хасдаг. Энэ нэмэгдлүүдийг хасдаг.

Анхан шатны сануулгууд хууль хэрэглээний мэргэжлийн алдаануудыг шууд сахилгын зөрчил гэж үзэхээс илүү мэргэжлийн алдаа гаргасан тохиолдолд тэр нэмэгдэл 55 байна уу, 40 хувиар онцгой нөхцөлийн нэмэгдэл энэ тэр бол хасагддаг ийм сахилгын анхан шатны шийтгэлүүд байдаг юм билээ. Үүнийг хуулийн практикт хэрэглэж болж магадгүй.

Ингээд Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууна. Үүний дараа санал хураалт явна.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая.

Сонсогдож байгаа болов уу?

Г.Занданшатар: Сонсож байна.

Б.Жаргалмаа: Сая шүүгчийн асуудал дээр бас асуулт байсан. Сая хариулчихлаа.

Би нэг зүйлийг тодруулах гэсэн юм. Энэ нөгөөдөх шүүх хурал нээлттэй байна гэдэг ийм зүйл, заалт байгаа. Олон нийтэд нээлттэй байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр шийдвэр нээлттэй байхаас гадна шүүх хуралдаан нээлттэй байна гэдэг энэ заалт.

Хэрвээ ямар нэгэн байдлаар тухайн иргэн өөрөө холбогдогч этгээд санал гаргах юм бол тэр хууль шүүхийн хуралдааныг хаалттай явуулах тийм заалт энэ хуульд байгаа болов уу?

Ер нь нөгөө нүүрсний хэргээр Б.Мөнгөнтуяа гээд эдийн засагчтай холбоотой шүүх хуралдааны нээлттэй явснаар олон нийт зөв мэдээллийг авсан. Шүүх шударга явагддаг юм байна гэдгийг олон нийт мэдэж авсан. Яг энэ жишгээр нээлттэй явуулах тэр зарчим, хатуу заалттай зохицуулалт байгаа болов уу?

Хэрвээ тухайн хэрэгт холбогдогч этгээд шүүх хурлыг нээлттэй явуулах хүсэлтгүй байна гэдэг ийм хүсэлт гаргавал хаалттай явуулах тэр заалттайгаа болов уу? Би жаахан өөр хөндлөн асуулт асуучхав уу, үгүй юу? 13-аас гадна ийм хоёр асуулт байсан юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Одоо хууль баталсантай холбогдуулан “Хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж байна. Шүүхийн тухай хуулийн хэлэлцүүлэг дууссан.

Тэгэхээр яг хэрэгжүүлэх арга хэмжээний хувьд нээлттэй, хаалттай болох тал дээр техник, технологийн талаас нь шийдлүүд ямар байх юм бэ. Одоо цахим ч гэдэг юм уу. Тэр талаас л хариулж болох байх. Тэр хэрэгжүүлэх талаас нь. Ажлын хэсэг. 83. Барсүрэнгийн Баасандорж дарга хариулчих уу?

Б.Баасандорж: Б.Жаргалмаа гишүүний асуултад хариулъя.

Чухал асуулт асууж байна. Энэ Шүүхийн тухай хуулийн нэг шинэлэг зохицуулалт бол энэ хуулийн төсөлд шүүхийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгохтой холбоотой шинэлэг заалтууд орсон байгаа. Нэлээдгүй туссан. Тухайлбал, хуулиар хамгаалагдсан төрийн болон албаны хувь хүний, хуулийн этгээдийн нууцад хамаарахаас бусад шүүх хуралдааныг цахимаар болон телевизээр дамжуулах зохицуулалтыг тусгаж өгсөн.

Хуулийн 12.6-д яг саяын зохицуулалт орсон байгаа. Энэ хувь хүний нууцад хамаарахаас бусад тохиолдолд шүүх хуралдааныг цахимаар болон телевизээр нэвтрүүлж болох бөгөөд холбогдох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална гээд хууль батлагдаж байгаа. Ийм зохицуулалт байгаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

“Хууль баталсантай холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлдээрэй. Санал хураалт.

Санал хураалтад 63 гишүүн оролцож, 35 гишүүн дэмжиж, 55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дараагийн асуудалд орно.

Тав. “Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан/

“Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Энэ бол Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан.

Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр танилцуулна.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын эрхэм дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2021 оны 01 дүгээр сарын 07, 08-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шүүгчид, докторын, төрийн алба хаасан хугацааны, онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох санал дэмжигдсэнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93, 94 дүгээр зүйлд заасан журмыг баримтлан шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан хэлэлцүүллээ.

Байнгын хороо 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд “Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан “Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Д.Тогтохсүрэн гишүүнээр тасаллаа. Салдангийн Одонтуяа гишүүн орсон. Ингээд 2 гишүүнээр. Цахимаар алга байна.

Эрхэм гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн асуулт асууна.

Д.Тогтохсүрэн: Асуулт, санал хамт юм байна гэж ойлгосон.

Тэгэхээр уг нь үүний өмнөх тогтоол дээр л миний энэ санал орох л ёстой байсан санал байгаа юм.

Ер нь шүүгчдийн ачаалал их байна гэж яриад байгаа юм. Тэгээд бид цалинг нь нэмээд шүүгчдийн ачааллыг шийдэж чадахгүй л дээ. Тэгэхийн тулд орон тоо нэмэгдүүлэх хэрэгтэй байгаад байгаа юм.

Шинэ хуулийн үзэл баримтлал, концепцоор давахын шүүхийн ачаалал эрс нэмэгдэж байгаа. Дээд шүүхийн ачаалал буурч, давахын шүүхийн ачаалал нэмэгдэж байгаа.

Тийм учраас би нийслэл, дүүрэгт эрүү, иргэний ачаалал их өндөр байна гэж манайхан яриад байгаа юм. Судлаачид ч тэгж гаргасан байна лээ.

Тэгэхээр нийслэлийн дүүрэг, нийслэлийн давахын шүүх, нийслэлийн дүүргийн шүүхүүдийн орон тоог нэмэх хэрэгтэй болчихсон юм билээ. Нэг хүнд тохирох норм, нормативыг гаргаад тэгээд энэ шүүхийнхээ орон тооныг цэгцэлж, 2022 оны төсөв хэлэлцэх үеэр үүнийг нэг шийдчихмээр байгаа юм. Их Хурал.

Тэгэхгүй бол бид хэдэн шүүгчийн цалин нэмээд үүнийг шийдэж чадахгүй байгаа юм. Ачаалал өндөр байна гэдэг бол эрсдэл бий болж байгаа юм. Хувь хүнд. Тийм учраас тохирсон ачаалалтай байх асуудал чухал.

Иймээс би 2022 оны улсын төсвийг батлах үед нь Их Хурал ч гэсэн, манай Хууль зүйн байнгын хороо, Засгийн газар, Хууль зүйн яам, Сангийн яам ч гэсэн анхаараад шүүгчдийн орон тоог нэмэх асуудал дээр их онцгой анхаарах хэрэгтэй юм гэж би бодоод байгаа юм.

Тэгээд энэ хүрээнд нь би түрүүн хэлдэг санал нь энэ хүрээнд нь 2022 оноос тэр нөгөө 13 шүүгчийн асуудлыг ч гэсэн Шүүхийн ерөнхий зөвлөл хамт авч үзээд шийдээд явчих хэрэгтэй байгаа юм. Ингэж гарц гаргаж өгөхгүй л бол би болохгүй юм байна гэж бодоод байгаа. Энэ бол миний санал явж байгаа юм шүү гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Хууль зүйн байнгын хороон дарга Сандагийн Бямбацогт асуултад хариулна.

С.Бямбацогт: Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргасан судалгаа байдаг юм билээ.

Тэгээд түүгээр шүүгч нарын ачааллыг анхан шат, давах, дунд, хяналтын шатандаа ямархуу ачаалалтай байна гэдэг дээр хийсэн судалгаагаар ер нь яах вэ иргэний хэрэг дээр харьцангуй ачаалал өндөртэй байдаг юм байна. Дээд шүүх дээр харьцангуй ачаалал өндөртэй байдаг юм байна гэсэн судалгаанууд хийгдсэн байдаг.

Дээд шүүхтэй холбоотойгоор сая Шүүхийн тухай хуулиар харьцангуй ачаалал буурах бололцоотой болж байгаа. Онолын шүүх. Тодорхой гуравхан заалтаар л хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ийм асуудал орж байгаа. Ачаалал нэлээн буурна.

Бусад шүүхүүд дээр таны ярьж байгаа асуудлыг бид яг энэ хуулиар зохицуулж чадаагүй. Гэхдээ Шүүх байгуулах тухай хууль бас энэ хавар батална. Энэ үедээ дагнасан болон тойргийн шүүх гээд асуудлууд яригдана. Энэ үедээ тодорхой судалгаа, тооцоонууд хийгдэж Засгийн газраас, Шүүхийн зөвлөлөөс орж ирэх байх. Энэ үедээ бас ярилцаад шийдэх бололцоотой болов уу гэж бодож байгаа.

Шүүгч нарын асуудал дээр Үндсэн хуульд орсон нөгөө шүүхийн эдийн засгийн баталгааг төр хангана гэсэн үүрэгтэй. Энэ дагуудаа Засгийн газарт, Улсын Их Хуралд тодорхой үүрэг ногдож байгаа. Шүүхийн байртай холбоотой, ажиллах орчин, нөхцөлтэй холбоотой асуудлуудыг шийдэх.

Ер нь судалгаагаар сүүлийн арваад жил ер нь шүүхийн төсөв ерөөсөө нэмэгдэж байгаагүй. Хөрөнгө оруулалт хийгдэж байгаа гэсэн тийм асуудал яригддаг. Тийм болохоор бас энэ дээр ч гэсэн энэ тогтоолыг дагаад саяын эдийн засгийн баталгаа, ажиллах орчин нөхцөлийн асуудлыг давхар шийдэхээр тогтоол тусгагдсан байгаа.

Мөн цалин хөлстэй холбоотой асуудал дээр түрүүн хэлсэн. Ерөөсөө ерөөсөө цалин бол нэмэгдэхгүй байгаа шүү. Үүнийг бас сайн ойлгомоор байгаа юм. Гэхдээ 2022 оны 01 сарын 01-н хүртэл одоо авч байгаа цалингаа авна. Сая дахин давтан хэлэхэд тэр 12 шүүгчийн асуудлыг бид 2021 ондоо цалин буурахгүй. Тэрнээс 2022 оны 01 сарын 01-нээс өмнө бас бууруулахгүй байхаар зохицуулах боломжийг гаргах тал дээр анхаарч Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтарч ажиллана.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Сайнбуянгийн Амарсайхан цахимаар асуулт асууна.

С.Амарсайхан: Би асуулт байсан. Сая үндсэндээ давхацчихлаа. Зүгээр санал байна.

Энэ шүүгчдийн цалинтай холбоотой маргаан дагуулаад байгаа асуудлыг манай холбогдох албаныхан ер нь нэг мөр болгож маш тодорхой ярихгүй бол ойлголтын зөрүү байсаар байна шүү. Нэгдүгээрт нь.

Хоёрдугаарт, шүүгчид үндсэндээ доод тал нь 2 сая 100 мянга, дээд тал нь 4 сая 500 мянган төгрөгийн цалинг татвар хураамжийн дараа гар дээрээ авдаг ийм хэм хэмжээ байгаа юм билээ.

Тэгээд бид үнэхээр шударга ёсыг бий болгоё. Дээрээс нь хүсээд байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангая. Шүүхийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй, хараат бус болгоё гэвэл энэ цалин дээр наана цаана гэх асуудал ярих шаардлагагүй гэж бодож байгаа. Энэ хүмүүс чинь ахуйн асуудлаа шийдэхгүйгээр, амьдралынхаа асуудлыг шийдэхгүйгээр, тэгээд авдаг хэд нь ахуйдаа хүрэхгүй бол хэнээс ямар шударга ёс бид нэхээд, хаанаас тэрийг гаргаж ирэх вэ гэдэг чинь өөрөө эргэлзээтэй асуулт. Бүр цаашлах юм бол зөвхөн шүүгчдийн асуудал ч биш. Ер нь үндэсний хэмжээнд бүх салбарын ажилтан, албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх, амьжиргааных нь түвшинг дээшлүүлэх энэ тал дээр хүртэл бид ер нь явцын дунд анхаарах ёстой гэж бодож байгаа.

Одоо энэ 600 мянган төгрөгийн цалин аваад ажиллаж байгаа төрийн албан хаагчаас бид хариуцлага нэхээд, өөрийгөө хөгжүүлэх, чадавхжуулах, хүний нөөцийн чадавх, ажлын хариуцлага, мэргэжлийн ур чадвар нэхээд ямар ч нэмэр байхгүй шүү дээ.

Ялангуяа тэр шүүгчдийн уг нь бол бид тэтгэврийг бас 80 хувиар нь тооцож олгох нь зүйтэй гэж бодож байгаа. Бид өнөөдрөөрөө асуудлыг харж ерөөсөө болохгүй юм байгаа юм. Энэ инфляц бусад амьжиргааны зардал энэ тэр гээд зөндөө олон асуудлууд бий. Насаараа ажиллаж ажиллачхаад 60, 65-тай тэтгэвэрт гардаг. Тэгээд тэтгэврээ эдэлж чадахгүй байгаад өвчинд нэрвэгдээд үндсэндээ 70, 80 хүрэхгүй ингээд л хорвоог орхиж байгаа тохиолдол манай улсад түгээмэл байна шүү дээ.

Тийм учраас хүн хөдөлмөрлөсөн бол.../минут дуусав/

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: С.Амарсайхан гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр үнэхээр бид хууль гаргах бол нэг хэрэг. Үүнийг хүн хэрэгжүүлнэ. Мөн шүүхийн эдийн засаг, нийгмийн баталгааг ганцхан шүүгч нарын цалинтай холбохоос гадна энэ системийн хэмжээнд нь авч үзэх чиглэлээр Улсын Их Хурал маань Шүүхийн хуулийг дагалдуулж тогтоол гаргаж байгаад их баяртай байна. Дэмжиж.

Дөнгөж сая үүний өмнөх санал хураалтаар их чухал ач холбогдолтой тогтоол гаргалаа. Энэ нь юу вэ гэхээр ер нь шүүхийн үйлчилгээний байруудыг 5 жилийн дотор засан тохижуулж шийдвэрлэх чиглэлээр Засгийн газарт үүрэг өгч байна.

Өнөөдөр гар дээрээ 700 мянган төгрөг авч байгаа шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга нарын цалинг хоёр дахин нэмэх чиглэлийг өгч байна. Мөн сая гишүүд бас ярьж байна. Д.Тогтохсүрэн дарга бас хэлж байна.

Энэ Шүүхийн тухайн хуулийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай нэмэлт санхүүжилтийн асуудлыг ер нь шийдэх ёстой шүү гэж.

Бүхэлдээ Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газраас энэ шүүх эрх мэдэл гэдгийг жинхэнэ утгаар нь Үндсэн хуулийн тэр бусад эрх мэдэлдээ хяналт тавьж байдаг хөндлөнгийн ийм салаа мөчир юм гэдэг утгаар нь тэр эдийн засгийн, нийгмийн тэр бие даасан байх тэр нөхцөл дээр үнэхээрийн бодитой алхам боллоо. Шийдэж байна гэж ингэж ойлгож байна.

Нөгөө талаараа энэ юу хамт очиж байна вэ гэхээр шүүгч нар дээр ихээхэн хэмжээний хариуцлага, ачааг үүрүүлэх гэж байгаа. Хариуцлагыг бас нэхнэ. Үндсэн хуулийн өөрчлөлтийн дагуу энэ хуулийн дагуу байгуулагдах Сахилгын хороо бол жинхэнэ утгаараа энэ хуулийн дагуу хариуцлагыг нэхнэ. Ард иргэд маань нэхнэ.

Түрүүн Ц.Мөнх-Оргил гишүүн маш тодорхой хэлсэн. Хүлээлт их байгаа. Тэгэхээр үүнийг хангаж ажиллах тал дээр шүүгч нар маань итгэл дааж ажиллаарай гэж.../минут дуусав/

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Салдангийн Одонтуяа.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ журмыг дэмжиж байгаа.

Сая хэдэн сар л бид энэ Шүүхийн тухай хууль ярихад шүүгчдийг авлига авдаг, хараат байдаг. Тэгээд л бүх л талаар нэлээд л шүүмжиллээ шүү дээ. Гэтэл яг энэ хараат байлгадаг, авлига өгдөг, эвддэг хүмүүс чинь бол яг энэ хууль тогтоогчид хуулиа мөрдөхгүй улс төрчид их байдаг.

Тэгэхээр одоо энэ Шүүхийн тухай хууль батлагдсанаар асуудлууд нэлээд жигдэрч сайжрах байх гэж бодож байна.

Нөгөө талаас энэ шүүгчдийн ачаалал дэндүү өндөр байгаа. Үүнийг бид анхаарах ёстой. Тэгээд энэ журмын тухай хуульд шүүгчээс гадна бас туслах шүүгч орж байгаа байх гэж би найдаж байна. Үүнийг бас нэмээд хэлээд өгөөрэй. Жишээлэхэд, би нэг ийм тооцоо авлаа л даа. Яаманд жилд дунджаар 1000-аас 1200 албан бичиг гардаг гэж байна. Төрийн нарийн бичгийн даргын тушаал. Гэтэл яаманд 80-аас 120 мэргэжилтэн энэ дээр ажилладаг. Гэтэл анхан шатны шүүгч нь жилд дунджаар 800 албан бичиг, 600 захирамж, 60 гүйцэтгэх хуудас, 70 шийдвэр, 200 тэмдэглэл, 30 үзлэг, бүрэлдэхүүнтэй шийдвэр 15 гээд нийт 1800 эрх зүйн актыг туслахтайгаа, нарийн бичгийн даргатай хамт гаргадаг юм байна. Энэ бол асар өндөр ачаалал байхгүй юу. Нэг шүүгч бараг төрийн захиргааны 20 албан хаагчийн ажлыг хийж байна гэсэн үг.

Тэгэхээр бид энэ ачааллыг нь тэнцүүлэх, орон тоог нь нэмэх, тэр ажиллах нөхцөлөөр хангах энэ асуудал дээр Улсын Их Хурал, Засгийн газар анхаарч ажиллах нь зүйтэй байх гэж бодож байна. Тэгээд шүүгчид маань бас хараат бус байгаад хууль дүрмээ мөрдөөд, ажиллах нөхцөл нь бас хэвийн байх юм бол Монгол Улсад цаашдаа энэ шүүх засаглалын асуудал бол.../минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

“Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья.

Санал хураалтад 64 гишүүн оролцож, 40 гишүүн дэмжиж, 62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тогтоолын төсөл батлагдлаа.

Тэгэхээр энд нэг ийм асуудал. Одоо ингээд Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг хийгдэж байна.

Тэгээд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг маргааш явуулахаар Хууль зүйн байнгын хороо бэлтгэл хийж редакцийг бүгдийг нь уншиж нарийвчлах ёстой. Тэгээд амжих уу. Маргаашдаа үүнийг маш сайн хянуур хийх хэрэгтэй байна.

Ер нь хууль эцэслэн батлахад дагаж мөрдөх журмын тухай хуулиудыг батлах шаардлагатай болно. Энэ хуулийн тогтоол, хэрэгжих хугацаа энэ тэр асуудлууд бас анхаарах юмнууд их байгаа шүү.

Тэгээд энэ том хууль эцэслэн батлагдах гэж байгаатай холбогдуулаад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр санал хэлье гэсэн. Санал гаргая гэсэн.

Б.Энхбаяр: Баярлалаа дарга аа.

Одоо ингээд Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг ингээд эцсийн хэлэлцүүлэг хийлээ. Мөн үүнийг дагалдуулаад хамт өргөн мэдүүлсэн хуулиудын эцсийн хэлэлцүүлгийг хийсэн.

Үүнтэй хамт сая Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар эцсийн хэлэлцүүлэг хийсэн юм.

Тэгээд энэ Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 44.5-д зааснаар Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль, тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоол, уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг энэ хуулийн 39, 40, 41, 42, 43, 44 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцэн баталж болно гэж заасан байгаа юм.

Энэ хүрээнд сая эцсийн хэлэлцүүлгийг нь хийсэн Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль дээр дагаж мөрдөх, энэ Иргэний процессын хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг бас нэмж хэлэлцэх, оруулах ийм шаардлага бас үүсээд байгаа юм.

Тийм учраас Та чиглэл өгөөд Хууль зүйн байнгын хороог хуралдуулаад. Тэгээд Дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг бас яаралтай оруулж ирэх ийм шаардлага бас байна. Эцсийн хэлэлцүүлгийг. Нөгөө ёслон батлахаас өмнө ийм шаардлага байна. Дарга аа.

Г.Занданшатар: Ойлголоо. Ажлын хэсгийн саналыг харгалзан үзээд Хууль зүйн байнгын хороо Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн сая дурдсан 44.5-д заасны дагуу Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл Хууль, тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоол. Уг хуулийг Дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг энэ хуулийн 39, 40, 41, 42, 43, 44 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцэн баталж болно гэж заасан.

Тэгэхээр Дагаж мөрдөх журмын тухай хуулиудыг, тэр дотроо онцлоод Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг Хууль зүйн байнгын хороо хэлэлцэн оруулж ирэхийг чиглэл болгож байна.

Дараагийн асуудалд орно. Хууль зүйн байнгын хорооны хурлыг чуулганы хуралдааны дараа хийчих. Тэр хооронд наадах чинь төслөө боловсруулах хэрэг гарна. Төслүүд дээрээ ажиллаж бай.